

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2022 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
06 ДУГААР САРЫН 09-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН
НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-7
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	8-161
	1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Засгийн газар 2022.04.05-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	18-42
	2. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат нарын 4 гишүүн 2022.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	43-129
	3. Донорын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн нарын 3 гишүүн 2022.05.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	129-155
	4. Төрийн болон орон нутгийн өмчит компанийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.05.04-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	155-161

ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ

Хоёр.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат нарын 4 гишүүн 2022.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамба, Б.Идэрчулуун, Ц.Амартөгс, Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Г.Агар-Эрдэнэ, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ш.Ариунжаргал, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, референт Ц.Энх-Амгалан, мөн газрын Эрх зүйн дүн шинжилгээний хэлтсийн ахлах зөвлөх С.Доржханд нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр нар танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт, Б.Жаргалмаа, Н.Наранбаатар, М.Оюунчимэг, С.Чинзориг, Ж.Батжаргал, Б.Бейсен нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамба, Б.Идэрчулуун, Ц.Амартөгс нар хариулж, тайлбар хийв.

Үдийн завсарлагын цаг болсон тул хуралдаан 13 цаг 14 минутад завсарлав.

Үдээс хойших хуралдаан 14 цаг 01 минутад эхлэв.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэв.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, Б.Саранчимэг, Ц.Сандаг-Очир, Ц.Туваан, Ц.Идэрбат, Г.Ганболд, Ц.Цэрэнпунцаг, Х.Булгантуяа, О.Цогтгэрэл, Т.Энхтүвшин нарын тавьсан асуултад хууль санаачлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Бат-Эрдэнэ, Төрийн албаны зөвлөлийн дарга Б.Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн С.Цэдэндамба, Б.Идэрчулуун, Ц.Амартөгс нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 14 цаг 38 минутаас 15 цаг 45 минут хүртэл хуралдааныг даргалав.

Төслийн үзэл баримтлалттай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 20

Бүгд: 47

57.4 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдлээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 16 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Хоёр.Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат нарын 4 гишүүн 2022.05.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Бат-Эрдэнэ: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Та бүхнийхээ энэ өдрийн амгаланг айлтгая.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат, Ё.Баатарбилэг, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан нарын гишүүдээс санаачлан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон дагалдах хууль, тогтоолын төслийг боловсруулан 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр өргөн мэдүүлээд байна.

Монгол Улсын Их Хурлаас 2019 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн үзэл санаа нь эрх мэдлийн харилцан хяналттай тогтвортой, хариуцлагатай эрх зүйт төрийг төлөвшүүлэхэд чиглэгдсэн юм.

Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн агуулга, үзэл санаанд нийцүүлэн эрх зүйн шинэтгэлийг хэрэгжүүлж байгаа энэ цаг үед төрийн албаны засаглах чадамжийг сайжруулах, сахилга хариуцлагыг дээшлүүлэх, ард түмэндээ үйлчилдэг, ёс зүйтэй, хариуцлагатай төрийн албыг төлөвшүүлэх чиглэлээр шаардлагатай хууль тогтоомжийг батлан гаргах шаардлага үүсэж байна.

Монгол Улсын Үндсэн хуульд өөрчлөлт оруулах асуудлаар анхдугаар зөвлөлдөх санал асуулга явуулж, иргэдийнхээ санал бодлыг сонсоход санал асуулгад оролцогчдын 94.5 хувь нь төрийн сахилга, хариуцлагыг дээшлүүлэх арга механизмыг Үндсэн хуулиар бий болгох, 89.4 хувь нь төрийн хариуцлага, сахилга, шударга ёсыг бэхжүүлэх, 87.9 хувь нь төрийн жинхэнэ албыг мэргэшсэн, мэдлэг, чадварт суурилсан, улс төрөөс ангид байхыг дэмжиж энэ чиглэлээр эрх зүйн хамгаалалтыг бий болгох талаар саналаа илэрхийлсэн байна.

“Алсын хараа-2050” хөгжлийн бодлогын баримт бичигт иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлж, нийгэмд ёс зүй, сахилга хариуцлагаар үлгэрлэх тогтолцоог бэхжүүлэхээр заасан.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга, хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн

зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана гэсэн зорилтыг дэвшүүлсэн.

Монгол Улсын хууль тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлд Төрийн албаны ёс зүй, сахилга, хариуцлагын тухай хуулийн төслийг боловсруулан 2021 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тусгасан зэрэг эрх зүйн баримт бичгүүд нь Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг боловсруулах хууль зүйн үндэслэл болж байна.

Монгол Улсын Их Хурлаас Төрийн албаны тухай хуулийг 1995 онд баталж, 2002 он, 2017 онд тус улс шинэчлэн найруулж, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг тогтоох, сахилгын хариуцлага хүлээлгэх эрх зүйн үндсийг бий болгосон.

Засгийн газраас 2019 онд 33 дугаар тогтоолоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрмийг баталж, төрийн албан хаагчийн албаны үйл ажиллагаандаа баримтлах ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, зөрчсөн бол хариуцлага тооцох хууль зүйн боломж бүрдсэн.

Төрийн албаны хуульд төрийн улс төрийн болон тусгай албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг холбогдох хууль тогтоомжоор тогтоохоор заасны дагуу тус тусын хууль тогтоомжид ёс зүйн асуудлыг тусган мөрдөж байна.

Төрийн тусгай чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бүх шатны шүүхийн шүүгч, прокурор, зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, цагдаа, гааль зэрэг байгууллагын холбогдох албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээг салбарын хууль тогтоомжоор зохицуулж байгаа хэдий ч ёс зүйн хэм хэмжээний төрөл, харилцан адилгүй албан хаагчид ёс зүйн хариуцлага хүлээлгэх журам өөр өөр байдлаар хэрэгжиж байна.

Төрийн тусгай албан тушаалтантай холбоотой ёс зүйн асуудлаар салбар тус бүрдээ тодорхой ажлууд хийгдэж байгаа боловч зөрчлийн тоо, мэдээ улсын хэмжээнд бүрэн нэгтгэж гардаггүй, үнэлэлт дүгнэлт, дүн шинжилгээ хийдэггүй, нэгдсэн бодлого, зохицуулалт хангалтгүй байна.

Төрийн улс төрийн өндөр албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээг тогтоосон бие даасан хууль тогтоомж одоогоор байхгүй байна. Харин Монгол Улсын Их Хурлын тухай хуулиар Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороог байгуулж, төрийн албан хаагчийн ёс зүйн сахилга, хариуцлагын бодлого, Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн сахилгын асуудлыг эрхлэхээр хуульчилсан.

Энэ хүрээнд Улсын Их Хурал 2021 оны 105 дугаар тогтоолоороо Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг шинэчлэн баталснаар төрийн өндөр албан тушаалтнуудын ёс зүй, хэм хэмжээг тогтоох, сахин мөрдүүлэх, хариуцлага тооцох эрх зүйн үндэслэлийг бий болгох санаачилга, эхлэлийг тавьсан гэж үзэж байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаар хууль, журам, дүрэм цөөнгүй боловч төрийн албаны бүх түвшинд ёс зүй, хариуцлагын арга хэмжээний үр нөлөө багатай зохицуулалт сул хэвээрээ байна.

Ёс зүйн дүрэм үйлчилж байгаа хэдий ч ёс зүйн зөрчил, маргааныг шийдвэрлэх, ёс зүйг сахин мөрдүүлэх, хэвшүүлэх тогтолцоо сул байна.

Төрийн албаны зөвлөлийн 2020 оны тайланд тусгагдсанаар нийт 1194 ёс зүйн зөвлөл байгуулагдан ажиллаж байна. Төрийн байгууллагын ёс зүйн зөвлөлийн ажиллах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах, үйл ажиллагааны үр дүнг тооцох, хяналт тавих, төрийн албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлэх нь чухал байна.

Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлага, ёс зүйг цахим мөрдүүлэх, төрийн албаны нэр хүндийг нэмэгдүүлэх, засаглах чадамжийг сайжруулах асуудал үе үеийн парламент, Засгийн газрын үед яригдаж ирсэн.

Төрийн албаны ёс зүйн сахилгын хариуцлагын тогтолцоог сайжруулах, холбогдох хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 48 дугаар захирамжаар байгуулж, тус ажлын хэсгийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга ахалж, Улсын Их Хурлын Ёс зүйн дэд хороо, Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөл, яамдын болон эрдэмтэд, судлаачдын төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулсан байна.

Засгийн газрын түвшинд Төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагын тухай хуулийн төсөл боловсруулж, түүний хэрэгцээ шаардлага, үр нөлөөг тооцсон тайландаа төрийн албан хаагчийн сахилга, хариуцлагын асуудлыг бие даасан хуулиар зохицуулах нь зүйтэй гэж үзсэн байна.

Улсын Их Хурлын даргын 2021 оны 35 дугаар захирамжаар Төрийн албан хаагчийн ёс зүйн сахилга, хариуцлагын тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг байгуулан ажиллуулж хуулийн төслийн анхны хувилбарыг боловсруулсан. Уг төсөл Төрийн албаны зөвлөлөөр дамжуулан Төрийн болон орон нутгийн 74 байгууллага санал, зөвлөмжөө ирүүлсэн.

Төрийн албан хаагчийн ёс зүйн сахилга, хариуцлагын чиглэлээр өмнө боловсруулсан төслүүд, түүнчлэн төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм, Засгийн газар, Төрийн албаны зөвлөл, Төрийн болон орон нутгийн байгууллагуудаас ирүүлсэн саналыг харгалзан Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон дагалдах хууль, тогтоолын төслийг боловсрууллаа.

Хуулийн төслийг боловсруулахад Нэгдсэн Үндэстний Байгууллагаас гаргасан Төрийн албан хаагчийн ёс зүйн олон улсын дүрэм, Европын зөвлөлөөс баталсан Төрийн албан хаагчийн ёс зүйн үлгэрчилсэн дүрэм болон Япон, Сингапур, Австрали, Канад Улс, Зүүн болон Төв Европын орнуудын төрийн албан хаагчийн ёс зүйн харилцааг зохицуулсан эрх зүйн орчинг судалж, харгалзан үзлээ.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслөөр төрийн албаны ёс зүйн нийтлэг асуудлыг нэгдмэл байдлаар зохицуулсан ерөнхий хуулийг батлан гаргах, түүнд бүх төрийн албан хаагчдыг сахин мөрдөх нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг тогтоож зөрчсөн бол хүлээлгэх хариуцлагын төрөл, түүнчлэн ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны журмыг энэ хуулиар тогтоох юм. Үүнд:

Нэг. Ёс зүйн хэмжээ, зөрчил, хариуцлагын талаарх ёс зүйн харилцааны суурь ойлголтыг өгнө.

Хоёрдугаарт, энэ хууль төрийн, улс төрийн, захиргааны, тусгай, үйлчилгээний албан хаагчид нэгэн адил үйлчлэх ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, шаардлагыг тогтоохоор зааж байгаа ба албаны чиг үүргийн онцлогтой уялдуулан тусгай зохицуулалтыг бусад хууль тогтоомжоор тогтоож болохоор заасан.

Гуравдугаарт, төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг хариуцах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, ёс зүйн байдалд хяналт тавих бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлон заалаа. Үүнд, төрийн байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтан албан хаагчдынхаа ёс зүйг сахин мөрдүүлэх, орчин нөхцөлийг бүрдүүлэх, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх арга хэмжээг авах ёс зүйн зөвлөлийг байгуулан ажиллуулах, зөрчил үйлдсэн албан хаагчид хариуцлага тооцох зэрэг чиг үүрэгтэй ажиллана.

Дараагийн дугаарт харин улсын хэмжээнд ёс зүйн асуудлыг нэгдсэн зохицуулах, нэгдсэн арга зүйгээр хангах, хуулиар харьяалуулсан гомдлыг хянан шийдвэрлэх үүрэгтэй Ёс зүйн хороог Төрийн албаны зөвлөлийн дэргэд байгуулж ажиллуулахаар энэ хуулийн төсөлд тусгасан.

Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол хүлээн авах, хянан шалгалт, дүгнэлт гаргах, хариуцлага хүлээлгэх зэрэг гомдол хянан шийдвэрлэх ажиллагааны журмыг хуучиллаа.

Төрийн албан хаагчид ёс зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлагын төрлийг тогтоож, ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл журмыг заалаа.

Албан тушаалтан өөрөө хариуцлага хүлээх соёлыг төлөвшүүлэх зорилгоор уучлалт гуйх, албан тушаалаасаа сайн дураараа огцорч, ёс зүйн

хариуцлага хүлээх боломжийг мөн энэхүү хуулиар зохицуулалтыг хийж өгч байна.

Хуулийн төслийг баталснаар төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг улсын хэмжээнд удирдан зохицуулах нэгдсэн зохицуулалттай болж, Төрийн болон орон нутгийн байгууллагын бүх шатанд төрийн албаны ёс зүй, соёлыг төлөвшүүлэхэд ахиц гарах, улмаар иргэд ёс зүйтэй, чанартай төрийн үйлчилгээ авах боломж бүрдэнэ гэж хууль санаачлагчид үзэж байна.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Хууль санаачлагч Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүнд баярлалаа.

Одоо зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Жамбын Батсуурь, Наянтайн Ганибал нарын урилгаар Сүхбаатар аймгийн “Жаахан шарга” хөгжимт жүжгийн театрын уран бүтээлчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Тэгээд соён гэгээрүүлэгчид, уран бүтээлчид Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан, уран бүтээлийн өндөр амжилтыг хүсэн ерөөе. /алга ташив/

Төслийн талаарх Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дарга Баагаагийн Баттөмөр танилцуулна. Индэрт урьж байна.

Б.Баттөмөр: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Мөнхбат, Ё.Баатарбилэг, Б.Бат-Эрдэнэ, Б.Баярсайхан нараас 2022 оны 05 дугаар сарын 27-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо 2022 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн хуралдаанаар хэлэлцлээ.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцүүлэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен төрийн албаны үйл ажиллагаанд улс төржих, намчирхах, ялгаварлах байдал гарч байгааг арилгах зохицуулалтын талаар, Б.Баярсайхан төрийн албан хаагчдын дунд удирдах албан тушаалтны зүгээс хууль бус шийдвэр гаргахад нөлөөлөх, дарамт гардаг байдлыг хянах,

хариуцлага тооцох талаар, Б.Баттөмөр Ёс зүйн зөвлөлд Ёс зүйн хорооны үйл ажиллагаа, гишүүдийн тоо, бусад чиг үүргийн талаар, Х.Баделхан Төрийн албанд бодит байдал дээр гардаг доголдол, зөрчлийг ёс зүйн зөвлөл болон хороогоор хэлэлцүүлэх, гарсан шийдвэрийн хэрэгжилтийн үр дүнг тооцох зохицуулалтын талаарх асуулт асууж, хариулт авсан болно.

Монгол Улсын Их Хурлын гишүүн Б.Бейсен төрийн албан хаагчийн ёс зүйн шаардлагыг дээшлүүлэх цаг үеийн чухал шаардлага байгаа талаар, Б.Баярсайхан төрийн албаны ёс зүйн хэмжээг сайжруулах, Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хариуцлагыг нэмэгдүүлэхэд энэ хуулийн төсөл чухал ач холбогдолтой нөлөөтэй бөгөөд нийгмийн захиалга үүссэн, цаг үеэ олсон талаар, Б.Баттөмөр төрийн албанд мөрдөх стандарт, баримтлах ёс зүйн хариуцлага, ёс зүйн код, мэдлэг чадварын стандарт, шатлан дэвшүүлэх арга хэмжээг нарийвчлан тогтоох, биеэ зөв авч явах, хувцаслалт, харилцаа, хандлагын асуудлыг тодорхой тусгах талаар, Б.Бат-Эрдэнэ төрийн албаны ёс зүй, сахилга хариуцлагыг чангатгах, нийгмийн бүх салбарт зөв төлөвшил тогтоох, нийтийн эрх ашгийн үүднээс хариуцлага, сахилга хариуцлагыг сайжруулахад чухал үр нөлөөтэй талаар, Ж.Мөнхбат хариуцлагатай, сахилгатай, ёс зүйтэй, нийгэм төлөвшихөд, ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх зориулалтын талаар нарийвчлан тусгах нь чухал алхам болох талаар тус тус санал хэлсэн болно.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслийн үзэл баримтлалын хүрээнд дэмжихийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүд 100 хувийн саналаар дэмжиж, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт тэргүүн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Авлигын эсрэг хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслүүд, “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хувьд хэлэлцэх эсэх талаар Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүгдээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Баярлалаа. Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя.

Төрийн албаны зөвлөлийн дарга Балдангийн Баатарзориг, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Самдангийн Цэдэндамба, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Бадамцоогийн Идэрчулуун, Төрийн албаны зөвлөлийн гишүүн Цэнддоогийн Амартөгс, Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Чандагийн Бат-Эрдэнэ.

Хууль санаачлагчийн илтгэл болон Улсын Их Хурлын Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу? Хүрэлбаатарын Булгантуяа гишүүнээр тасаллаа.

Сандагийн Бямбацогт гишүүн асуулт асууна.

С.Бямбацогт: Энэ бас нэлээн чухал хууль юм. Бас олон жил яригдсан. Шийдэх ёстой. Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт хийсний бас нэг гол зорилго бол төрийг цомхон чадварлаг болгох, дээрээс нь төрд итгэх ард иргэдийн итгэлийг сэргээх, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэх асуудал байсан. Асуудал байсан.

Төрийн албан хаагч ард түмэндээ үйлчилж, төрдөө чин шударгаар зүтгэснийхээ төлөө зүтгэх эрхэм зорилгоо ухамсарлаж, төрийн ажил үүргийг гүйцэтгэхдээ хуулиар тогтоосон ёс зүйн хэм хэмжээг чандлан биелүүлэх, үнэт зүйлс соёлыг төлөвшүүлж, төрөө дээдлэх ард түмний итгэлийг бэхжүүлэхэд энэ хуулийн зорилго орсон гэж байгаа юм.

Тэгээд ёс зүйн асуудал, ёс зүйн асуудлын цаад талд төрийн бүтээмжийн асуудал байгаад байгаа юм. Төрийн түгжрэлийн асуудал. Анх ажилд томилогдохдоо төр, ард түмнийхээ төлөө ёстой хоёргүй сэтгэлээр зүтгэнэ. Над шиг мэдлэгтэй, боловсролтой, чадвартай хүн байхгүй гээд ажилд томилогддог. Томилогдсон хойноо хүнд суртал гаргадаг, шан харамж авдаг, ард иргэдээ дарамталдаг, чирэгдүүлдэг. Би төрийн албан хаагч. Надад та бүхэн бөхөлзөх ёстой гэдэг хандлага гаргадаг. Ийм л төртэй болчихоод байгаа юм л даа. Төрийн албан хаагчтай болчихоод байгаа юм.

Анх ярьж байсан, тийм үү, хоёргүй сэтгэлээр зүтгэнэ гэсэн хаачив. Би чинь тийм үү, ард түмэн илүү зүтгэх үүрэгтэй хүн шүү гэж үүрэг хариуцлагаа ухамсарлаж ажиллах ёстой. Тэгээд үүнээсээ болоод үндсэндээ төрийн бүтээмж гэдэг асуудал байхгүй болчихсон. Цагаа бүртгүүлээд цалин авдаг болчихсон. Төр маань улам данхар, улам том, улам нүсэр болчихсон. Төрийн гарч байгаа бодлого шийдвэр амьдрал, ард иргэддээ наалддаггүй ийм л болчихоод байгаа юм л даа.

Тэгээд энэ хууль батлагдсанаар энэ асуудал маань хэрхэн яаж шийдэгдэж чадах юм бэ? Хийж шийдэж чадах юм бэ? Энэ дээр нэг тодорхой авсан хариулт авмаар байгаа юм. Хариулт авмаар байгаа юм.

Төрийн түгжрэл хэрхэн яаж алга болох вэ? Энэ данхар төр маань цомхон болж чадах уу? Төрийн бүтээмж нэмэгдэж чадах уу? Төрийн албан хаагч нар маань төр, ард түмнийхээ төлөө хоёргүй сэтгэлээр үнэнч, шударгаар, хөнгөн шуурхай ард иргэдийнхээ төлөө ажиллаж чаддаг болох уу? Үүнийг л бид шийдмээр байна л даа.

Нөгөө талаасаа дахиад нэг асуудал. Цагаа бүртгүүлээд цалингаа аваад хүн болгонд тийм үү, та мундаг хүн, та сайн хүн, би анхаарна гэдэг бөөрөнхийлөөд нэг их сайхан бөөрөнхий. Ерөөсөө. Ойлголоо, мэдлээ, болголоо. Хийнэ, хийнэ гээд сууж байдаг хүмүүс. Ямар ч гараас нь юм гардаггүй ийм хүмүүс байдаг.

Нөгөө талдаа юу гэдэг юм, шударга, зарчимч, асуудлаа үнэн шударгаар нь хэлээд тийм үү, таалагдах таалагдахгүй асуудал үүсдэг. Ажлын бүтээмж гардаг. Ааш зан муутай гэж ярьдаг шүү дээ. Бид нар бас. Иймэрхүү хүмүүс байдаг.

Гэтэл юу гэдэг юм, ааш муутай гээд байдаг хүмүүсээс нь юм гараад байдаг. Тэр нь илүү ажлаа сэтгэлээсээ хийгээд байдаг. Гэтэл юу ч хийдэггүй нэг сайхан бөөрөнхий хүн суугаад байдаг. Тэр нь ерөөсөө тийм үү, аягүй мундаг хүн шиг харагдаад их ааш сайтай хүн шиг байгаад байдаг. Гараас нь юу ч гардаггүй.

Үүнийг хэрхэн яаж салгах юм бэ? Аль нь ёс зүйтэй хүн бэ? Та бүгдийн. Хууль санаачлагчдын үзэж байгаагаар. Бас нэг зарчимч, шударга тийм үү, ил тод, асуудлаа айхгүй, ичихгүй, хэлчихдэг, шүүмжилчихдэг ийм хүмүүс нь ёс зүйтэй хүн болох уу? Эсвэл хүн болгонд тал зассан, бөөрөнхийлсөн, таны зөв шүү дээ гэсэн тийм үү, цаг нөхцөөсөн, цаг бүртгүүлсэн ийм бөөрөнхий хүмүүс нь ёс зүйтэй хүн үү? Энэ хууль дээр үүнийг ямархуу байдлаар томъёолж тодорхойлж байгаа вэ? Үүнийг хууль санаачлагч хариулж өгөөч.

Г.Занданшатар: Бадамаанямуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Хууль санаачлагч.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. С.Бямбацогт гишүүний асуултад хариулъя. Таны асууж байгаатай санал нэг байгаа.

Үнэхээр энэ сүүлийн 30-аад жилийн хугацаанд төрийн албанд. Нийтлэгээр нь хэлж байгаа юм биш шүү. Одоо яг тантай санал нэг байгаа. Үнэхээр төрийн хүнд суртал, цаашилбал авлига, ашиг сонирхлын зөрчил, төрийн албаны чанар, хүртээмж, түргэн шуурхай үйлчилгээ, цаашлах юм бол төрийн алба сонгуулиас сонгуулийн хугацаанд л данхайгаад л бүтэц нь нэмэгдээд л байгаа энэ асуудлууд байгаа. Үүнтэй санал нэг байгаа.

Үүнийг Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар мэдээж та мэдэж байгаа бүрэн хэмжээнд шийдвэрлэх бололцоогүй. Гэхдээ нэг тодорхой нөхцөлийг бүрдүүлэх, ялангуяа харьцаа, хандлага, зан чанар, төлөв, ажилдаа

эзэн болох энэ ёс зүйн зөрчилтэй холбоотой, ёс зүйн хандлагатай холбоотой, энэ ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн энэ томоохон суурь хууль болно гэж бид үзэж байгаа.

Бидний өмнө тулгамдаж байгаа, төрийн албанд тулгамдаж байгаа энэ олон бэрхшээлийг давахын тулд олон хууль, эрх зүйн зохицуулалт, бодлого шийдвэр гаргаж хэрэгжүүлэх шаардлагатай. Үүний нэг тодорхой илрэл яригдаж байгаа Үндсэн хуулийн асуудал энд хамаарагдана.

Бид 2019 оны Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн үндсэн үзэл агуулга энэ рүү л чиглэж байгаа. Энэ Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлт батлагдсантай холбоотойгоор дагаж гарах олон хууль, шийдвэрүүд бий. Эхнээс нь Их Хурал батлаад ингээд явж байгаа. Энэ бол цогцоор нь шийдэх асуудал.

Таны асууж байгаа ааш авир муутай, тэгэхдээ гараас нь юм гардаг, нэг хэсэг нь ямар ч итгэхгүй, цагаа бүртгүүлсэн, ажлын бүтээмж муутай энэ хоёрын зааг ялгаа. Үүн дээр холбогдох хууль, журам, ажил хариуцаж байгаа эрх бүхий албан тушаалтан, хамт олны зүгээс энэ зохицуулах олон асуудлууд бий. Бид энэ хуулиараа ерөөсөө улсын хэмжээнд 1100 гаруй Ёс зүйн зөвлөлүүд ажиллаж байгаа. Энэ ёс зүйн зөрчил, энэ тавигдах шаардлага, нийтлэг хэм хэмжээ, энэ юмнуудыг нэгдсэн нэг мөр ойлголттой болъё гэдэг ийм шаардлага байгаа юм.

Тэгэхээр зэрэг энд төрийн албан хаагчийн эрхэмлэх үнэт зүйлс, ёс зүйн нийтлэг хэмжээний шаардлага гээд бүхэл бүтэн 2 дугаар бүлэг дээр заагаад өгчихсөн. Энэ ямар ямар шаардлагыг сахиж биелүүлэх вэ, ямар харьцаа, хандлага, зан чанарыг баримталж ажиллах вэ. Бүгдийг нь энд оруулаад өгчихсөн байгаа.

Тэгэхээр зэрэг энэ хэм хэмжээ, шаардлага энэ хязгаараас давахгүй л байх ёстой. Тэр ажлаа бүтээхийн тулд үйл ажиллагаандаа ажилдаа баримтлах тэр хэм хэмжээг давахгүй л байх ёстой. Аль нэг хэмжээгээр давсан байх юм бол ёс зүйн зөрчлийн тухай асуудал яригдаж эхлэх болно гэж л хууль санаачлагчид үзэж байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: 93. Төрийн албаны зөвлөлийн дарга хариулна.

Тэрний өмнө зочид танилцуулъя. Асуулт хариултын цаг явж байгаа. Одоо энэ чинь.

Улсын Их Хурлын гишүүн Цэдэндамбын Цэрэнпунцаг, Балжиннямын Баярсайхан нарын урилгаар Завхан аймгийн Улиастай сумын ерөнхий боловсролын сургуулийн 1991 оны төгсөгчдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Оны төгсөгчдөдөө Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эргэж учирсан энэ мөчүүд инээд хөөр, дурсамж баяраар дүүрэн өнгөрүүлэхийг хүсэн ерөөе. /алга ташив/

Төрөлх сургууль, найз нөхөд, үеийнхнийгээ эргэн дурсаж уулздаг ийм сайхан уламжлал манай уламжлалт боловсролын соёлуудын нэг. Тэгээд та бүхэндээ эргэн дурссан уулзалт чинь дурсамж дүүрэн байхыг хүсэн ерөөе.

Балдангийн Баатарзориг дарга хариулъя.

Б.Баатарзориг: С.Бямбацогт гишүүний асуултад хариулъя.

Зарим төрийн албан хаагчид үнэхээрийн иргэдэд хүнд суртал үүсгэдэг, хүлээлгэн чирэгдүүлдэг, бухимдуулдаг. Тэгээд ч зогсохгүй бүр эгдүүг нь хүргэдэг ийм үзэгдлүүд байгаа.

Үүнтэй холбоотойгоор соён гэгээрүүлэх үйл ажиллагаа Төрийн албаны тухай хуулийн дагуу үйл ажиллагаанууд явагдсан. Зарим тоонууд та хэд дээр танилцуулагдсан. Танилцуулга дээр байгаа тооноос өөр байгаа. Ахиц дэвшил, хөгжүүлэлт хийгдэж байгаа. Зарим тоо бол 2020 оны манай тайлан дээр үндэслэсэн тоонууд байгаа.

Өнөөдөр гэхэд нэг жилийн дотор 1517 Ёс зүйн зөвлөл шинээр байгуулагдсан. Яг өнөөдрийн байдлаар улсын хэмжээнд 2711 Ёс зүйн зөвлөл ажиллаж байгаа. Эдгээр зөвлөл ажилласны үр дүнд зарим ажлын эхлэлүүд харагдаж байгаа. Гэхдээ саяын дурдсан зөрчлүүд байсаар байна. Жишээ нь, 2020 онд 1422 зөрчил гарч байсан. Ёс зүйтэй холбоотой. Зөвхөн. Энэ оны хувьд 2021 онд 419 зөрчил гарсан. Харьцангуй буурч байгаа.

Ер нь ёс зүйтэй холбоотой асуудал анхаарлын төвд байгаад үүнийг хэрэгжүүлэх чиглэлээр хийгдэж байгаа ажилтай холбоотой гэж үзэж байгаа. Олон удаагийн давтамжтай судалгаагаар 2017 оны зөвшилцөх санал асуулгын судалгаанаас хойш ер нь төрийн албан хаагчдын ёс зүйтэй холбоотой, хариуцлага сахилгатай холбоотой, хүнд сурталтай холбоотой таны хэлээд байгаа зүйл судалгаагаар нотлогддог. Энэ бол 89.7-оос 94.5 хувь хүртэлх нь энэ төрийн зарим албан хаагчдынхаа ёс зүйг сайжруулаач ээ, хариуцлага, сахилгыг сайжруулаач ээ гээд ийм зүйлүүд байгаа учраас энэ харилцааг зохицуулахад Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль чухал үүрэгтэй гэж үзэж байгаа юм.

Ингэснээр Шинэ сэргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, сэргэлтийг хэрэгжүүлэхэд, төрийн бүтээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой зүйлүүд дээр ахиц дэвшил гарна. Санхүүжилт шаардахгүйгээр, хөрөнгө оруулалт, шаардахгүйгээр хийгдэж болох ажил бол энэ ёс зүйн асуудал юм байна гэдэг дээр бид сүүлийн гурван жил үзэж байна. Ингээд зарим ахиц дэвшлүүд гарч байгаа.

Сүүлийн өнгөрсөн долоо хоногт гэхэд Б.Бат-Эрдэнэ дарга оролцсон, Байнгын хорооны дарга оролцсон Сангийн яам дээр 6 яамдын ёс зүйн сургалтууд явагдсан. Ер нь бид гурван зүйлүүдийг тоглолтын дүрэм дээрээ тодотгож хэлж байгаа.

Нэгдүгээрт нь, энэ иргэдийг хуурдаг байдлаа зогсоо.

Хоёрдугаарт нь, иргэдэд худлаа хэлдэг байдлаа зогсоо.

Төрөөс хулгай хийдэг байдлаа зогсоо гэдэг.

Ер нь ёс зүйн харилцааг зохицуулахад дээд тал нь есөн гол асуудал дээр анхаарлаа хандуулдаг юм билээ. Тэгээд таны асуулттай санал нэг байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: С.Бямбацогт гишүүн 1 минут тодруулъя.

С.Бямбацогт: Тэгэхээр хууль зөрчдөг, хулгай хийдэг төрийн албан хаагч нар хуулийнхаа дагуу хариуцлагыг хүлээнэ. Гэтэл хууль зөрчсөн үү гэхээр зөрчөөгүй. Тийм үү.

Би сая хэллээ шүү дээ. Бөөрөнхийлөөд л сууж байдаг. Сайхан аашлаад л сууж байдаг. Гараас нь юу ч гардаггүй. Цагаа бүртгүүлээд л цалингаа авч байдаг. Ямар ч бүтээмж байхгүй. Энэ хүмүүс энэ хууль батлагдсанаараа хэр зэрэг бүтээмжтэй, хариуцлагатай, санаачлагатай, сэтгэлтэй болох юм бэ? Ажил даа. Яаж?

Хоёрдугаарт нь, ажлаа сайн хийдэг, бүтээмж ихтэй, ааш муутай энэ хүмүүсийн ааш нь яаж засагдах вэ, бүтээмж нь яаж нэмэгдэх вэ? Өөрөөр хэлэх юм бол энэ хууль батлагдсанаараа төрийн бүтээмж нэмэгдэх үү? Төрийн түгжрэл алга болох уу? Төрийн албан хаагчдын хүнд суртал, ажилдаа хайнга, хариуцлагагүй, сэтгэлгүй ханддаг хандлага хэрхэн яаж өөрчлөгдөх вэ? Үүнийг л бид хийж чадах юм бол аягүй чухал байгаад байгаа юм л даа. Тийм болохоор энэ хуулийн зорилго ийм л байх ёстой. Яг тодорхой ийм үр дүнгүүд энэ хууль батлагдаж гарснаараа ийм ач холбогдолтой болно, ийм үр дүнгүүд гарна гэдгийг тодорхой. Өнөөдөр ямар байгаа юм. Ирээдүйд энэ хууль батлагдсанаар ямар байна.../минут дуусав/

Г.Занданшатар: 92. Бадамцоогийн Идэрчулуун. Төрийн албаны зөвлөлийн гишүүн.

Б.Идэрчулуун: Баярлалаа. Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуун.

Эрхэм гишүүний тодруулаад байгаа. Энэ асуудал зайлшгүй байгаа асуудал.

Тэгэхээр ёс зүйн хуультай болсноор бид энэ ажлаа хийдэггүй, цагаа бүртгүүлчхээд цалингаа аваад явж байдаг улсуудын хандлагад өөрчлөлт орох уу гэж асууж байна.

Тэгээд хүнийх нь ухамсар дээшилчихсэн, ёс зүй нь өөрийнхөө энэ нийгэмд гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлагаа ойлгочихсон, нийгэм нь хөгжихсөн, хүн нь хөгжсөн гадаад орны туршлагыг харахаар энэ Японы баримталдаг ёс зүйтэй хүнд албан тушаал өг өө гэдэг энэ философи хэрэгжээд явах юм болов уу гэж харж байгаа юм.

Г.Занданшатар: Бадарчийн Жаргалмаа гишүүн асуулт асууна.

Б.Жаргалмаа: Баярлалаа. Та бүхнийхээ өдрийн амгаланг айлтгая.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл орж ирж байгаад үнэхээр талархалтай байна. Энэхүү хууль батлагдсанаараа төрийн маань үйл ажиллагаа тодорхой хугацаанд амждаг байх тэр боломжийг нээж өгөх болов уу гэж харж байна. Өөрөөр хэлэх юм бол саяын С.Бямбацогт даргын хэлээд байгаачлан Төрийн албан хаагчийн ёс зүйгүй байдлаас шалтгаалаад төрийн ажил удаашралтай байдаг. Төр ажлаа хийхгүй байна, төр хүнд сурталтай байна, төр данхайсан байна гэдэг энэ асуудал, төр ажлаа мэдэхгүй байна гэдэг энэ асуудал эцэслэн шийдвэрлэгдэх юм болов уу гэж харж байгаа.

Ер нь төрийн алба 100 хүнтэй, хувийн хэвшил 10 хүнтэй ажиллаад байгаа энэ жишиг харагддаг. Сая уг нь хэмнэлтийн хуулиараа бид энэ алдааг маш томоор засах ёстой байсан боловчиг бас шаардлагатай хэмжээнд хүрч чадаагүй. Эргээд л ажилгүйчүүдийнхээ эгнээг бид нэмсэн ийм хууль болсон гэж харж байгаа.

Энд хэд хэдэн асуулт байна. Өнөөдөр төрийн албаны шалгалт бид өгдөг байгаа. Яг энэ шалгалт дээр ёс зүйтэй байх, хэт хэчнээн шалгуурууд байдаг вэ? Энэ дээр тайлбар өгөөч.

Нөгөөтээгүүр өнөөдөр төрийн алба хашиж байгаа албан хаагчдаас хэчнээн нь үүрэг гүйцэтгэгч байна вэ? Үүнийгээ эцэслэн бид шийдвэрлэж чадсан уу гэдэг асуулт.

Дараа нь энэ ёс зүйн зөрчил гаргасан алба хаагчдын сан бүрдүүлнэ. Нэгдсэн сан хөтлөх, ёс зүйн зөрчлийн талаар олон нийтэд мэдээлэх гэнэ. Зөрчил гаргаад байвал төрийн албандаа байгаад л байна гэсэн үг үү?

Бас нэг заалт байна. 15.6.ёс зүйн зөрчлийг илрүүлснээс хойш 6 сар, зөрчил гарснаас хойш 12 сараас илүү хугацаа өнгөрсөн бол ёс зүйн хариуцлага хүлээлгэхгүй. Уучлаарай. Хэрвээ хэн нэг нь мэдэхгүй бол, хэн нэг нь гомдол гаргахгүй бол энэ хариуцлагагүй, энэ ухамсаргүй, энэ үгээ зөв хэлж иргэнтэйгээ

зөв харьцаж чадахгүй хүн чанаргүй энэ улсууд төрийн албанд байгаад л байна гэсэн үг үү? Үүгээрээ бид энэ алдаагаа засаж чадах уу? Энэ хууль гарснаараа.

Ёс зүйн зөвлөл, Ёс зүйн хороо байгуулагдана гэсэн байна. Төсөвт хэчнээн төгрөгийн зардал гарах вэ? Бас дахиад л төрийн албаа бид данхайлгах гээд байна уу, үгүй юу гэдэг асуудал дээр.

Ёс зүйн зөрчил үйлдсэн албан хаагчид зөрчлийн шинж байдалд нийцүүлэн энэ хуульд заасан ёс зүйн хариуцлага хүлээлгэнэ. Өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах, нийт ажилтан зарлан хэлбэрээр нийтэд мэдээлэх, төрийн албанаас халахыг сануулах, төрийн албанаас халахыг сануулах шийтгэл ногдуулсны дараа ёс зүйн зөрчил гаргасан, эсвэл албан тушаалын чиг үүрэгт харшлах ноцтой зөрчил гаргасан бол төрийн албанаас хасах.

Нөгөө хэрэг хөөн хэлэлцэх хугацаа гэдэг шиг Зөрчлийн хуулиараа энэ нэг асуудлыг шийдүүлэх гээд л энэ хүн Ёс зүйн хороонд байгаад байх нь. Хэрвээ ямар нэгэн ичих нүүр нь элгэндээ наачихсан гэдэг юм уу, ичих нүүр нь өөрөөс нь ичээд нисээд явчихсан хүмүүс бол олон нүдэн дээр нэг гарч ирээд уучлаарай гэж нэг мэхийн ёслоод ёс зүйн хариуцлагаа хүлээсэн тооцох нь ээ.

Бид яаж ёс зүйтэй хүн байх вэ гэдэг зүйлийг л би дандаа ярьдаг. Хүнээ дээдэлдэг төр байна гэж бид ярьдаг. Тэгвэл энэ хуулиар энэ зүй тогтол бий болж чадах уу гэдэг энэ хэд хэдэн асуултад хариулт өгөөч ээ. Баярлалаа.

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Хууль санаачлагч гишүүн асуултад хариулна уу?

Б.Бат-Эрдэнэ: Энэ хуулийг хэлэлцэх эсэхийг нь Их Хурал шийдвэл дараагаар нь Их Хурлын даргын захирамжаар ажлын хэсэг гараад, манай гишүүд ажлын хэсэгт оролцоод, тэгээд энэ хуулийн төслийг боловсронгуй болгох, сайжруулах ийм боломж бүрэн нээлттэй байгаа.

Энэ хуулийн үндсэн зорилт бол урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн ажлыг энэ Ёс зүйн хороо, Ёс зүйн зөвлөлүүдээр дамжуулж хийх ийм үндсэн зорилготой.

8 дугаар зүйл дээр төрийн албан хаагчдад тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага гээд. Ингээд 8.1-ээс эхлээд 8.1.1 албан тушаал, бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ иргэд, үйлчлүүлэгчдэдээ хүндэтгэлтэй, адил тэгш, эелдэг, хүлээцтэй харилцаж, төрийн үйлчилгээг чирэгдэл, ялгаваргүйгээр хөнгөн шуурхай хүргэх.

Тэр тухайн төрийн байгууллагын үйл ажиллагааны соёл, дэг журмын чанд сахих. Гадаад улсад ажиллах хугацаандаа Монгол Улсын нэр хүндэд харшилсан аливаа үйлдэл гаргахгүй байх, албан үүргээ гүйцэтгэж байхдаа

согтууруулах ундаа хэрэглэх, байгууллагын дотоод журам болон холбогдох бусад журамд нийцэхгүй байдлаар хувцаслах. Төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнийг үндэс угсаа, хэл, арьс өнгө, нас, хүйс, нийгмийн гарал байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх.

Албан үүргээ гүйцэтгэх нь 8.1.2.б. албан үүргээ гүйцэтгэхдээ бусдын нэр төр, алдар хүндийг гутаан доромжлохыг цээрлэх.

1.2.в.албан тушаалын бүрэн эрхээ ашиглаж бусдыг дарамтлах, эрхшээлдээ байлгах, хавчин гадуурхахгүй байх.

Ингээд та бүхэн энэ нийтлэг шаардлагууд, үүнийг нь аль болохоор тодорхой болгож тавьж өгч байгаа юм. Одоо жишээлбэл архи ууж согтууруулах ундаа ажлын байран дээрээ хэрэглэхгүй байх гэдэг бол энэ хэнд ч ойлгомжтой. Үүнийг зөрчсөн бол ёс зүйн зөрчилд тооцно. Энэ тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага бол хэм хэмжээ. Тухайлах юм бол ажлын байран дээр бэлгийн дарамт, албан тушаал албанахаа эрх мэдлээ хувийн болон нийгмийн тодорхой бүлэг, байгууллагын явцуу ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх, хувийн зорилгоор албаны нэр ашиглахыг цээрлэх гэх мэтчилэнгээр ингээд тодорхой заагаад өгчихсөн.

Энэ хүрээндээ л ёс зүйн зөрчил гэж тооцно. Бид ёс зүйн зөрчил эхлээд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар дээр боловсруулагдаж байсан хуулийн төсөл бол Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилгын тухай хуулийн төсөл гээд. Энэ чинь хоёр гурван жилийн хугацаанд бид энэ хуулийн төсөл дээр ажиллаж байгаа л даа.

Тэгэхээр энэ асуудлуудыг ярьж байгаад Засгийн газрын ирүүлсэн санал бүх юман дээр нь ажиллаад бид зөвхөн Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай асуудлыг нь хуульчилж өгсөн ийм суурь хуулийг гаргаж өгөөд байгаа юм.

Б.Жаргалмаа гишүүн их чухал асуудал асуулаа. Энэ төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлыг хариуцсан Ёс зүйн хороог Төрийн албаны зөвлөлийн дэргэд байгуулахаар. Энэ бол ямар нэгэн нэмэгдэл орон тоо, бүтэц санхүүжилт шаардахгүйгээр өнөөдөр Төрийн албаны зөвлөлийн дэргэд байгуулна.

Тэгэхдээ энэ Ёс зүйн хороо бол хараат бусаар. Яг Төрийн албаны зөвлөлийн нэг нэгж болж ажиллахааргүйгээр ингэж байгуулахаар хуульчилж байгаа юм. Хуучин энэ ёс зүйн зөвлөлүүдийг яаж байгуулж байсан гэхээр зэрэг шууд томилж байгуулж байсан. Одоо тэгвэл ёс зүйн зөвлөлүүдийг албан хаагчдынх нь нийтийн хурлаар санал хураагаад ёс зүйн зөвлөлөө байгуулаад Ёс зүйн зөвлөл нь ахлагчаа сонгоод ингээд энэ үйл ажиллагаагаа явуулна. Тухайн байгууллагын удирдаж байгаа албан тушаалтан үүрэг хариуцлагатай оролцохын зэрэгцээгээр тэр ёс зүйн зөвлөлүүд харьцангуй.../минут дуусав/

Г.Занданшатар: 93. Б.Баатарзориг дарга хариулъя.

Б.Баатарзориг: Хариулт хэлье. Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулахын өмнө С.Бямбацогт гишүүний асуултад хариулъя.

Энэ гараас нь юм гардаггүй зарим төрийн албан хаагчид байгаа. Энэ хуулийн 7.1.4-өөр албан үүргээ эс гүйцэтгээд байвал хариуцлага ногдуулна гэдэг энэ зохицуулалтаар шийдэгдэнэ. Өнөөдрийн байдлаар гэхэд өөрсдөөр нь хүчингүй болгосон 577 төрийн албан хаагчдын асуудал бид шийдээд байгаа. Энэ эс үйлдэл хийдэг.

Б.Жаргалмаа гишүүний асуултад хариулъя. Сая санхүүжилтийн асуудал ярьсан. Санхүүжилт дээр нэмэлт санхүүжилт шаардахгүйгээр байгаа.

Хоёрдугаарт нь, Төрийн албаны зөвлөл дээр одоо оны яг эхэнд 01 сарын 01-ний байдлаар 2524 хууль бус томилгоотой нөхдүүд байсан. Үүнийг засах ажлууд үе шаттай хийгдсэн. 411 дүгээр тогтоол гараад. Одоогоор 326 хүн үүрэг гүйцэтгэж байна. Эндээс 79 нь болзол шаардлага хангагдаагүй анхааруулга аваад ийм зүйл хүлээж байгаа. Энэ нь мэргэжлийн шаардлагаас хамаардаг. Мал аж ахуйнхан энэ тэр гээд зарим тодорхой хугацаатай томилогдсон энэ хүмүүс байгаа.

Ер нь хууль бус зүйлтэй эвлэрэхгүй байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Б.Жаргалмаа гишүүн асуулт асууна. Гүйцээж асууна. 1 минут.

Б.Жаргалмаа: Төрийн алба гэдэг бол ард түмний өмнө үүрэг хүлээж байгаа үүрэг гүйцэтгэгч болохоос биш дарга сэтэртэн биш шүү гэдгийг онцгойлон хэлэх ёстой байх гэж бодож байна. Өөрөөр хэлэх юм бол би, би гэдэг өвчлөлийг арилгах ёстой. Төрийн албанд энэ хуультай болсноороо бид төрийн албанд ичих булчирхай нь өөрөөс нь ичээд нисээд явчихсан энэ хүмүүсийг томилохгүй байх. Нөгөөтээгүүр улс төрийн томилгоо гэж хэн нэгэнд эрх мэдэл олгох энэ байдлыг засах ажил гэж би бодож байна.

Тийм учраас энэ хуулийн төслийг дэмжээд ажлын хэсэгт нь ороод ажиллах саналтай байна. Дарга аа. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал юм байна. Энэ хуулийн төслийг 2018 оноос эхэлж Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга байхдаа энэ хуулийг санаачилж боловсруулаад, Германы төрийн албаны сахилга хариуцлагын хууль, Японы төрийн албаны ёс зүйн хуулийг судалж бас ажлын хэсгийг тийш нь явуулж ажиллуулж, Удирдлагын академи, Төрийн албаны зөвлөл, олон эрдэмтэн судлаачид оруулж хийсэн.

Тэгээд ёс зүйг хуульчилж болдоггүй гэсэн тийм ерөнхий шаардлага байсан учраас одоо манайд ёс зүй эвдрээд байгаа учраас үүнийг хуульчилдаг олон улсын туршлага байгаа. Хамгийн гол юм чинь энэ хууль хэрэгждэггүй чинь энэ төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай л холбоотой асуудал байгаа шүү дээ.

Тэгээд энэ хууль ингээд өнөөдөр өргөн бариад хэлэлцэх эсэхийг нь гурван жилийн дараа хэлэлцэгдээд явж байгаа. Одоо Нанзадын Наранбаатар гишүүн асуулт асууна.

Н.Наранбаатар: Та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе.

Ёс зүйн хуультай байхыг дэмжиж байгаа. Харин хэрэгждэг байх дээр л анхаарах хэрэгтэй байх. Хэрэгжилт нь ямар байх бол гэж л санаа зовж байна. Энэ дээр бас хариулаарай. Хэрэгжилт ийм байхаараа сайн байх юм. Ийм ийм механизм байх юм гэдэг зүйл байгаа юу гэж асуумаар байгаа юм.

Яах вэ, сүүлийн үед Их Хурлаар орж ирж байгаа хуулиуд дээр үнэхээр дэмжмээргүй хуулиуд бас байгаад байгаа юм. Тухайлбал тэр Төрийн албаны тухай хууль. Төрийн албаны чинь бүх босгыг нь багасгаад ингээд ямар ч мэдлэггүй, чадваргүй хүмүүс орох бололцоотой болгоод. Төрд ажиллаж байгаагүй хүмүүс цонхоор орж ирэх бололцоотой болгоод л. Тэгээд л хугацаа юмнуудыг нь багасгаад л. Нөгөө тогтвортой, мэргэшсэн, шатлан дэвших зарчмыг чинь байхгүй болгоод л. Ингээд л сэтгэл дундуур нэг ийм хууль орж ирэх юм.

Үүний өмнө хэлэлцсэн Тендерийн хууль бас босго юмнуудыг нь багасгаад л. Тэгээд л үүний үр дүн чинь чанаргүй л юмнууд л үлдэнэ шүү дээ. Төсвийн хөрөнгө ямар ч үр ашиггүй зарцуулагдана. Төрийн албаны хуулийг ингээд босгыг нь багасгахаар төрийн албан хаагчийн мэдлэг чадвар, ёс зүй гэж ярих юм байхгүй болно. Энэ төрийн албаны нэр хүнд, чадвар гэдэг юм чинь байхгүй болно. Монгол төрийн дархлаа гэдэг юм уу, чадвар гэдэг юм уу энэ чинь сулрах ийм зүйл бий болно. Бас орж ирж байгаа хууль, энэ төрийн хяналт шалгалтыг гурван жил зогсооно гэж байгаа. Мэргэжлийн хяналтыг. Энэ чинь одоо нөгөө хүнсний аюулгүй байдал, байгаль орчны эсрэг гэмт хэрэг, аюулгүй байдал гээд дэмжмээргүй дэмжмээргүй ийм зүйлүүд бас их орж ирж байгаа юм.

Тэгээд үүний хажуугаар ёс зүйн хууль орж ирж байгааг дэмжмээр байгаа юм. Бас энэ төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой асуудлууд их гардаг. Өнөөдөр ер нь төрийн албан хаагчийн боловсрол, ёс зүй, мэдлэг ямар байна вэ гэдэг дээр нэг анхаарах цаг нь болчихсон. Тэдний цалин хангамж нь ямар байна вэ гэдгийг ер нь эргэж харахгүй энэ чинь 500, 600-хан мянган төгрөгийн цалинтай төрийн албанд ер нь ямар хэмжээний боловсролтой, тэр хэмжээнд үнэлэгдсэн, ямар хүн орж ирэх нь ер нь тодорхой болчихоод л. Ингээд л аргаа ядаад боловсон хүчнээ бүрдүүлэхийн тулд л хамаг шаардлагуудаа багасгаад л ингээд л яваад байгаа юм.

Тийм учраас ёс зүй энэ хуулиа батлаад сайн хэрэгжилтийг нь хангаад явах нь цаашдаа чухал байна. Асуулт байна.

Иргэд энэ төрийн албан хаагчтай холбоотой гомдол, саналаа хаана гаргах вэ? Ямар байдлаар гаргаж өгөх вэ? Нотлох баримт янз бүрийн юмнуудтай хамтруулж өгөх үү?

Төрийн албан хаагчид бас ёс зүйтэй холбоотой, дарга удирдлагынхаа ёс зүйтэй холбоотой гомдол, саналыг хаана гаргаж өгөх вэ?

Мөн Улсын Их Хурал, тэгээд л аймаг, сумын хурлын төлөөлөгч нартай холбоотой, Засаг дарга, хурлын даргатай холбоотой, ялангуяа улс төрийн албан тушаалтнууд бол үнэндээ хамгийн их ёс зүйн алдаа зөрчил дутагдал, томилгоо хийдэг, гаргадаг улсууд байдаг. Тэгээд энэ хүмүүстэй холбоотой санал гомдлуудыг хаана гаргаж өгөх вэ, хэрхэн яаж шийдвэрлэх вэ? Шийдвэрлэж байгаа процесс, үйл явцыг тэр өргөдөл гаргасан этгээд яаж мэдэх вэ? Нууцлал янз бүрийн юм байх уу? Ил тод байх уу? Тэгээд эргүүлээд хэн ямар арга хэмжээ авах вэ? Тухайлбал иргэдийн Хурлын дарга дээр хэн хариуцлага тооцох вэ? Ажлаас халах хүртэл гээд байж байна. Энэ бол сайн л байна.

Тэгэхээр зэрэг аймгийн Засаг дарга, жишээ нь иргэдийн Хурал, хурлын төлөөлөгч энэ тэрийг ажлаас нь яаж халах вэ? Ямар процессоор явагдах вэ? Үүнийгээ ард иргэдэд олон түмэнд яаж, ямар мэдээлэлтэй байх вэ? Ямар арга хэмжээ авах вэ? Хугацаа юм нь ямар байх вэ гээд энэ хууль чинь яаж хэрхэн хэрэгжих юм гээд процесс талаас нь л асууя. Тэгээд дараа нь хариултын дараа тодруулъя.

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Хууль санаачлагч. Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороон дарга.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Н.Наранбаатар гишүүнд.

Аймгийн Засаг даргаар ажиллаж байсан орон нутаг дахь төрийн албаны тулгамдаж байгаа асуудлууд, ялангуяа төрийн албан хаагчийн ёс зүйтэй холбоотой асуудлаар та үнэтэй санал, асуулт асууж байна.

Энэ хуулиар ер нь нэлээн тодорхой асуудлуудыг нь зохицуулах ийм агуулгатай зүйл, заалтуудыг ажлын хэсэг дээр ярьж байгаад бид оруулсан байгаа.

Одоогийн байдлаар би түрүүн хууль санаачлагчийн илтгэлдээ та бүхэнд дурдсан. Зарим төрийн өндөр дээд албан тушаалтнуудын ёс зүйн хариуцлага тооцох ийм асуудлууд орхигдсон байгаа.

Ялангуяа энэ хуулийн 13.4-т Монгол Улсын Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, дэд дарга, Улсын Их Хурлын гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүгч, прокурор, шүүхийн сахилгын хорооны дарга, гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүн, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгчийн ёс зүйтэй холбоотой гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна гээд ингээд энэ 13.4-өөр оруулсан байгаа.

Үүнд 13.5-д Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, дэд сайд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зөвлөх, Их Хурлын даргын зөвлөх, Ерөнхий сайдын зөвлөх, аймаг, нийслэлийн Засаг дарга, бусад төрийн улс төрийн албан тушаалтны ёс зүйтэй холбоотой гомдлыг Ёс зүйн хороо харьяалан шийдвэрлэхээр энэ хуулийн төсөлд оруулсан байгаа.

Би түрүүн илтгэлдээ хэлсэн. Энэ зохицуулагдаагүй үлдсэн төрийн өндөр албан тушаалтнууд дотроос Их Хурлын гишүүд, энэ 2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр байгуулагдсан манай Их Хурал бол улс төрийн манлайлал үзүүлж Улсын Их Хурлын гишүүнийхээ ёс зүйн дүрмийг баталсан байгаа. Одоо энэ 03 сарын 30-наас эхлээд энэ шинэ дүрмийн хүрээнд бид ажиллаж байгаа.

Тэгэхээр зэрэг энэ 13.4-т заасны дагуу холбогдох хууль тогтоомжийнхоо дагуу ингээд зохицуулаад явах энэ эрхийг нь нээгээд өгч байгаа гэж.

Санал гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэх 14 дүгээр зүйл байгаа. Гомдлуудыг хүлээн авч хянан шалгах ажиллагааг доорх журмаар сонгоно. Энэ гомдол мэдээллийг хүлээж авах, хянан шийдвэрлэх энэ ажиллагааг л хамгийн гол нь хэлмэгдэл гаргахгүй. Аль аль талд нь. Тэр ёс зүйн зөрчил гаргасан этгээдэд хариуцлагыг нь хүлээлгэж чадахгүйгээр өнгөрүүлэх, эсвэл хэн нэгнийг хэлмэгдүүлэх ийм юмыг аль болохоор хязгаарлаж өгөх хэрэгтэй байдаг.

Улсын Их Хурлын гишүүний 2009 онд баталсан дүрмээр ч гэсэн энэ харилцааг бид хамгийн эхний ээлжид л тэр гомдол гаргагч иргэн хуульд заасан шаардлагын дагуу нийцсэн энэ гомдол мэдээллийг бид хүлээж авна. Хамгийн эхлээд өргөдлийн гомдол, мэдээллийн хаягласан хаягаас эхлээд эргэх буцах харилцаа холбооноос авхуулаад ингээд энэ зүйлийг нь зохицуулсан ийм зохицуулалт байгаа.

14.1.1-д жишээлбэл хүлээн авснаас хойш ажлын 3-аас 5 өдрийн дотор, хүндэтгэн үзэх шалтгаантай бол эрх бүхий албан тушаалтны тогтоосон хугацаанд зөрчилд холбогдсон албан хаагчаас бичгээр, эсвэл цахим шуудангаар тайлбар авах, шаардлагатай бол тухайн албан хаагчийг дуудан ирүүлж тодруулга, мэдээлэл авах.

14.1.2-т шаардлагатай тохиолдолд гомдол, мэдээлэл гаргагчаас нэмэлт тайлбар, тодруулга, түүнчлэн эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас мэдээ, баримт гаргуулан авах.

Ингээд энэ дээр 14 дүгээр зүйл бол гомдол, мэдээллийг хянан шийдвэрлэхтэй холбоотой энэ процессыг нэлээн дэлгэрэнгүй тусгаж өгсөн.

Тухайлах юм бол 14.2 дээр дүгнэлтийг дараах этгээдэд баталгаат шуудангаар явуулснаас хойш нийслэлд ажлын 5 өдөр, орон нутагт ажлын 10 өдөр өнгөрсний дараа, эсвэл биечлэн гардуулснаар тэдэнд мэдэгдсэнд тооцно. Энэ тухай гомдол, мэдээлэл гаргасан этгээд, зөрчилд холбогдсон төрийн албан хаагч.../минут дуусав/

Г.Занданшатар: Нанзадын Наранбаатар гишүүн тодруулъя.

Н.Наранбаатар: Төрийн жинхэнэ албан хаагчид, төрийн захиргааны албан хаагчдын хувьд тодорхой шалгалт юмнуудаа өгөөд ингээд байгууллагадаа он удаан жил ажиллаад дадлага туршлагатай болоод явдаг. Төрийн тусгай бас ялгаа байхгүй ёс зүйн зөрчил гаргавал доор нь л тушаал гаргаад л хөөгөөд явуулчихна. Төрийн захиргааныхан бас ялгаа байхгүй. Түүн шиг амархан. Төрийн үйлчилгээнийхнийг бүр амархан. Тэгээд л ингээд.

Харин улс төрийнхныг оруулж ирж байгааг би сайшааж байгаа юм. Харин улс төрийн албан хаагч хамгийн их ёс зүйн зөрчил гаргадаг, хүнийг дарамталдаг, ажил төрлөөс нь халдаг, өөрсдөө ажил төрөлдөө ирдэггүй, тэгээд ажлаа таслаад явчихдаг, юм хийдэггүй, ямар ч шалгалтгүй ингээд төрд ороод ирчихсэн мөртлөө нөгөө мэрэгшсэн хүмүүсийг удирдах гээд дээр нь сууж байдаг. Нөгөө мэдлэг нь хүрдэггүй, туршлага нь хүрдэггүй ийм этгээдүүдэд хариуцлага хүлээлгэх хариуцлага нь л товч тодорхой, процесс нь ил тод байх ёстой шүү л гэдгийг хэлэх гээд байгаа юм. Өөр юм алга.

Г.Занданшатар: Сайхан үг хэллээ. Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Төрийн алба, төрийн албанд ажиллаж байгаа дарга цэрэг, ер нь бүх л хүмүүс дээр хариуцлагатай байх тэр хариуцлагын үр дүн нь улс орны хөгжил, бүтээн байгуулалт, иргэдээ аль болохоор орлоготой хөдөлмөртэй байх, энэ улс орныг нэг зөв голдирол руу нь хөгжүүлчих л гэсэн гол зорилго, агуулга байгаа гэж би харж байгаа. Түүнээс биш энэ нэг хэдэн хуудас гаргаад энэ нь төрийн албанд нэг л сайхан ааштай, ёс суртахуунтай хүнийг ажилд оруулах тухай асуудал яригдаад байгаа юм уу, эсвэл тэнд ажиллаж байгаа хүний тэр ёс суртахуун нь өөрөө бүтээл бүтээмж болоод энэ нь өөрөө улс орны хөгжилд, хүний нийгмийн, хүний эрхийн асуудал дээр, хүний үүрэг хариуцлагын асуудал дээр бүтээмж болох тал дээр нь нэгдүгээрт анхаараад байгаа юм уу гэдэг жоохон тодорхойгүй байна л даа.

Бид зөндөө хууль гаргадаг. Тэгээд л төрийн алба данхайсан гээд л хөөрхий тэнд өдөр шөнөгүй ажиллаж байгаа хүмүүсийг бид буруутгаад байгаа юм биш. Үнэндээ данхайсан биш ажлаа даахгүй, тэр дунд түвшиндээ доод түвшин нь маш их байна шүү дээ. Харин данхайсан зүгээр дарга нар дээрээ л байгаа.

Одоо тэгээд төрийн албаа бүр хүчгүй болгочоод яаж ажиллах гээд байгаа юм. Би бас ойлгохгүй байгаад байгаа юм. Цалин хөлс нь ч муу, дээрээс нь өдөр шөнөгүй ажиллаж байна. Тэгээд л гамшиг, элдэв өвчин зовлон тохиолдоно нөгөө л төрийн албаны үйлчилгээнийхэн маань бүгд явдаг. Хамгийн бага цалинтай. Тэгээд өнөөдөр яах. Төрийн алба данхайчихсан, нэр төр нь уначихсан гээд бүр төрийн албагүй болчих гээд байгаа юм уу.

Би энэ Төрийн албаны зөвлөлийнхнөөс асуух гээд байгаа юм. Ер нь ёс зүй, энэ төрийн алба гэдэг дээр юун дээр нь болохгүй байгаад байгаа гэдгийг та нар харж байгаа шүү дээ.

Түрүүн яг С.Бямбацогт гишүүний хэлж байгаа үнэн. Цүнх барьдаг нь нэг хэсэг л гүйгээд байдаг. Яг бүтээмж авахгүй. Ажил байхгүй. Тэгэхдээ хамгийн сайхан ааштай. Долдогонуур. Хүний урдуур хойгуур гүйдэг. Бусдын хийснийг өөрөө хийсэн юм шиг болж яриад дараа нь мэдээж тэгээд өөд нь шидсэн ч чулуу өөрийнх нь толгой дээр ирдэг л байх л даа. Юм нь. Ийм байгаад байна шүү дээ.

Би тэгээд ёс зүй ярих гэж байж яривал ярьсан шиг ярих хэрэгтэй байна л даа. Тангараг өргөөд, хууль гаргаад юу ч бүтэхгүй. Бид олон жил олон дарга нар тангараг өргөдөг. Тэгээд л авлигал хээл хахуульдаа баригдаад л яваад байна шүү дээ.

Тийм учраас бид үүнийг маш тодорхой яримаар байна. Нэгдүгээрт.

Хоёрт нь, Б.Баатарзориг дарга аа, энэ төрийн албан дээр хоёр, гурван зөрчлийг бүр хэлэхгүй болохгүй байгаад байна.

Нэгдүгээрт, сүүлийн үед дүүрэг, тамга, яамдаас ингээд л ярихад төрийн албаны сургалтад хамрагдаж байна. Бүр ажил хийхгүй болж. Өдөржин сургалтад хамрагдаж байна. Ажил хийхгүй байна. Энэ хүмүүс. Яасан ч их сургалт, семинар явдаг юм. Одоо энэ ёс зүй гээд дахиад л сургалт семинар яваад. Энэ хүмүүсийг ажлыг нь хийлгүүл л дээ. Нэгдүгээрт энэ байна.

Хоёрт нь, энэ жендэрийн баланс яагаад энэ төрийн алба, захиргааны албан тушаалтан дээр алдагдаад байна. Үнэхээр дэндүү алдагдаж байна. Энэ нь юу юм гэхээр нэг эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн амбицтай биш, энэ өөрөө энэ сөрөг үр дагаврууд асар их гарч байгаатай холбоотой байхгүй юу. Энэ агаар хөрсний бохирдлыг хар. Өнөөдөр энэ ээжүүд гадаа уйлаад байж байна. Үр дүн нь юу юм. Энэ агаар хөрсний бохирдлоо бууруулах гэж энэ эрүүл мэндийн

салбар, боловсролын салбар, хүнээ хөгжүүлэх дээр бид орхигдоод анхаараагүй. Энэ нэг гол нөлөө. Энэ нь юу юм гэхээр жендэрийн баланс алдагдсаны гол үр дагавар шүү дээ.

Өнөөдөр Скандинавын орнууд, бид сая Японы сайхан туршлага гээд л яриад байна. Тийм ээ. Энэ бүгдээрээ улс орныг хөгжүүлэхэд жендэрийн баланс өөрөө маш чухал үүрэгтэй байдаг. Хэрвээ жендэрийн балансыг зөв хангаж чадвал тухайн улсын дотоодын нийт бүтээгдэхүүн бүр 30 хувиар өсөх бүрэн бололцоотой гэдгийг өнөөдөр өндөр хөгжсөн орнууд гаргаад, тэгээд үүнийг судалгаан дээр үндэслээд яриад байгаа шүү дээ. Манайд яагаад байна. Энэ алдагдаад байдаг.

Тэгэхээр хаана нь алдагдаж байна гэхээр захиргааны түвшинд, шийдвэр гаргах түвшин дээр нь алдагдаад. Харин гүйцэтгэх тэр хөшигний ар талын тэр боловсрол дээр, тэр сувилагч, асрагч, үйлчилгээ тэр чигээрээ эмэгтэйчүүд хамгийн бага цалинтай. Тэтгэвэрт гарна. Хамгийн бага тогтоогддог. Мэдээж зөндөө эрчүүд маань ч ийм асуудал байгаад байна.

Энэ нь юу юм гэхээр бид үнэхээр л төрийн албыг боловсронгуй, чанартай, ёс суртахуунтай, бүтээмж өндөртэй болгоё гэвэл үндэс сууриар нь л асуудалд хандах ёстой. Түүнээс биш өнгөцхөн илээд л, нэг л нэг үгийн сайхнаар бие биетэйгээ уралдаад байх биш. Асуудалд нухацтай хандах өөрөө чухал байгаа.

Тэгээд миний асуух гэж байгаа асуулт бол би Б.Баатарзориг даргаас тэр хоёр асуулт байна.

Нэгд. Энэ хүмүүс яагаад ингээд ажиллахгүй, хурал цуглаанд хамаг цагаа бараад байгаа юм бол доо.

Хоёрт. Тэр жендэрийн баланс дээр хариулт өгнө үү.

Дараа нь тодотгоё.

Г.Занданшатар: Б.Баатарзориг дарга. 93. 94. С.Цэдэндамба дарга хариулах уу? Төрийн албаны зөвлөлийн гишүүн Самдангийн Цэдэндамба. 94.

С.Цэдэндамба: Хуулийн хэлэлцүүлэгтэй холбоотойгоор сая М.Оюунчимэг гишүүний дэвшүүлсэн асуудлыг зүйтэй гэж хүлээж авч байна.

Ер нь энэ яг яриад байгаагийн цаана төрийн албаны ёс зүй нь өөрөө бүтээмж болох, соёл болох ийм зам руу явж байгаа. Явуулах үүднээс л энэ хуулийг дэмжиж байгаа гэж.

Ер нь ёс зүйн асуудал бол бүхэлдээ зөвхөн төрийн алба биш бас нийгмийн асуудал. Энэ бол одоо боловсролын анхан шатнаас авхуулаад тэгээд байгаа асуудал. Түүний үр дүн нь төрийн албанд тусгал нь байж байгаа. Тэгээд

тэр тусгал нь эргээд нийгэмдээ бас их сөрөг нөлөө үзүүлж байгаа учраас энэ төрийн албанаас нь эхэлж ёс зүйн хэм хэмжээг илүү чангатгая, сайжруулъя гэсэн үзэл баримтлалаар энэ хуулийг санаачилж оруулсан гишүүдийн, Төрийн албаны зөвлөл зарчмын хувьд дэмжиж байгаа байр суурьтай байгаа.

Хоёр асуулт байна. Сургалт их байна гэж хэллээ. Энэ дээр анхаарах зүйл бий. Яах вэ, Төрийн албаны хууль хэрэгжиж эхлээд 3 жил болж байна. Хуульд зааснаар шат шатны сургалтуудыг явуулахаар заасан. Энэ дагуу төлөвлөгөөт сургалтууд явж байгаа байх. Удирдлагын академиас авхуулаад. Түүнээс гадна энэ салбаруудын сургалтууд хийгдэж байх шиг байна. Зайлшгүй шинэ хууль дүрэм журам гарсантай холбогдуулаад түүнийг таниулах, хэрэглэхтэй холбоотой сургалтууд явж байна.

Тийм учраас ажлын байр дээрх сургалтууд гэж үүнийг хэлээд байгаа. Бас богино хугацааны сургалтууд энэ тэр байгаа. Тэгэхээр үүнийг цааш, цаашдаа ажил сургалтынхаа харьцааг зохицуулах талаар анхаарч ажиллая.

Хоёр дахь асуулт байна. Жендэрийн баланс алдагдаад байгаа гэж. Энэ баланс гэдэг ерөнхий утгаараа төрийн албан хаагчдын 60 гаруй хувь нь, одоо 63 хувь нь гэх юм уу эмэгтэй, 37 хувь нь эрэгтэй байгаа. Хаана алдагдаж байна вэ гэхээр яг томилогдох, сонгогдох улс төрийн шийдвэр гаргах түвшинд энэ баланс Жендэрийн эрх тэгш байдлын тухай хуульд заасан квотыг хүрэхгүй байгаа юм. Энэ талаар холбогдох санал зөвлөмжүүдийг Төрийн албаны зөвлөл тайлан болон бусад мэдээллүүдийг холбогдох газруудад хүргээд ажиллаж байгаа.

Жендэрийн үндэсний хороотой хамтарч бид энэ асуудлыг онцгойлон анхаарч ярилцсан. Өчигдөр хүртэл энэ талаар зөвлөлдөх уулзалт хийгээд 2023 онд энэ жендэрийн талаарх мэдээллийг Улсын Их Хуралд тусгайлан тайлан гаргаж танилцуулъя гэдэг ийм шийд гаргаад бид ажиллаж байна.

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Хууль санаачлагч.

Б.Бат-Эрдэнэ: М.Оюунчимэг гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр энэ төрийн албаны данхар бүтэц, төрийн албаны сахилга хариуцлага, бүтээмжтэй холбоотой асуудлыг зөвхөн Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулиар зохицуулах бололцоо байхгүй. Энэ бол зөвхөн нэг суурь нөхцөл нь мөн.

Одоо Улс төрийн намуудын тухай хуулийг Улсын Их Хурал хэлэлцэх байх. Энэ улс төрийн намуудын төлөвшилтэй холбоотой, санхүүжилттэй холбоотой, дүрмийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулдаг, энэ боловсон хүчин, хүний нөөц, сонгууль, энэ мөнгөний сонгууль, энэ бүх юмнуудыг яаж арилгах юм бэ гэдэг юм аа нэг цогцоор нь авч үзэхгүй бол болохгүй.

Цаашлах юм бол энэ төрийн албаны чиг үүргийг төр, хувийн хэвшлийн хүрээнд байдаг юм уу, мэргэжлийн холбоодоор нь гүйцэтгүүлэх байдаг юм уу, энэ олон үйл ажиллагаануудыг явуулах ёстой. Энэ төрийн албанд бүх шатанд бий болоод байгаа авлига, ашиг сонирхол, хариуцлага, сахилга, ёс зүйтэй холбоотой энэ олон асуудлыг цэгцлэхэд сая Засгийн газраас өргөн бариад Улсын Их Хурлаар шийдсэн энэ Төрийн хэмнэлтийн хууль. Энэ бол одоо чухал хууль мөн үү гэвэл мөн гэж би боддог.

Цаашлах юм бол энэ төрийн албыг төрлийн алба болгодог. Ялангуяа энэ төрийн өндөр албан тушаалтнуудаас энэ төрийн томилгоонд оролцдог. Бүр тодорхой хэлэх юм бол үе үеийн Улсын Их Хурал парламент, парламентын гишүүд энэ томилгоонд хууль бусаар нөлөөлдөг, өөрийнхөө ах дүү, амраг садан, үр хүүхдүүд, эхнэр нөхрөө ажил, албан тушаалд томилдог. Энэ чинь нийтлэг асуудал шүү дээ. Үүнийг эндээсээ эхлээд болих ёстой.

Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрэм тодорхой зааж өгсөн. Одоо энэ Засгийн газар үүнийг нэг авч үзээд үүнийг эцэслэх нэг хууль оруулж ирэх байх. Энэ төрийн албыг төрлийн алба болгодоггүй нэг ийм хуулийг оруулж ирэх байх. Харин үүнийг дэмжиж, баталж өгөх ёстой гэж ингэж бодож байгаа юм.

Дараагийнх нь энэ авлигал. Энэ авлига, хулгайг таслан зогсоохтой холбоотой бас тодорхой хуулийг Улсын Их Хурал батлах гаргах шаардлагатай гэж би ингэж боддог хүн. Энэ Засгийн газрын Ерөнхий сайдын яриад байгаа тэр төрийн албанд бүх шатанд ажиллаж байгаа хүмүүс өөрийнхөө орлого хөрөнгөжсөн энэ эх үүсвэрээ нотолж чадахгүй бол төрд тушаадаг энэ хуулийн тодорхой зохицуулалтууд орж байж ингэж тал талаас нь эрх зүйн орчин, төрийн бодлогын хэмжээнд энэ асуудлуудыг авч үзэх ёстой.

Өөртэй чинь харин санал нэгдэж байгаа зүйл бол үүнийг сууриар нь засах ёстой. Энэ гэр бүлийн харилцаа, гэр бүлээс эхлээд сургуулийн өмнөх боловсролоос эхлээд энэ хүмүүсийн төлөвшил, хандлагыг яаж өөрчлөх юм бэ, яаж тогтоох юм бэ. Энэ бүх шатны боловсролын байгууллагууд энд оролцох ёстой гэсэн ийм үндсэн үзэл баримтлалтай байгаа гэдгийг хэлье.

Г.Занданшатар: Мөнхөөгийн Оюунчимэг гишүүн тодруулж асууна. 1 минут.

М.Оюунчимэг: Б.Бат-Эрдэнэ даргатай нэг зүйл дээр үнэхээр санал нэг байна.

Энэ нь дээрээсээ Улс төрийн намын тухай хууль, Үндсэн хуулийн хэрвээ нэмэлт, өөрчлөлтийн асуудал яригдвал, энэ Сонгуулийн тухай хууль энэ тэр яригдвал энэ жендэрийн балансыг барих асуудал. Яг чадвар шалгуураар нь төрийн албанд улс төрийн албан тушаалд томилдог байх дээр хаа хаанаа анхаараасай гэж нэгд хүсэхээр байна.

Хоёрт нь, хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт гомдол мэдээлэл гаргах, түүнийг хянан шийдвэрлэх заалтууд орсон байгаа. Энэ дээр бэлгийн хүчирхийлэлтэй холбоотой асуудлууд сүүлийн арав, хорин жил нэлээд их гарсан байсан. Нэгхэн хувь нь шийдэгддэг. Яагаад гэвэл гомдол гаргахаар нөгөө хүн буруутан болдог, эсвэл нэр хүнд нь унадаг. Нөгөө мэдээллийн нууцыг хадгалах байдал байдаггүй.

Тэгэхээр үүнийг жишээлбэл яаж энэ дээр шийдвэрлэхээр орж ирж байгаа юм оо? Мэдээлэл гаргах, түүнийг хянан шийдвэрлэхээр. Хэн нь шийдвэрлэх юм? Дараа нь яг бодит үнэн мэдээлэл гаргаснаас болоод даргынх нь асуудал юм уу, тэдэнтэй ойр нөхдийнх нь асуудал хөндөгдвөл тэр хүн буруутан болчих уу, үгүй юу гээд асуудлууд байгаа юм. Бид бол одоо яг үнэнийг хэлэхдээ энэ хууль.../минут дуусав/

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Хууль санаачлагч хариулна.

Б.Бат-Эрдэнэ: Энэ хуулийн 8.1.2.г дээр жендэрийн ялгаварлан гадуурхалт, бэлгийн дарамт үзүүлэхээс ангид байх ёстой гээд ингээд заачихсан байгаа л даа.

Тэгээд энэ хуулийн 8 дугаар зүйлийн төрийн албан хаагчид тавигдах ёс зүй, нийтлэг шаардлага бол ер нь 8 дугаар зүйл бол бүхэлдээ багтаж байгаа. Энд одоо ер нь тодорхой хэн ч ойлгомжтой. Үүнийг чанд сахин мөрдөөд биелүүлээд явах ийм боломж үндэслэлтэй шаардлагуудыг л бид оруулсан байгаа.

Энэ ёс зүйн хариуцлагатай холбоотой юм бий. Хэрвээ энэ асуудал нь ёс зүйн хариуцлагаас хэтийдсэн асуудал бол сахилгын хариуцлага, захиргааны хариуцлага, цаашлах юм бол эрүүгийн хариуцлага хүлээнэ гээд явчихна.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг, Жамбалын Ганбаатар, Салдангийн Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн ерөнхий боловсролын 93 дугаар сургуулийн 12^б ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Хүндэт сурагчид Та бүхэндээ сурлага, хөдөлмөрийн өндөр амжилтыг хүсэж, амьдралынхаа нэн чухал энэ хариуцлагатай арван жилийн ерөнхий боловсролын сургуулиа төгсөж байгаа энэ ахлах ангийн сурагчид Та бүхнийг ирээдүйгээ зөв төлөвлөж, зөв шийдвэрүүд гаргаарай. Та бүхний ирээдүй гэрэлтэй байг гэж. Амьдралын зам чинь тод байг ээ гэж хүсэн ерөөе. Сайн сурцаагаарай. Сурлагын амжилт хүсье. /алга ташив/

Одоо Содномын Чинзориг гишүүн асуулт асууна.

С.Чинзориг: Төрийн албан хаагчдаас ёс зүй нэхэх, шаардах нь зүйн хэрэг л байхгүй.

Гэхдээ бид энэ төрийн албан хаагчдаас ёс зүй шаардахын зэрэгцээ ер нь энэ төрийн албаны хуулийг хэрэгжүүлэх талаар, хэрэгжилтийг хангуулах талаар Төрийн албаны хуулийн манаач болсон Төрийн албаны зөвлөл энэ чиг үүргээ шударгаар, хариуцлагатайгаар хэрэгжүүлж чадаж байна уу, үгүй юу гэдгийг бид яримаар л байгаа юм л даа.

Хоёр дахь асуудал. Төрийн албан хаагчдынхаа эрх ашгийг Төрийн албаны зөвлөл хамгаалж чадаж байна уу, үгүй юу гэдэг ийм асуудлуудыг бид ярих л ёстой.

Төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төслийг санаачилсан гишүүний нэг, санаачилж батлуулсан гишүүний нэг нь би л дээ.

Төрийн албан хаагч шатлан дэвших зарчмаар ажил, албан тушаалд очиж байна аа, хашиж байна аа л гэсэн ийм зарчмаар энэ хууль хийгдсэн. Гэтэл энэ хуулийн хэрэгжилтийг ханган биелүүлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах тал дээр би Төрийн албаны зөвлөлийг нэлээн хангалтгүй ажиллаж байгаа юм болов уу гэж л бодоод байдаг юм.

Төрийн албаны хуулийн шинэчилсэн найруулга баталсантай холбоотойгоор Төрийн албаны зөвлөлийн ажиллах нөхцөл боломжийг нэлээн нэмэгдүүлж өгсөн. Төрийн албаны зөвлөлийн орон тоог нэлээн нэмэгдүүлж өгсөн. Төрийн албаны зөвлөлийн гишүүдийн орон тоог нэмэгдүүлж өгсөн. Орон тооны гишүүдийн тоог нэмэгдүүлж өгсөн. Төрийн албаны хуулийн хэрэгжилтийг хангуулахтай холбоотойгоор Төрийн албаны зөвлөлийн эрх хэмжээг нэлээн нэмэгдүүлж өгсөн.

Хууль зөрчиж ажил, албан тушаалд төрийн албан хаагчийг томилсон бол тухайн шийдвэр гаргасан сайдын, Төрийн нарийн бичгийн даргын, аймгийн Засаг даргын, аймгийн Тамгын газрын даргын тушаалыг хүчингүй болгох эрхийг хүртэл Төрийн албаны зөвлөлд хуулиар өгсөн.

Хэдийгээр ингээд төрөөс Төрийн албаны зөвлөлийн ажиллах нөхцөл боломжийг нь хангаж өгч байгаа ч гэсэн, эрх хэмжээг нь нэмэгдүүлж өгч байгаа ч гэсэн Төрийн албаны зөвлөл Төрийн албаны хуулийн хэрэгжилтийг хангуулах талаар, ялангуяа улс төрөөс ангид хараат бусаар үйл ажиллагаа явуулах ийм чадавх суухгүй байна гэж би бодоод байгаа юм.

КОВИД-ын хуулиар төрийн албаны шалгалтыг зогсоосон. Тэгээд төрийн албан хаагч орон гарсан бол тэр нөөцөд байгаа төрийн албан хаагчдаас томилох эрх ийм хуулийн үйлчлэл хэвээрээ юм байгаа юм.

Гэтэл ерөөсөө улс төрчдөөс, Засгийн газраас хараат бусаар үйл ажиллагаа явуулж чадахгүйгээс шалтгаалаад төрийн албан хаагчаар тэргүүн түшмэдүүд, эрхэлсэн түшмэдүүд, үүрэг гүйцэтгэгч нар одоогоор байгаа шүү дээ. Одоо улсын хэмжээгээр хэчнээн хууль бус зөрчиж томилогдсон тэргүүн түшмэлүүд, эрхэлсэн түшмэлүүд байна.

Та нар энэ хууль батлагдсанаас хойш өнөөдрийг хүртэл энэ хууль бус томилгоо хийж, хэдэн сайдын, хэдэн Төрийн нарийн бичгийн даргын тушаалыг хүчингүй болгов?

Энэ төрийн албан хаагчдын нийгмийн хамгааллыг сайжруулах, эрх ашгийг нь хамгаалах талаар юу хийв?

Хөдөө орон нутагт ажиллаад ирэхээр чинь сумдын Засаг даргын Тамгын газарт чинь ажиллах орон тоо олдохоо байлаа л гэх юм. Танайхаас авсан мэдээллээр улсын хэмжээгээр сумдын Засаг даргын Тамгын газарт 1300 гаруй орон тоо эзэнгүй байна. Дандаа үүрэг гүйцэтгэгчтэй байна. 1100 орчим хүн өөрийн хүсэлтээрээ болоод өөр ажилд шилжин ажилласан байна гэсэн судалгаа гараад байдаг юм билээ.

Энэ чинь үндсэндээ тэр суманд ажиллаж байгаа төрийн албан хаагч эрх ашгаа хамгаалж чадахгүй, нийгмийн хамгаалал.../минут дуусав/

Г.Занданшатар: Төрийн албаны зөвлөлийн даргаас асууж байна. 93. Б.Баатарзориг дарга.

Б.Баатарзориг: С.Чинзориг гишүүний асуултад хариулъя.

Төрийн албаны зөвлөл нөгөө сав сайнтай муутай нийлээд сав дүүрэн гэдэг шиг хийгдэж байгаа ажил ч бий, бэрхшээл сорилт ч байна. Та хэдийнхээ дэмжлэгтэйгээр эхлэлүүд байгаа.

Зөвхөн өнгөрсөн онд гэхэд одоогийн байдлаар 417 байгууллага дээр шалгалт хийсэн. Таны эмзэглээд байдаг, бидэнд зөвлөөд байдаг зүйл дээр анхаарал хандуулж байгаа.

417 байгууллагын 5803 төрийн албан хаагч хамрагдсан. Зөрчил 1451 зөрчил гаргасан. Үүнтэй холбоотойгоор өөрсдөөр нь хүчингүй болгох ажлыг 577 шийдвэрийг өөрсдөөр нь хугацаа өгч хугацаанд нь хүчингүй болгосон. Тусгай шалгалтгүй орчихсон нөхдүүд байсан. Паспортгүйгээр хил нэвтэрч байна гэсэн үг шүү дээ.

Тийм учраас 1069 тусгай шалгалт аваагүй нөхдүүд дээр нээлттэй сонгон шалгаруулалт аваад босго давсан нь томилогдсон, даваагүй нь чөлөөлөгдсөн. Төрийн албаны зөвлөл өнөөдрийн байдлаар 207 тушаалыг хүчингүй болгоод энэ хэрэгжилт хэрэгжээд явж байгаа. Үүнийг хариулна одоо.

Эд нар дотроо хугацаатай үүрэг өгөгдөөд 1432 албан хаагч дээр хугацаатай үүрэг өгөгдсөн. 289 удирдах ажилтны шийдвэрийг засуулж буюу хууль бус томилгоог нь хүчингүй болгож шийдвэрлэсэн. 1085 гүйцэтгэх албан тушаалтны албан тушаалыг болзол, шаардлага хангаагүй хүмүүс томилогдоод, КОВИД-ын хуулиар томилогдсон байсныг хүчингүй болгосон. 419 ёс зүйн зөрчлийг илрүүлээд. Үүнээс төрийн захиргааны 150, төрийн үйлчилгээний 269 хүнд хариуцлага ноогдуулах ажлуудыг явагдаж байгаа.

Маргаан хяналт шалгах ёс зүйн асуудал хариуцсан Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуун дарга хариулна.

Г.Занданшатар: Б.Идэрчулуун. 92.

Б.Идэрчулуун: Эрхэм гишүүн С.Чинзоригийн асуултад хариулъя.

Яамдын Төрийн нарийн бичгийн даргын 73 тушаалыг хүчингүй болгосон байна. Агентлагийн даргын 187 тушаалыг хүчингүй болгосон. Орон нутгийн Тамгын дарга нарын 970 тушаалыг хүчингүй болгосон байна.

Ингээд нийтдээ 1069-ийг хууль номын дагуу болгочхоод тийм тусгай шалгалтаа өгөөд, ерөнхий шалгалтаа өгөөд, өгч чадаагүй нь өөр хүн энд сонгон шалгаруулалтад ороод ингээд сул орон тоо нь нөхөгдөөд одоогоор КОВИД-ын хууль далимдуулж томилогдсон 326 албан тушаалтан ажлаа хийгээд байж байна.

Б.Баатарзориг: 2022 оны байдлаар. Сая Б.Идэрчулуун гишүүн 2021 оныхыг хэлсэн.

2022 оны байдлаар, 5 сарын сүүлийн байдлаар яамны 40 Төрийн нарийн бичгийн даргын шийдвэрт, агентлагийн 75, орон нутагт 3. Ийм шийдвэрт хүчингүй болгох ажлуудыг хийсэн.

Г.Занданшатар: С.Чинзориг гишүүн тодруулъя. 1 минут.

С.Чинзориг: Ер нь цаашдаа жаахан төрийн алба хуулийн хүрээнд энэ Төрийн албаны хуулийг хэрэгжүүлэх шаардлагыг тавьж хуулиар олгосон эрх мэдлээ хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн эрх ашгийг хамгаалж ажиллаж баймаар байгаа юм.

Одоо бол Засгийн газрын томилгоогоор хууль зөрчөөд томилогдчихсон тэргүүн түшмэлүүд гэхэд одоо арав гаруй, 13, 14 орчим л байгаа юм билээ шүү дээ.

Тэгээд та нар нөгөө Засгийн газрын шийдвэр халдаж чаддаггүй, сайдын шийдвэрт халдаж чаддаггүй. Тэгээд муу муудаа нь дээрэлхүү гэдэг шиг л тэгээд

хэдэн аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга нарын хэдэн тушаалыг л хүчингүй болгосон гээд байдаг.

Гол нь одоо энэ тэргүүн түшмэл, эрхэлсэн түшмэлүүд дээр чинь зөрчил арилахгүй байгаад байгаа байхгүй юу. Энэ талаар ерөөсөө дуугардаггүй. Улс төрөөс ангид бай, хараат бусаар ажилла гээд л эрх мэдлийг чинь нэмэгдүүлж өгсөн шүү дээ. Онцгой эрх өгсөн шүү дээ. Тушаал, шийдвэрийг хүчингүй болгодог.../минут дуусав/

Г.Занданшатар: 92. Б.Идэрчулуун дарга.

Б.Идэрчулуун: Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуун.

Төрийн албаны тухай хууль дээр хууль зөрчсөн томилгоог Засгийн газар 14 хоногийн дотор засаж залруулна гэсэн байгаа. Бид үүнийг арилгуулах чиглэлээр тухайн томилгоо болгон дээр Засгийн газарт бичиг өгч байгаа. Үүнийгээ арилга гээд.

Яамд арилгаад байгаа. Засгийн газар өөрийнхөө томилгоог арилгахгүй байгаа. Өгч байгаа. Захиргааны шүүхэд өгч байгаа. Бид шүүхдээ хангалттай нэг түвшинд хүрээд ойлголцоод ажиллаж байгаа. Одоогийн байдлаар зүгээр өчигдрийн байдлаар 98 шүүхийн асуудал дээр Төрийн албаны зөвлөлийн тогтоол нэг нь ч унаагүй явж байгаа. Тэр дээр бид.../минут дуусав/

Г.Занданшатар: Жигжидийн Батжаргал гишүүн.

Ж.Батжаргал: Баярлалаа. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль орж ирж байна. Энэ хуулийг бид нэлээн сайхан чамбайруулж гаргах ёстой байх. Ажлын хэсгийн түвшинд ярих болов уу гэж би ингэж бодож байна.

Бид Төрийн албаны зөвлөлөө байгуулаад нэлээн тийм тогтвор суурьшилтай чадамжуулах ажиллачихлаа л гэж ингэж ойлгоод байгаа.

Тэгэхээр одоо энэ Ёс зүйн хороо, зөвлөлийг дэргэд нь биш дотор нь нэгж болгож л ажиллуулах ёстой. Тэгж байж энэ бас нэг төрийн албаныхаа мэргэшсэн байдал, соёл, ёс зүйн асуудал нь хангагдах ёстой болов уу гэж би ингэж хараад байгаа. Үүнийг явц дунд нь зөв зохицуулах ёстой болов уу. Энэ талаар ямар бодол байна вэ гэж.

Хоёр дахь асуудал, ёс зүйн асуудал, хариуцлага, ажлын бүтээмжийн тухай ярилгүй яах вэ. Энэ ярих ёстой зүйл. Гэхдээ Монголчуудын өнөө хүнээр хүн хийдэг гэдэг юм уу, эсвэл энэ төрийн боловсон хүчнийг бэлтгэдэг асуудлаа бид орхигдуулчихсан юм билээ. Яг нарийндаа.

Тийм учраас энэ төрийн албаны шалгалт өгөөд тэнцээд орж ирж байгаа энэ хүүхдүүдийг ажлын байран дээрээ төлөвшдөг, чадварждаг, манлайлдаг

тийм сургалтын хөтөлбөр, юмыг тэр агуулга, юмнуудыг нь нэлээн боловсронгуй болгож гаргаж, ажлын байран дээр нь мөнхийн бэлтгэх асуудлыг энэ Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо хийх ёстой.

Тийм учраас би энэ Төрийн албаны зөвлөл, Ёс зүйн хороо, энэ зөвлөлүүдийн ажлын чиг үүрэгт үүнийг оруулж өгөх ёстой гэж ингэж ойлгоод байна. Энэ талаар ямар бодол байна вэ?

Бид ер нь хүнээ бэлтгэх, төлөвшүүлэх, чадваржуулах энэ чиглэлээр бага юм хийгээд байгаа улс билээ шүү. Дандаа л хариуцлага ярьцгаагаад л, стандарт ярьцгаагаад л ингээд л яваад байгаа улсууд юм билээ. Үүнийг ер нь их бодох цаг болчихсон. Үүнийг зөв хийх ёстой гэж.

Дараагийн нэг зүйл. Төрийн албанд янз бүрийн тохиолдлоор улсууд томилогдоод байна. Үүнийг хаах ёстой. Дам дамаа тэр төрийн захиргааны өндөр албан тушаалууд дээр тавигдаж байгаа улсуудыг Авлигатай тэмцэх газраас бид дүгнэлт авч байгаа. Яг тэр дотроо энэ Төрийн албаны зөвлөлөөс төрийн албаныхаа шалгуурыг хангаж байгаа юм уу, үгүй юм уу гэдэг дүгнэлтийг нь давхар авдгаар эрх зүйн зохицуулалтыг нь хийж өгөх ёстой. Тэгж байж тэнд тэр цонхоор орж ирдэг юмыг хаах хаалтуур нь, эрх зүйн зохицуулалт нь хангагдах ёстой гэж ингэж ойлгоод байна. Үүнийг та бүхэн юу гэж ойлгож байна вэ гэдэг асуудал байна.

Дараагийн нэг хэлмээр байгаа асуудал байгаа юм. Ерөөсөө бид энэ төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, энэ элдэв бусын юм ярихдаа дээд тушаалынхаа улсуудыг л гэдэг юм уу, бас нэг жоохон гоочлох талын юмнуудыг нь дэвэргээд ч байгаа юм шиг. Зарим тохиолдолд ийм л юм л харагдаад байгаа л даа.

Нотлогдоогүй, үндэслэлгүй байдлаар төрийн албан хаагчдаар төрийн албан хаагчид нь матаад байгаа энэ үйл явцыг ер нь тогтоовол тэр худлаа асуудал гаргаад байгаа улсууд ямар хариуцлага тооцох юм. Энэ ёс зүй юмаа энэ дотор оруулж өгөх юм уу? Тэр чинь ёс зүйн зөрчил мөн юм уу, биш юм уу?

Ер нь хамт олны уур амьсгалыг эвддэг барьдаг тийм юм их байна. Энэ бол нийгмийн өөрийнх нь сэтгэл зүйн гажигтай холбоотой байх. Бодоход. Гэхдээ л бас энэ төрийн алба өөрөө манлайлал байх ёстой юу бол энэ асуудлыг энэ хууль дотор бас зөв шигтгээ юмыг нь оруулж өгөх ёстой гэж.

Нөгөө талд дан ганц тэр янз бүрийн зөрчлүүдийн тухай ярихаасаа илүүтэйгээр ажлын цаг ашиглалтаас авхуулаад бүтээмжийн асуудлыг ёс зүйтэй яаж холбох юм бэ? Одоо нэг баахан цаг нөхцөөсөн, яг нарийндаа энэ сошиал.../минут дуусав/

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? 95. Цэнддаваагийн Амартөгс хариулна.

Ц.Амартөгс: Гишүүний асуултад хариулъя.

Ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотойгоор хандлага, соёлыг төлөвшүүлэх, ялангуяа хариуцлагыг дээшлүүлэх тогтолцоог бий болгох, урьдчилан сэргийлэх гэсэн энэ агуулгаар энэ шинэ хуульд маань тодорхой зохицуулалтууд бий болохоор тусгагдсан байгаа.

Энэ хүрээнд одоо байгаа Төрийн албаны хуульд байгаа сургалт, хөгжлийн асуудлыг нэлээн уялдуулж зохицуулахаар, ялангуяа ажлын байр, албан тушаалын шаардлагад тавигдаж байгаа сургалтуудын агуулга, хүрээг өргөжүүлэх байдлаар үүнийг зохицуулна гэсэн ийм зүйлийг бид харж байна.

Ажлын байран дээрх сургалт, ялангуяа харилцаа хандлагыг дээшлүүлэхэд энэ чиглэгдсэн байх олон төрөл, арга хэлбэртэй байх гэдэг дээр Төрийн албаны зөвлөл нэлээн өргөн хүрээнд ажиллаж байгаа.

Одоогийн хууль тогтоомжийн дагуу мэрэгшүүлэх, чиглүүлэх, дунд болон богино хугацааны сургалтын агуулгадаа бид манлайлал, хариуцлагыг дээшлүүлэх, мөн дүн шинжилгээ хийх гэх мэт энэ шийдвэр гаргахад шаардлагатай бусад ур чадваруудыг цогц чадамжийн хүрээнд бид суулгана гэсэн энэ асуудлыг тусгасан.

Мөн арга зүйн хүрээндээ бас улсын хэмжээнд нэгдсэн байдлаар **WEBINAR** сургалтыг бид тогтмолжуулж явуулж байгаа. Энэ сургалтын үндсэн агуулга бол одоо харилцаа хандлага, ёс зүй, хариуцлагаа дээшлүүлэхэд чиглүүлсэн ийм сургалтууд байгаа.

Бид өнөөдрийг хүртэл хийгдэж байгаа сургалтад маань энэ цахим сургалтынхаа хүрээнд 47500 гаруй албан хаагчдыг хамруулаад, үр дүнгээ тооцож ажиллаж байна.

Мөн энэ хариуцлага тооцох механизмыг хэрхэн яаж бүрдүүлэх юм бэ, зөрчлийн ялгаа, ялгамж нь ямар байх юм бэ гэдэг маань энэ шинэ хуулийн зохицуулалт дээр хэн хаана мэдээллээ гаргах, эргэж яаж хариуцлага тооцсоноо олон нийт болон иргэдэд мэдээлэх энэ зохицуулалтыг тусгаж өгсөн.

Ингэснээрээ бидний Төрийн албаны хуультай хамт нэгдсэн зохицуулалтад ороод бүтээмж гэж яриад байгаа. Ялангуяа тэр албан тушаалыг хариуцаж байгаа албан хаагч маань хэрхэн яаж үр дүн гаргасан бэ гэдэг энэ механизмыг нэгдсэн байдлаар зохицуулах боломж бүрдэнэ гэж бид тооцож байгаа.

Сургалт, хөгжлийнхөө асуудлын хүрээнд Удирдлагын академитай бид энэ хөтөлбөр, агуулгуудаа илүү өргөжүүлэх, ялангуяа бие даасан ёс зүйн чиглэлийн сургалтын хөтөлбөрийг бид бий болгоод эхэлж орж байгаа албан хаагчдад

хэрхэн ямар сургалтын чиглэл өгөх вэ. Дунд болон дээд түвшний албан тушаалтнуудад ажил, үүрэгтэйгээ холбоотойгоор ямар илүү өндөр шаардлага тавигдах вэ гэдэг сургалтын агуулгуудыг албан ёсны болгож оруулах ёстой гэдэг ийм байр суурьтай байгаа. Баярлалаа.

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Хууль санаачлагч.

Б.Бат-Эрдэнэ: Ж.Батжаргал гишүүн, бусад гишүүд маань хэлж байгаа.

Энэ төрийн албан хаагчдын эрх ашгийг хамгаалах, цаашлах юм бол нийгмийн баталгаатай холбоотой асуудлууд байна. Үүнийг цогцоор нь бусад хууль тогтоомжтой уялдуулж үүнийг шийдэх шаардлага байгаа байх гэж.

Төрийн албаны зөвлөлтэй бид энэ жил гаруйн хугацаанд нэлээн үр дүнтэй хамтран ажиллаж байгаа. Төрийн албаны зөвлөлийн тайланг Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо авч хэлэлцсэн. Тодорхой үр дүн гарчээ гэдэг ийм дүгнэлт ирүүлсэн. Үндсэндээ улсын хэмжээнд энэ 25-аас дээш албан хаагчидтай байгууллагууд Ёс зүйн зөвлөлөө байгуулсан. Миний түрүүний хэлдэг жишгийн дагуу байгуулаад ингээд үйл ажиллагаа нь үндсэндээ жигдэрч байна гэсэн ийм дүгнэлтийг бид хийсэн. Байнгын хороон дээр.

Нөгөө талынх нь юм бол энэ цалин, нийгмийн баталгаатай холбоотой юман дээр төр тодорхой бодлого гаргахгүй бол хуучин тогтолцооны үеийнх шиг хөдөлмөр, цалин хөлсний улсын хороо гэж бие даасан агентлаг, хороо хариуцаж байсан. Зүгээр тэр жишиг нь ямар байх юм. Гэхдээ ялгамжгүй тогтоохгүй бол болохгүй байна.

Ямар шалтгааныг мэдэхгүй байна. Үе үеийн парламент хамгийн түрүүнд шүүх. Энэ хуулийн байгууллага болгоны цалинг нэмээд л байдаг.

Ер нь нэгдсэн нэг тийм ойлголт байдаг шүү дээ. Боловсролдоо бага мөнгө зарах юм бол шоронд их мөнгө зарна гэж. Тэгээд энэ зарчмаар л бид яваад байгаа нэг ийм зүйл байна.

Хамгийн гол юм энэ төрийн албаны салбарын цалин хангамжийн ялгамжгүй байдлыг бид анхаарч үзэхгүй бол. Мэдээж инфляц, үнийн өсөлт гээд олон зүйл нөлөөлж байгаа. Гэхдээ энэ чинь суурь нөлөөлөөд байгаа зүйл чинь ийм зүйл байна шүү. Бодит байдал дээр суман дээр яваад очих юм бол одоо эмнэлэг, сургууль, багш, эмч нарын цалин яах вэ, их биш юмаа гэхэд тэр хэмжээнд хүрэлцэхээр байдаг. Нэг сая орчим төгрөг ч гэдэг юм уу, ингээд бодоход. Гэтэл чинь 500, 600 мянган төгрөгөөр төрийн албанд, энэ Тамгын газар, бүх шатанд төрийн албанд ажиллах хүн олдохгүй байна шүү дээ. Хүний нөөц, боловсон хүчинтэй холбоотой юм аа давхар анхаарах ёстой гэж. Тэгээд төрийн алба сэтгэлийн алба, нэр хүндийн алба.

Тийм учраас энэ хандлага, төлөвшил, ухамсрыг яаж суулгах юм бэ. Хуучин тогтолцооны үед жишээ нь Монгол Улсын Их Сургууль чинь Төв хорооны боловсон хүчин, хүний нөөцийн суурь нь байлаа шүү дээ. Одоо Төрийн албаны зөвлөлтэй бид яриад энэ ядаж төрийн өмчийн томоохон 6 их дээд сургуулиудтай ажиллая. Үнэндээ төрийн албанд авах хүмүүс авсан хойноо ажиллаж байгаа хүмүүсийн харьцаа, хандлагын тухай асуудлыг яриад сууж байна гэдэг бол үнэхээр харамсалтай асуудал байхгүй юу. Харьцаа хандлага, төлөвшлийн асуудал бол хүн өсөх үүр орчин тэр гэр бүлдээ олж авах ёстой. Сургуулийн өмнөх боловсролоос, бага сургуульдаа үүнийг ингээд цэгцэнд нь оруулаад тогтоод үүнээс хойш мэдлэг оюуныг хураах, мэргэжлээ, чадвараа эзэмших ийм зүйл рүүгээ явах ёстой шүү дээ. Тэгтэл Монголын нийгэм өнөөгийн байж байгаа байдал ийм байгаа.

Тийм учраас энэ бүх түвшинд нь нийгмийн соён гэгээрэл, харилцаа, хандлага, төлөвшил, энэ ёс зүйн асуудлыг бид нэг цогцоор нь авч үзэхгүй бол өнгөн талд нь л яриад байх ийм зүйл гарна гэж. Ийм зүйлийг би хэлье.

Тэгээд энэ салбарын нэг хууль орж ирэхээрээ зэрэг л ерөөсөө орон тоо, сандал ширээ, тэгээд цалин, тэгээд тэр салбарынхны нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг оочин цоочин хооронд нь өрсөлдүүлсээр байгаад бүр сэглээд бүр юугаа ч алдлаа шүү гэдгийг би энд бүр хэлмээр санагдаад байгаа юм.

Г.Занданшатар: Буланы Бейсен гишүүн. Жигжидийн Батжаргал гишүүн тодруулж асууна. 1 минут.

Ж.Батжаргал: Тийм ээ. Бид яриад тайлбар өгөөд байж болдог юм.

Энэ гарч байгаа эрх зүйн хэм хэмжээ, тогтоож байгаа акт дотроо л ярьж байгаа зүйлүүдээ яг бүрэн шингээж оруулахгүй бол үзэмжийн юм болж хувирна.

Тийм учраас тэр ажлын байран дээр нь хүнийг бэлтгэдэг, төлөвшүүлдэг, чадваржуулдаг, манлайлдаг тэр үйл явцаа шингээсэн хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэхээр л энэ хууль дотроо багтааж оруул. Тэгж байж наадах чинь улсын хэмжээнд нэг мөр ажил болж хэрэгжинэ. Өөр арга байхгүй. Бид тэрийг хийхгүйгээр энэ ёс зүй, сахилга хариуцлагын тухай ярихад нэн түвэгтэй. Үүнийг хэлмээр байна.

Хоёр дахь зүйл. Би бодоод байдаг юм. Энэ анагаахын чиглэл буюу манай эрүүл мэндийн салбарынхан боловсон хүчнээ их зөв тийм системтэй бэлтгээд байх шиг байгаа юм. Төгсгөөд нэг, хоёр жил ажиллаад резидент сургаад нарийсгаж мэргэшүүлээд ингээд яваад байна л даа.

Г.Занданшатар: Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Ж.Батжаргал гишүүний хэлж байгаатай санал нэг байгаа.

Бүх түвшинд нь хүнээ бэлтгэх, төлөвшүүлэх, чадваржуулах асуудлыг анхаарахгүй болохгүй байна. Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль 11 сарын 26-нд тусгаар тогтнолын баярын өдөр намайг урьж эрдмийн хамт олон, оюутнуудтай, хамт олондоо лекц яриа хийлгэсэн. Тэнд шинэ эхлэлийг тавьчихсан байгаа асуудал. Тантай санал нэг байгаа гэдгийг хэлье.

Ер нь бид энэ хуулиар өмнө нь явж ирсэн нэг муу жишиг бол энэ дарга нар, өөрийнхөө харьяанд ажиллаж байгаа албан тушаалтнуудыг дарамтлах нэг ийм хэрэглүүр маягаар явж ирсэн. Одоо тэгвэл энэ хуулийн зохицуулалтаар бид бүх түвшинд ижил ёс зүй.../минут дуусав/

Г.Занданшатар: Одоо Буланы Бейсен гишүүн.

Б.Бейсен: Төрийн алба хаагчийн ёс зүйн тухай хуулийн төслийг дэмжиж байгаа юм.

Гэхдээ хэд хэдэн асуудал байна аа, энд асуух. Төрийн албан хаагчдыг ялгаварлан гадуурхдаг, намын харьяаллаар халдаг, чадваргүй боловсон хүчнээр сольдог тийм асуудлууд их байна хөдөөд. Энэ талаар одоо ямар арга барилтай ажиллаж байна. Хариуцлага тооцож байгаа юу? Ялангуяа энэ орон нутагт байгаа энэ. Аймаг, сумын түвшинд. Чадварлаг боловсон хүчнүүдээ халчихдаг.

Сая Ж.Батжаргал гишүүний асуудгаар тэд нарыг хамгаалдаг хуулийн төсөл байна уу, ер нь. Дараа нь нэг чадваргүй улсууд оччихдог. Ёс зүйгүй, харьцааны соёлгүй тийм улсад оччихоод ийм асуудлууд байж байгаа юм.

Нөгөө талаар энэ төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм ерөөсөө хэрэгжихгүй байна. Хэрэгжүүлдэггүй. Ёс зүйгээ ноцтойгоор зөрчдөг асуудлууд байж байна. Төрийн сүлд нь өмнө ёс зүйн ноцтой алдаа гаргасан улсууд ч байж байгаа. Би саналаа хүргүүлсэн. Одоо хүртэл арга хэмжээ аваагүй байж байгаа. Гэтэл тэнд төрийн нэр хүндийг дордуулсан, аймаг сумандаа нэр хүндгүй улсууд ч байж байна. Энэ талаар ямар арга хэмжээ авч байна?

Сая төрийн албанд 1080-аад хүн төрийн албаны шалгалтгүйгээр томилогдсон байна шүү дээ. Хөдөөд энэ улсууд халагдаагүй шүү, дарга аа. Ажлаа хийж л байгаа.

Нөгөө талаар энэ төрийн үйлчилгээний албан хаагчид, сургууль, цэцэрлэг, энд ямар ч ур чадваргүй, боловсролгүй улсууд, манлайлах чадваргүй улсууд тавигдчихаад байна.

Төрийн албаны шалгалт тэнцсэн улсууд орж чадахгүй байна. Энэ тал дээр анхаарахгүй байна. Ялангуяа эмнэлгийн салбарт мэргэжлийн мэдлэгтэй, тухайн салбартаа хүндлэгддэг, эмч ажилтан хүндэлдэг хүнийг тавихгүй бол

намын харьяаллаар хүн тавьчихдаг. Нөгөөдөх нь ур чадваргүй. Нарийн мэргэжлийн юмыг эзэмшиж, шаардлага тавьж чаддаггүй улсууд томилогдоод байна.

Энэ асуудал дээр эрүүл мэнд, боловсролын салбар дээр ямар бодлого баримталж байна? Цаашдаа энэ талаар хуулийн төсөл дээр юу оруулах уу?

Энэ төрийн албан хаагчдын алдаа дутагдал гээд түрүүн ярьж байна. Гол нь ямар алдаа дутагдал, ноцтой алдаа дутагдал байна уу? Хуулийн байгууллагаар шалгагдаж байгаа юм байна уу?

Нөгөө талаар энэ ажлаасаа намын харьяаллаар ялгаваран гадуурхах тийм юмаараа халчхаад, тэгээд их хэмжээний эдийн засгийн хохирол учруулж байгаа асуудал шүү. Нөгөөдөх зардлыг нь эргэн төлдөг, төрөөс төлдөг ийм асуудлууд байж байна. Энэ тал дээр тодорхой тоо байна уу? Тэрийг асууя.

Г.Занданшатар: Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуун. 92.

Б.Идэрчулуун: Б.Бейсен гишүүний асуултад хариулъя.

Таны яриад байгаатай санал нэг байна. Тэгэхдээ бид үүнийг ганцхан ёс зүйн хуулиар бүх ярьж байгаа асуудлыг чинь зохицуулахгүй. Энэ нэг суурь зохицуулалтын нэг болно гэдгийг дахиад хэлэх байна.

Түрүүн хууль санаачлагч гишүүн хэлнэ лээ. Энэ хуулийн 8 дугаар зүйл дээр төрийн албан хаагчдад тавих ёс зүйн нийтлэг шаардлага гээд дотор нь таны ярьж байгаа энэ яс, үндэс угсаа, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй гэсэн энэ суурь зарчим нь явж байгаа.

Үүнтэй холбогдолтой өргөдөл, гомдол ирж байгаа юу? Ирж байгаа. Үүнийг бид ёс зүйн зөрчлөөс хальсан энэ зөрчлийг хууль хяналтын байгууллагад нь шилжүүлж байгаа. Заавал энд тодорхой жишээ дурдах шаардлагагүй байх. Захаас нь эрүү үүсгэгдээд шалгагдаад, шийтгэгдээд явсан ч бий. Шат шатандаа хариуцлага тооцоод ингээд явсан юм бий.

Энэ ялгаварладаг асуудал нэгэнт ярьж байгаа учраас үүнийг намууд сонгогдож томилогдсон Улсын Их Хурлын гишүүд, Засгийн газрын гишүүд энэ төрийн жинхэнэ албан хаагчийн томилгоонд илт оролцдог энэ юм чинь арилаагүй байгаа учраас энэ асуудал яваад байгаа шүү. Энэ бол бүр ил тод байгаа. Их Хурлын гишүүнээр сонгогдонгуутаа сумын цэцэрлэг, сургуулийн цэвэрлэгчийг хүртэл тэрийг томил, энийг томил гэдэг чиглэл өгдөг. Энэнээс чинь болж энэ яваад байгаа.

Тэгэхээр тэр намуудын тухай хуульд бас өөрчлөлт орохоороо энэ нь цэгцрэх байх.

Ёс зүйн дүрэм хэрэгжихгүй байна гэж байна. Энэ бол тухайн байгууллага, тухайн байгууллагыг удирдаж байгаа Ёс зүйн зөвлөлтэй л холбоотой болохоос биш нийтээр нь ингэж харлуулж болохгүй.

Манайх бол одоо 2019 онд энэ бүрэлдэхүүн байгуулагдсанаас хойш Ёс зүйн зөвлөл байгуулах асуудал нийтээр жил болгон тоо нь өсөөд ёс зүйн зөрчлүүд урьд нь шийдэгдэхгүй өнгөрдөг байсан бол ёс зүйн зөрчил шийдэгддэг болоод ингээд явж байгаа.

Төрийн үйлчилгээнд чадваргүй, чансаагүй улсууд тавигдаж байна. Намын харьяаллаар тавигдаж байна гэдэг нь нэг дэх асуултынхаа хариулттай ингээд хариулагдчих байх гэж ойлгож байна.

Бид алдаа, энэ гарч байгаа хүндрэлүүдийг засаж залруулахад үнэхээр энэ хэлэлцэх эсэх асуудлаа шийдээд энэ хууль цаашаа явахаар болбол энэ ажлын хэсэгт сонирхсон гишүүд орох байх. Дээр нь мэргэжлийн хүмүүсийн туслалцаа орно. Тэгээд энэ шийдэх харьяалал, байх бүрэлдэхүүн, зохион байгуулалт. Энэ тодорхой болно гэж ойлгож байна. Баярлалаа.

Уучлаарай. Энд төрд учирсан хохиролтой холбоотой тоо асууна лээ. Би одоо энд хэлье. Төрийн албан хаагчийн эрх ашгийг хамгаалж бид шийдвэрийг нь хүчингүй болгосон 2022 оны 14, 2021 оны 30, 2020 оны 14 гээд нийт 64 төрийн албан хаагчийн эрх ашгийг хамгаалж үлдсэн байна. Төрийн албаны тухай хуулиараа.

Төрд учирсан хохирлын тухайд энэ дураар авирладаг албан тушаалтнуудын үлдээж байгаа ул мөр 738.7 сая төгрөг. Энэ бол Шүүхийн ерөнхий зөвлөл, Шийдвэр гүйцэтгэлээс авч байгаа тоо. Төрийн албан хаагчийг хууль бусаар халсан, чөлөөлсөн, түр чөлөөлсөнтэй холбоотой төрд учирсан хохирлын тоо. Үүнээс Төрийн албаны зөвлөл бүртгэл хөтлөөд, энд хяналт тавиад 331.7 сая төгрөгийг шүүхэд нэхэмжилээд явж байна. Үүнээс одоо шүүхийн шийдвэр гараад төлөгдөх шатандаа 150 сая.../минут дуусав/

Г.Занданшатар: 13.00 цаг болсон байна. Энэ чухал асуудал хэлэлцэж байгаа учраас 14.00 цаг хүртэл завсарлаад. 14.00 цагт ирцээ бүрдүүлээд чуулганы хуралдааныг үргэлжлүүлнэ. Чуулган түр завсарлалаа.

З А В С А Р Л А Г А

Наадах чинь тэр Японы хуулиас л хуулсан юм билээ. Японы хууль дээр байна шүү дээ, төрийн албан хаагч бол ард түмний зарц учраас зарц. Яг агуулгаараа “үйлчлэгч” гэсэн ханзаар. Үйлчлэгч учраас төрд итгэх ард түмний итгэлийг хангах үүрэг нь.

Улсын Их Хурлын гишүүдийн энэ өдрийн амгаланг дахин айлтгая. Өдрийн мэнд дэвшүүлье. 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн чуулганы нэгдсэн хуралдааны үдээс хойш хуралдаан нээсний мэдэгдэе.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт төрийн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг үргэлжлүүлэн хэлэлцэнэ.

Ажлын хэсгийг оруулъя. Асуулт хариулт үргэлжилнэ. Эрхэм гишүүн Баттөмөрийн Энхбаяр асуулт асууна.

Б.Энхбаяр: Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийг хэлэлцэж байна.

Энэ анх Их Хурлын гишүүн байсан манай С.Төмөр багш 1998 онд. Одоо энэ Ж.Сүхбаатар гишүүн миний урд сууж байна. Туслах нь байсан. Анх нооргыг нь гаргаж байсан юм. Би оюутан байсан.

Тэгээд магистрын ажил бас энэ чиглэлээр хийж байсан юм. Тэгээд судалж судалж байгаад миний хувьд бол нэг ийм дүгнэлтээр 2000 онд төрийн албан хаагчийн ёс зүйн ном гаргаад дүгнэлт нь сүүлийнхээ өгүүлбэртэй хэлсэн юм.

Одоо манай Г.Занданшатар дарга шатар тоглодог. Шатарт бол эхний эгнээний хүүхэд хүүнүүд хамгийн түрүүнд идүүлдэг. Тэгэхдээ тэд хожих нөхцөлийг бүрдүүлдэг гэж. Өөрөөр хэлбэл энэ санаа нь юу гэсэн үг вэ гэхээр бид бүх зүйлийг хуулийн аргаар хүчиндээд бүтэлгүйтнэ. Энд хүн илүү, хүний үлгэрлэл үйлдэл, манлайллаар л энэ ёс зүй гэдэг юм биеждэг юм байна гэдэг л дүгнэлтийг л аминдаа хийсэн ухаантай юм л даа.

Тэгэхээр хууль санаачлагчаас юу гэж асуух гэж байна вэ гэхээр ёс суртахуун, ёс зүй, хууль гурав ямар ялгаатай вэ гэсэн эхний асуулт байгаа юм. Хууль санаачлагч бол хэлж байгаа. Бүх төрийн албаны, тэр дотроо улс төрийн албан тушаалтнуудыг хүртэл оролцуулаад нэг ийм ёс зүйн кодексоор хайрцаглахгүй болохгүй байна гэдэг гол үзэл баримтлалаа хэлээд байгаа юм.

Би үүний яг эсрэг бодолтой байдаг хүн. Жишээлбэл, улс төрийн ёс зүй гэж тусдаа байдаг юм. Улс төрч хүний ёс зүй гэдэг бол тусдаа. Шүүгч хүний ёс зүй гэдэг бол тусдаа байдаг юм. Жишээлбэл, бид Шүүхийн тухай хуульд шүүгч хүн хэргийн оролцогчтой бэлгийн харьцаанд оролцож болохгүй гэж бичсэн хууль гаргасан. Энэ бол зөвхөн шүүгчид яригдаж байгаа юм. Ийм өндөр шаардлага. Магадгүй энэ нэг бодлын хайр дурлал, сэтгэлийг зохицууллаа гэж байж магадгүй. Зөвхөн шүүгч дээр яригдаж байгаа юм.

Улс төрч нөхөр ингэчихэж байна. Доллар мянга болно гээд л ярьчхаж байгаа шүү дээ. Худлаа яриад байгаа юм уу, хүн хошигируулаад байгаа юм уу. Үүнийг чинь яг юу гэж үзэх вэ? Бүгд ялгаатай байдаг.

Тэгэхээр нэг уутанд хийчихээр их сонин болчихоод байдаг юм. Тухайлбал, хуулийн төслийн 6 дугаар зүйлд “төрөө дээдлэх ард түмний итгэлийг эрхэмлэнэ” гэж байгаа юм. Энэ ер нь төрөө хайрла гэсэн үг л дээ. Тэгээд хайрлаагүй төрийн албан хаагч одоо энэ хуулийг зөрчсөн гээд огцрох уу?

7.1-д “ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилнэ” гэж байгаа юм. Манай төрийн албаны хуульд ард түмэндээ үйлчлэх гээд байгаа л даа. Одоо ч байгаа. Бүх хуульд байгаа. Ер нь.

Энэ ёс зүйн хуульд юу орж ирж байна вэ гэхээр “чин сэтгэлээсээ үйлчилнэ” гэж байна. Үүнийг яаж барьж хэмжих вэ? Энэ баригдах уу?

Төрийн албаны үйл ажиллагаанд итгэл алдах, хардахад хүргэх, аливаа үйлдэл, эс үйлдлээс зайлсхийх гэж. 8.1.1.б. Энэ заалтыг ер нь юу гэж ойлгох вэ? Би бол нэг бодлоор ойлгож л байна. Энэ хүн болгон өөр өөрөөр ойлгогддог байхгүй юу. Ёс суртахуун чинь.

Г.Занданшатар: Хэн хариулах уу? Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Хууль санаачлагч хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Б.Энхбаяр гишүүн сая тодорхой санал хэлсэн. Асуулт асуусан. Манай парламентын, ер нь Монголын урдаа барьдаг л ийм залуу хуульчдын төлөөлөл, Хууль зүй дотоод хэргийн яамны дэд сайд, бүлгийн ажлын алба, Их Хурлын гишүүнээр ингээд ажиллаж байгаа.

Та өөрийн чинь оюутан байхдаа Хууль зүйн сургуульд сурч байхдаа судалгааны чинь гол чиглэл, ёс зүйн асуудал дээр л төвлөрч ажиллаж байсан юм байна. Энэ их чухал.

Хууль, нийгмийн харилцааг зохицуулсан хэм хэмжээ тогтоох энэ хүрээнд ойлгогдоно гэж ингэж үзэж байгаа. Ёс суртахууны хэм хэмжээ гэдэг бол хүн төрөлхтөнд, ялангуяа энэ дорно дахины ард түмнүүдэд тогтсон ийм ойлголт. Өргөн хүрээнд.

Тантай санал нэг байгаа. Одоо ч хүн төрөлхтөн нэг мөр ойлголтод хүрч чадаагүй олон асуудлууд бий. Философийн асуудал, аз жаргал. Тухайлах юм бол аз жаргал гэж юу вэ гэж авч үзэх юм бол өнөөдөр ч маргаантай гэдэг юм уу, ихээхэн хэмжээний судлагдахууны талбар болсон ийм асуудал байдаг.

Ёс зүйн асуудал бол нийтлэгээр нь тогтсон тэр хэм хэмжээ гэж ингэж ойлгож болно гэж би боддог. Энэ талаасаа аваад үзэх юм бол дорно дахины ард түмнүүдэд хуримтлуулсан их туршлага байна. Дорно дахины ард түмнүүдийн бүтээсэн соёл гэдэг бол бие даасан. Хүнтэй нь аваад үзэх юм бол ерөнхийдөө дэлхийн улс орнууд, тэр дундаа энэ дорно дахины нэн эртний энэ соёл, уламжлалтай ард түмнүүд бол энэ ёс суртахуун, ёс зүйн асуудлыг их

эрхэмлэж үүнийгээ хуульчлах ийм хандлага байгаа. Энэ талаас нь энэ хуулийн төслийг боловсруулах ажлын хэсэг нэлээн тогтож, олон улс орнуудын хууль эрх зүйн асуудлыг үзсэн. Энэ ном товхимол гаргасан. Энэ дээрээс аваад үзэх юм бол ер нь дэлхийн 34 улс орны парламентаас тогтоосон энэ ёс зүйн код, ёс зүйн дүрэм, цаашилбал бие даасан энэ ёс зүйн хуультай улс орнуудыг үзсэн. Тэгээд энэ парламентат ёс хөгжсөн, тэр дундаа хөгжиж байгаа улс орнууд, хөгжингүй улс орнууд, түүнчлэн Европын Холбооны улс орнуудын ийм жишиг туршлагыг харгалзаж үзсэн юм байна лээ. Тэгээд энэ бүх материал дээр хууль санаачлагчийн зүгээс нэлээн ажилласан.

Үүнтэй зэрэгцүүлээд олон улсын байгууллагууд, Нэгдсэн Үндэстний Байгууллага, түүнчлэн Европын зөвлөлөөс гаргасан уриалга, зөвлөмж, чиглэлийг бид анхааралтай авч үзсэн.

Өнөөгийн Монголын нийгэмд нэн тэргүүнд тулгамдаад байгаа асуудал бол энэ ёс зүйн асуудал байна гэж ингэж үзэж, тэгээд өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа төрийн албаны хууль, бусад хууль эрх зүйн хүрээнд зохицуулалт хангалтгүй байна.../минут дуусав/

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн тодруулж асууна. 1 минут.

Б.Энхбаяр: Нэмээд нэг хуулийн тодорхой гурван заалтаас асууя.

7.1.5.төрийн албан хаагч аливаа улс төрийн эвсэл, хөдөлгөөн, намын нөлөөллөөс ангид байх гэж байгаа юм.

Тэгэхээр нөлөөллөөс яаж ангид байх вэ? Зурагт үзэж болж байна уу, үгүй юу? Улс төрчийн твиттер хаягийг дагаж болж байна уу, үгүй юу.

Хоёрдугаарт, 8.1.6.албаны харилцааны хэвийн уур амьсгалыг алдагдуулахгүй байх. Энэ хов базаж болж байна уу, үгүй юу?

Гуравдугаарт, 8.1.7.төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг эсэргүүцэх үг, үйлдэл, зан байдлаараа илэрхийлэхийг хориглож байгаа.

Энэ хориглогдсон албан тушаал бол одоо зэвсэгт хүчин, цагдаа бол ажил хаялт хийхийг хориглодог.../минут дуусав/

Г.Занданшатар: Хариулт хангалтгүй бол дахиад тодруулж болно.

Төрийн албаны зөвлөл. Б.Баатарзориг 94. С.Цэдэндамба гуай хариулъя. Доктор С.Цэдэндамба. Төрийн албаны зөвлөлийн гишүүн.

С.Цэдэндамба: Б.Энхбаяр гишүүн ёс суртахуун, ёс зүй, хууль гурав ямар хамааралтай вэ гээд асуугаад байна л даа.

Зүгээр энд өөрийнхөө ойлголтоор хариулъя. Мэдээж гурвуулаа хоорондоо огтлолцох гэдэг юм уу, юуны хэлээр бол огтлолцох харилцаатай буюу хамааралтай.

Ёс суртахуун хувь хүний зан араншин, зан харилцаа, зан үйл. Энэ зан үйл нь тэр нийтээр хүлээн зөвшөөрч байгаа тэр нийтлэг зан үйлтэй нийцэж байна уу, нийцэхгүй байна уу. Бусад хүмүүсийн тэр үнэлэмжтэй, нийгмийн нийтлэг үнэлэмжтэй нийцэж байна уу, үгүй юу гэдэг талаас нь ярьж.../минут дуусав/

Г.Занданшатар: Баттөмөрийн Энхбаяр гишүүн тодруулж асууя.

Б.Энхбаяр: Тэгэхээр төрийн албан хаагчийн хувьд хуулиар тогтоосон иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг эсэргүүцэж, эсэргүүцэх үг, үйлдэл, зан байдлаараа илэрхийлэхийг хориглоод байгаа юм.

Энэ юу вэ гэхээр төр засгаа шүүмжилж болохгүй. Одоо ингээд юмны үнэ өсөөд байна гээд тэгэнгүүт цагдаа хийдэг албан хаагч үүнийг эсэргүүцэж болохгүй. Бүр зан байдлаар илэрхийлж болохгүй гэж байна шүү дээ. Энэ чинь мушийж болох уу, үгүй юу? Одоо нэг тийм хууль тогтоогч буруу зөрүү юм яриад байнгуут нь тэрийг нь жоохон мушийгаад инээмсэглэчихэж болж байна уу, үгүй юу? Тэгээд мушийж байгаад хаагдчих юм биш биз дээ. Энэ хуулиар чинь хариуцлага тооцно гээд байгаа шүү дээ.

Г.Занданшатар: 94. Доктор С.Цэдэндамба. Төрийн албаны зөвлөл.

С.Цэдэндамба: Түрүүчийнхээ хариултыг жоохон үргэлжүүлээдэхье. Тийм. Ёс зүй бол энэ ёс суртахууны судлал юм л даа. Нэг ёсондоо институт юм. Ийм ойлголт.

Тийм учраас ёс зүй бол дотроо ингээд нийтлэг ёс зүй, иргэний ёс зүй, мэргэжлийн ёс зүй гээд ингээд. Өнөөдөр бид энэ дотроосоо төрийн албан хаагчын ёс суртахууны асуудал бол энэ төрийн албаны ёс зүй гэдэг утгаар яригдаж байна гэж.

Энэ зан үйлүүд тэр хоорондын харилцаагаар зохицуулагдахгүй бол төрийг зохицуулах албадлагын арга хэмжээ байдаг. Тэр нь хууль.

Тэгэхээр аливаа хуулийн үндсэн нэг функц бол нийгмийн харилцааг журамлах, зохицуулах. Энэ чиглэлээр яригдаж байгаа гэж ойлгож байгаа. Зүгээр өнөөдрийн хууль бол яг энэ төрийн албан хаагчийн үйлдэл болгоныг энэ хууль дотор оруулах уу, үгүй юу гэдэг бол.../минут дуусав/

Г.Занданшатар: Хууль санаачлагч Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн.

Б.Бат-Эрдэнэ: Бид 2 дугаар бүлэг дээр төрийн албан хаагчийн эрхэмлэх үнэт зүйл, ёс зүйн нийтлэг хэмжээ, шаардлага гээд бүлэг оруулсан л даа.

Тэгээд төрийн албан хаагчийн 6 дугаар зүйлд төрийн албан хаагчийн эрхэмлэх үнэт зүйл, 6.1.төрийн албан хаагч нь дараах үндсэн зүйлсийг эрхэмлэн дээдэлнэ. 6.1.1.Монгол Улс, үндэстний язгуур ашиг сонирхол.

Энэ бол тогтсон өөрчлөгдөхгүй ойлголт байх л даа.

6.1.2.Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулиар баталгаажуулсан хууль дээдлэх ёс. Энэ мөн адил.

6.1.3.хүний эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүнд. Энэ ойлгомжтой.

6.1.4.Монголын төрт ёс, түүх соёлын уламжлал.

6.1.5.төрөө дээдлэх ард түмний итгэл гээд.

Цаашилбал 7 дугаар зүйлд төрийн албан хаагчийн ёс зүйн нийтлэг хэм хэмжээ байгаа. Цаашилбал төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага гээд 8 дугаар зүйл байгаа. Үүнийг Улсын Их Хурал хэлэлцэх эсэхийг нь шийдсэний.../минут дуусав/

Г.Занданшатар: Гүйцээгээд хариулчихъя. Б.Бат-Эрдэнэ гишүүн гүйцээж хариулна.

Б.Бат-Эрдэнэ: Энэ хуулийг Улсын Их Хурал хэлэлцэх эсэхийг нь шийдсэний дараагаар манай гишүүд, ажлын хэсэг илүү нарийвчилж, энэ нийтлэг хэм хэмжээ, нийтлэг шаардлагууд дээр нэмэх, хасах зүйл нь ямар зүйл байж болох вэ, үг үсэг, найруулгын хувьд ямар ямар асуудлыг оруулж болох вэ, хасаж болох вэ гэдгийг ярилцах бүрэн бололцоотой л доо.

Энэ дээр Б.Энхбаяр гишүүнийг би идэвхтэй оролцож ажиллаасай гэж ингэж хүсэж байна. Баярлалаа танд.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Батсүхийн Саранчимэг асуулт асууна.

Б.Саранчимэг: Баярлалаа.

Тэгэхээр төрийн албан хаагчдын мэргэжил, ёс зүй, хүнд суртал, хариуцлагын талаар нэлээн шүүмжлэл дагуулж байгаа энэ цаг үед төрийн албан хаагчдын ёс зүйн хуулийн төсөл орж ирж байгаа нь нэлээн ач холбогдолтой.

Тийм учраас дэмжиж байгаа юм. Олон хууль дүрэмд энэ төрийн албан хаагчдын ёс зүйн талаар орсон байдаг. Гэхдээ үүнийг нэгдмэл байдлаар энэ

суурь зохицуулалтуудыг тусгасан хуулийн төсөл боловсруулагдан орж ирж байгаа нь сайшаалтай. Эндээс нэг тодруулах зүйлүүд байгаа юм.

Тэгэхээр энэ ер нь энэ хууль батлагдсанаар тогтвортой, хариуцлагатай, ёс зүйтэй төрийн алба төлөвшиж төрийн албанд итгэх иргэдийн итгэл нэмэгдэнэ гэсэн байна.

Ер нь энэ төрийн албанд итгэх иргэдийн энэ итгэл ёс зүй, хариуцлага алдсан албан тушаалтанд хариуцлага ялгавартай тогтоодог, зарим зөрчил хэрэг тодорхойгүй, замхардаг учраас би итгэл буурч байгаа гэж харж байгаа юм.

Ёс зүйн хариуцлагын зөрчил гаргасан төрийн албан хаагч аливаа нөлөөлөл бусад зүйлээс хамаарахгүйгээр энэ хуулийн төслийн дагуу хариуцлага хүлээх ийм тогтолцоогоо бүрдүүлж чадсан уу гэсэн ийм эхний асуулт байна.

Дараагийн асуулт бол энэ төслийн 4.3-т төрийн тодорхой чиг үүргийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж байгаа төрийн бус байгууллагын удирдах албан тушаалтанд тавигдах ёс зүйн хэм хэмжээ, гомдол гаргах, хянан шийдвэрлэх асуудлыг гэрээнд тусган зохицуулна гэж орж ирсэн байна.

Тэгэхээр энэ төрийн байгууллагууд зөвхөн төрийн бус байгууллагын удирдах ажилтан гэлтгүй иргэнтэй ингэж гэрээ хийж ажил гүйцэтгэдэг.

Тэгэхээр энэ иргэнтэй хийж байгаа гэрээ нь түүний мөрдөх ёс зүйн хэм хэмжээний талаар тусгагдсан байгаа юу? Зарим асуултууд давхардсан учраас энэ хоёр асуултыг асууя.

Нөгөө талаар бас энэ төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн талаар Ёс зүйн хороо, Ёс зүйн зөвлөлд гомдол мэдээлэл гаргасан тохиолдолд хянан шийдвэрлэх үү? Одоо ёс зүйн зөрчил гаргасан тохиолдолд энэ гомдол, мэдээлэл гаргаагүй бол яах вэ? Энэ асуудлыг яаж зохицуулахаар орж ирсэн байгаа вэ? Баярлалаа.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Төрийн албаны зөвлөл. Ц.Амартөгс 95. Төрийн албаны зөвлөлийн гишүүн.

Ц.Амартөгс: Гишүүний асуултад хариулъя. Энэ яг ёс зүйн асуудлаар гаргаж байгаа зөрчлийн ялгаа, ялгамжийг тогтоогоод энэ ялгамжтай тогтоосон гаргаж байгаа зөрчилд нь ногдох хариуцлагыг тухайн шат болгонд нь тооцдог, эргээгээд энэ тооцсон, хариуцлага тооцсон тухай мэдээллийг ил тод мэдээлэх, ингэснээрээ дараа дараагийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, мөн ижил тэгш үйлчилж хариуцлага тооцогддог байдал илүү сайжирна гэдэг энэ агуулгаар хариуцлага тооцох механизм, гомдол, маргаан хянан шийдвэрлэх процессууд одоогийн төсөлд тусгагдсан байгаа.

Тэгэхээр энэ хууль батлагдсанаар бидний хүлээж байгаа үр дүн нь ёс зүйн хэм хэмжээг илүү нарийвчлан зааж өгөөд энэ хэм хэмжээг мөрдөж ажиллаагүйгээс болж гарч байгаа үр дагаврыг багасгах, сөрөг үр дагаврыг бууруулах, тэдгээрт тооцсон хариуцлагыг ил тод байлгах ийм үр дүнг бид хүлээж байна.

4.3-т заасан төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, хуулийн этгээдэд энэ бол нэгэн ижил үйлчлэхээр хүрээг нь тодорхойлж өгөх зохицуулалт орох байх.

Яагаад гэвэл энэ маань төрийн нэрийн өмнөөс төрийн үйлчилгээ болон зарим чиг үүргийг хэрэгжүүлэх эрхээ аваад эргээгээд энэ маань төрийн албан хаагчидтай ижил ажил үүргийг хариуцлагыг хүлээж ажиллах, төрийн төсөв зарцуулагдах ийм боломж бололцоог бүрдүүлж байгаа.

Ёс зүйн зөвлөлүүд мөн харьяаллыг илүү тодорхой болгож ямар асуудлыг аль хороо болон зөвлөл дээр шийдвэрлэх вэ гэдгийг тогтоож оруулах ийм зохицуулалтуудыг тусгасан. Хэрвээ энэ Ёс зүйн зөвлөл, хороогоор шийдвэрлэгдэх асуудлууд нь зөвхөн төрийн албан хаагч биш бас иргэдээс гаргаж байгаа гомдол, санал, маргаан, мөн тодорхой асуудлуудыг авч хэлэлцэх ийм бололцоотой болсон байгаа.

13.3 дахь заалт дээр харьяаллыг мөн илүү тодотгож өгсөн гэж ингэж үзэж байна.

Г.Занданшатар: Одоо Цэндийн Сандаг-Очир гишүүн асуулт асууна.

Ц.Сандаг-Очир: Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Өнөөдөр манай төрийн албан хаагчид гэдэг бол асар өндөр шалгуур, шаардлагын доор асар их ачаалалтай, тэгсэн хэрнээ нийгэмд хамгийн доогуур цалин авч байгаа ийм л хүмүүс болж хувирчхаад байгаа л даа.

Тэгээд төрийн өндөр босго байх ёстой, шалгуур өндөр байх ёстой гээд төрийн хяналтын хуулийн нэрийн доор ингээд ажиллах орчин нөхцөлийг хязгаарлаад, тэгээд түүнтэйгээ таарсан цалин хангамж авч байгаа юу гэвэл харин тийм биш байгаа.

Тэгээд энэ төрийн албан хаагчийн ёс зүйн хууль орж ирж байна. Энэ хуулиар төрийн албанд ёс зүйтэй хүнийг авах тухай яриад байна уу, төрийн албанд орсон хүнийг ёс зүйтэй байлгах асуудлыг яриад байна уу гэдэг асуудал. Ёс зүйн асуудал өөрөө хүний хүмүүжил төлөвшлийн асуудал. Тэгээд төрийн алба өөрөө ийм стандарттай байх ёстой. Энэ стандартын хүрээнд ажиллаарай гэдэг энэ талаас нь ярьж байгаа болов уу гэж ойлгож байна.

Тэгээд 20 хүртэл насандаа хүмүүжсэн хүнийг төрийн албанд орж ирээд ёс зүйтэй байлгах гээд хүмүүжүүлэх гээд байвал хэтэрхий өрөөсгөл байх.

Тийм учраас Та бүхэн энэ тал дээр нэг хариулж өгөөч ээ гэж. Нөгөө талаар шаардлага, шалгуур өндөр болохын хэрээр энэ төрийн албанд сонгон шалгаруулж авч байгаа шалгалт, сонгон шалгаруулалт чинь энэ хуулиар хэрхэн яаж зохицуулагдаж байгаа вэ. Энэ хүрээнд авч үзэж байгаа юу?

Би хувьдаа энэ төрийн албан хаагчийг сонгон шалгаруулалтын энэ хууль дүрэм, журмаа өөрчлөх цаг болсон юм байна л гэж харж байгаа юм. Та бүхний яриад байгаа энэ ёс зүйн асуудал чинь явж явж эцэстээ төрийн албан хаагчийг анхнаас нь сонгон шалгаруулж авах энэ шалгалтад чинь ерөөсөө маш бүдэг байгаа шүү дээ.

Төрийн албан хаагчийн сонгон шалгаруулалтын авч байгаа тэр 90 минутын шалгалт чинь тэр ерөнхий мэдлэгийн шалгалт байгаа. Ерөнхий мэдлэгийн. Монгол хэлний, компьютерийн, англи хэлний гэх мэтчилэн.

Тэгээд тусгай шаардлагууд байгаа. Энэ 30 тест бөглөж байгаа шалгуур тестэд чинь тухайн хүний хэн бэ, ямар ёс зүйтэй вэ гэдгийг нотолж чадахгүй байгаа байхгүй юу. Энэ шалгалтаар чинь. Энэ хүн төрийн албанд тэнцэх ёс зүйтэй хүн мөн гээд энэ шалгуур хэзээ гэхээр цаг хугацааны хувьд доод тал нь жил ажиллаж, дагалдан ажиллаж, үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байж тэр хүний мөн чанар, ёс зүй харагдаж танигдана. Түүнээс 90 минутад авсан 30 онооны текст дээр тестээр авсан шалгалтад тэр хүнийг төрийн албанд тэнцэж байна, тэнцэхгүй байна гэдэг асуудал өрөөсгөл ойлголт байгаа юм.

Тийм учраас энэ төрийн албаны шалгалттайгаа холбогдуулж энэ хуулиар ямар нэгэн өөрчлөлт юм орж ирэхээр туссан уу, үгүй юу гэдгийг.

Дараагийн ээлжид дарга болгон л, гишүүн болгон л төрийн алба нүсэр хүнд болсон, хүнд сурталтай болсон л гэж яриад байгаа юм. Энэ төрийн албан хаагч нарт буруу биш шүү дээ. Төрийн албан хаагч нар төрийн албыг данхар бүтэцтэй болгоогүй шүү дээ. Бүтэц орон тоог нь хэн баталдаг юм. Улсын Их Хурал, Засгийн газар л баталж байгаа шүү дээ.

Нийгмийн хэрэгцээ шаардлагын хүрээнд олон сургууль, цэцэрлэгүүд бий болж байгаа. Шинээр байгуулагдаж байгаа. Тэнд чинь төрийн албан хаагч нар ажиллаж байгаа юм.

Нөгөө талаар хүнд суртал гэж байгаа юм. Тухайн иргэн, хуулийн этгээдээс өргөдөл, гомдол, санал хүсэлт ирээд 30 хоногийн хугацаанд шийдвэрлэх ёстой. Гэтэл одоо төрийн алба өнөөдөр хэчнээн төрлийн үйлчилгээг төр өөрөө төрийн албан хаагчаараа дамжуулж үзүүлж байна вэ? Нийтдээ. Тэр ажлын байрны тодорхойлолт болгон тэр тухайн асуудлыг ямар хугацаанд ажлын байрны тодорхойлолт.../минут дуусав/

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Мөнхөөгийн Оюунчимэгийн урилгаар Чингэлтэй дүүргийн ерөнхий боловсролын 50 дугаар сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс хүүхдүүд Та бүхэнд сурлагын өндөр амжилтыг хүсэн ерөөж, амьдралынхаа хаалгыг нээж, шинэ замд орох гэж байгаа Та бүхнийг нэн хариуцлагатай энэ үедээ зөв шийдвэр гаргаж, ирээдүй чинь гэрэлтэй байхыг хүсэн ерөөе. /алга ташив/

Улсын Их Хурлын гишүүд ээ, одоо 7 хүний асуулт, хариултын дараа асуулт хариултын цаг дуусаж, санал хураалт явуулна.

Тийм учраас чуулганы танхимд цагийн дараа цуглацгаах нь байна. Бэлэн байхыг. Санал хураалтад бэлдэнэ шүү. Асуултад Улсын Их Хурлын гишүүн, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга, хууль санаачлагч Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ харуулна.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Таны хэлж байгаа шалгуур өндөр, төрийн албанд шалгуур өндөр, цалин, нийгмийн баталгаа бага байна гэдэгтэй санал нэг байгаа.

Тийм учраас төрийн албан хаагчдынхаа ажиллах орчин нөхцөлийг нь сайжруулах ёстой. Зөвхөн энэ хуулиар зохицуулалтыг хийхгүй. Үүнийг Улсын Их Хурал, хууль тогтоогч нар үүнийг анхаарах ёстой. Цалин хангамжийг ялгамжгүй тогтоох энэ асуудлыг давхар үзэх ёстой. Зөвхөн төрийн албаны бүтээмжтэй холбоотой төдийгүй нийт иргэн, аж ахуйн нэгж, байгууллага энэ бүтээмжтэй уялдах ёстой. Энэ байдал алдагдаж байгаатай холбоотой олон сөрөг үр дагавар гарч байгаагийн нэг бол та бид нарын ярьж байгаа энэ төрийн албан хаагчдын цалин, нийгмийн хамгаалал, баталгаатай холбоотой ийм асуудлууд гарч байгаа. Үүнийг нь өнөөдөр хөндөж ярьж байгаа асуудал их чухал.

Тийм учраас манай Их Хурлын гишүүд, холбогдох Байнгын хороо, цаашилбал Засгийн газар бүх түвшиндээ анхаарч хууль бодлого, эрх зүйн хувьд нь сайжруулах ийм шаардлага гарна гэж.

Энэ төрийн албан хаагчдын сонгон шалгаруулалттай холбоотой асуудлыг холбогдох хууль тогтоомжид нь өөрчлөлт оруулаад сайжруулаад явах шаардлага байна.

Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн зохицуулалт бол хөдөлмөрийн гэрээ байгуулаагүй, төрийн албанд ороогүй хүмүүсийн тухай асуудалтай холбогдохгүй шүү дээ. Зөвхөн төрийн албанд орж ажиллаж байгаа

ийм хүмүүс нэг үгээр хэлэх юм бол тэр стандартаа бид тогтоож өгье л гэж байгаа юм.

Төрийн албанд ажиллахаар шийдсэн бол энэ төрийн албаны үнэт зүйлс гэж юу юм, тэр тодорхой хөдөлгөөнгүй үнэт зүйл, цаашилбал тавигдаж байгаа нийтлэг хэм хэмжээ, энэ шаардлагуудыг хүлээн зөвшөөрч энэ шаардлагад нийцэж ажиллана л гэсэн ийм үг. Харин хуулийг хэлэлцэх эсэхийг нь шийдсэний дараагаар Их Хурлын гишүүд, ажлын хэсэг илүү ажиллах, түрүүн яригдсан энэ асуудлуудыг анхаарч үзээд, хуулиа улам боловсронгуй болгоод, ингээд батлаад хэрэгжүүлээд явах ийм шаардлага байгаа.

Ер нь өнөөдрийн амьдралд тулгамдаж байгаа асуудал бол энэ Төрийн алба гэдэг бол нийгмийн, улс үндэстний нүүр царай.

Тийм учраас өнөөгийн байгаа нөхцөл дээрээ бид ухралт хийгээд энэ шаардлага, хэм хэмжээг тогтоож чадахгүй, үүнийг биелүүлж, хэрэгжүүлж чадахгүй бол үнэхээр улс орны ирээдүйн хувь заяа, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын асуудал холбогдоно л гэж ингэж үзэхээр байгаа юм. Төрийн албад данхар байгаа. Энэ данхар төрийн албаны бүтэц, тогтолцоог хэн бий болгож байна? Улс төрийн намууд, улс төрийн албан тушаалтнууд, хуулиар олгогдоогүй эрх эдэлж, энэ томилгоонд шууд оролцдогтой холбоотой олон асуудлууд бий.

Тийм учраас энэ улс төрийн намуудын хуулийг хэлэлцэх үеэр энэ асуудлуудыг нэлээн сайн тусгаж өгөх ийм шаардлага бий болно гэдэгтэй санал нэг байгаа.

Дээр нь хүний нөөц, боловсон хүчний асуудлыг бид өргөн хүрээнд авч үзэх ийм шаардлага байгаа гэдгийг би түрүүн гишүүдийн асуултад хариулахдаа би бас хөндөж хэлсэн. Тэр дээр анхаарал тавих ёстой байх. Энэ төрийн албаныхаа хуульд тодорхой өөрчлөлт оруулах юм уу. Манай гишүүд, ялангуяа энэ аймаг, орон нутгийг удирдаж ажиллаж байсан гишүүд маань тодорхой санал, санаачилгууд гаргаж байгаа. Та бүхэнд яг ажил хариуцаад ажиллаж байсан хүмүүсүүдэд, амьдралд тулгамдаж байсан олон бэрхшээл, асуудлууд бий. Үүнийгээ яаж зөв зохицуулалтад оруулах юм бэ гэдгээ давхар үзэх шаардлага бий байх. Төрийн жинхэнэ алба, төрийн үйлчилгээний алба, энэ бүх юмаа зааглах ийм шаардлага байх уу. Төрийн үүргийг бусад байгууллага, хууль.../минут дуусав/

Г.Занданшатар: Цэндийн Сандаг-Очир гишүүн тодруулж асууна.

Ц.Сандаг-Очир: Би асуултдаа Төрийн албаны зөвлөлийнхнөөс. Тэр сонгон шалгаруулалтын авч байгаа ерөнхий болон тусгай мэдлэгийн тест, сорилууд чинь тухайн хүний ёс зүйн асуудлыг, ёс зүйтэй байх, ёс зүйтэй хүн гэдгийг нотолж, тодорхойлж чадахгүй л байна л даа. Тийм ёс зүйгүй улсуудыг төрийн албанд авчхаад ямар нэг шахаагаар гэдэг юм уу, танил талаар улс

төрийн томилгоогоор авчхаад л, дараа нь эцэстээ төрийн албан хаагчдын нэр хүнд унаж байгаа асуудлууд байгаа шүү дээ.

Тийм учраас энэ сонгон шалгаруулалтыг ер нь цаашдаа яаж яг тухайн хүнийг ёс зүйтэй хүн бэ гэдгийг нь нотлох хэмжээний ийм шалгалт авдаг болох вэ гэдэг тал дээр л би асуугаад байгаа юм.

Дараагийн асуулт. Энэ ажлын байрны тодорхойлолтын асуудал чинь хүнд суртал юунаас үүсэж байна вэ гэхээр тухайн иргэн, хуулийн этгээдээс төрийн байгууллагад гаргасан өргөдөл, гомдлыг тодорхой хугацаанд шийдвэрлэх ёстой. Гэтэл өдөрт нь ч гэдэг юм уу, хоёроос гурав хоногийн хугацаанд шийдчих ёстой асуудлыг ширээ нь.../минут дуусав/

Г.Занданшатар: Тэр сонгон шалгаруулалтыг л зөв шударга хийдэг байх асуудал яваад байгаа шүү дээ. 93. Одоо Азийн улсуудад сонгон шалгаруулалт, төрийн албаны сонгон шалгаруулалтад ёс зүйн номыг, Күнзын ёс зүйн номыг цээжээр нь мэддэг байх шаардлагатай тавьдаг шүү дээ.

Б.Баатарзориг: Ц.Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя.

Энэ нийгмийн анхаарлын төвд байгаа эргэлзээг нь тайлах ёстой нэг асуудал бол таны хөндөж байгаа энэ сонгон шалгаруулалтын асуудал байгаа. Сонгон шалгаруулалтын асуудал бол үнэхээрийн хүндрэлтэй байсан.

Эхний шатанд тавигдсан оноогоо бүл зөвшөөрдөг байсан бол одоо нэг дэвшил нь цахимаар авагдаж байгаа учраас энэ хардлага сэрдлэг арилсан.

Одоо хоёр дахь дэвшил нь яг таны хэлдгийг хэрэгжүүлэх ажлуудыг эхэлж байна. Яавал томилогдох хүмүүс мэдлэгийн хувьд босго давж болдог, ёс зүйн хувьд тэр хүн ямар вэ гэдгийг оношлох асуудал байгаа. Бусад оронд бол үүнийг оношилдог. Тэр оношилсон нь зөв байдаг. Магадлал өндөртэй байдаг ийм арга туршлага байдаг юм байна. Үүнийг өөрийнхөө оронд турших ажил.../минут дуусав/

С.Одонтуяа: 92. Гүйцээгээд хариулъя. 93.

Б.Баатарзориг: Үүнийг хэрэгжүүлж байгаа зүйл байгаа. Ц.Сандаг-Очир гишүүн ээ. Бусад гишүүд ч гэсэн үүнийг харж байгаа. Яавал хүний дотоод итгэл үнэмшлийг зөв оношилчих уу, илрүүлэх вэ. Энэ ажлууд хэрэгжүүлнэ.

Хоёрдугаарт нь, өгч болох хариуг заавал удаахгүйгээр өгдөг ийм тогтолцоонд орж байгаа. Цахим тогтолцоонд. Заавал тоот харахгүйгээр албан мэйлээр явуулсан хариуг шууд тэрийг албан ёсны хариу гэж үзэх ямар нэгэн шуудангийн юм уу, цаасны дамжлагагүйгээр байгууллага төлөөлөн хариу өгөх эд нар ийм зүйлүүдийг бол энэ системд шилжиж байгаа. Тэгээд энэ сэтгэл зүйн сорил тестэй холбоотой, хүнд суртлыг арилгахтай холбоотой, цахимжуулахтай

холбоотой зүйлүүд хийгдэж байгаа болно. Маш товчхон хариуллаа. Зөв ойлгоорой.

С.Одонтуяа: Одоо Цэвэгдоржийн Туваан гишүүн асууна.

Асуултын өмнө мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн ажлын албаны ажилтнуудын хүүхдүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс сурлагын өндөр амжилт, амьдралд нь сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Ц.Туваан гишүүн асуултаа асууя.

Ц.Туваан: Энэ хуулийн төсөл дэмжиж байгаа. Орж ирэх зүй ёсны цаг хугацаа нь болсон.

Манай Монголчууд энэ дэлхий дээр төрт ёсны агуу их уламжлалтай ийм ард түмэн. Төрөө дээдэлдэг, төрийнхөө сүлд соёмбоо дээдэлдэг ийм сайхан уламжлалтай ард түмэн. Энэ уламжлал ч гэсэн байгаа одоо байгаа. Тэгэхдээ харьцангуй багасаад байгаа. Үүнийг бид бүхэн бүгдээрээ мэдэж байгаа. Одоо нэг сайхан төрд зүтгэдэг төрийн хар хүн, ноён нуруутай хар хүмүүс, хар хүн гэж ярьдаг. Тийм ээ. Ийм хүмүүс маань үнэхээр цөөдлөө. Цөөхөн боллоо. Ихэнх нь ингээд л авлига, албан тушаалын янз бүрийн юманд холбогдсон гэсэн нэр зүүлттэй ийм зүйлүүдээс болоод энэ төрийн албаны маань нэр хүнд үнэхээр шалан дээр ойчоод байна.

Тэгэхээр энэ өнөөдрийн орж ирж байгаа асуудал бол төрийн албан хаагчдын ёс зүйн тухай асуудал. Тэгээд дээрээс нь тэдгээрийг дагаад Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах асуудал яригдаж байна л даа.

Тэгэхээр ёс зүй гэдэг бол бид нар уг нь, манай ард түмэн чинь хүүхдүүдээ бүр бага наснаас нь өгсүүлээд ингээд ёс зүйтэй, хүмүүжилтэй, одоо тийм уламжлалаар хүмүүжүүлж, ёс зүй суулгадаг байсан. Ичих нүүртэй байлгадаг байсан. Одоо өнөөдөр бол ер нь энэ асуудал нэлээн хүнд болчихоод байгаа. Тэгэхээр энэ хуульчилж оруулж ирж байж энэ асуудлыг тодорхой хугацаанд авч явах нь зөв гэж ингэж бодож байгаа.

Тэгээд төрийн албан хаагчдыг аваад үзэхээр бас ёс зүй муутай. Дээрээс нь энэ ажлын ур чадвар асар муутай. Тэгээд бас мэдлэг, ур чадвар муутайгаасаа болоод ч тэр юм уу нэг тийм их зантай ч юм уу. Хашиж байгаа төрийн албандаа сэтгэлгүй хандаад байх гэсэн ийм асуудлууд түгээмэл байна. Тэгэхээр өнөөдрийн хууль бол цагаа олсон байгаа гэж ингэж ойлгож байна.

Энэ дунд энэ Төрийн албаны зөвлөлийн дэргэд энэ Ёс зүйн зөвлөлийг байгуулъя гээд. Энэ зөвлөл нь ер нь ямар бүрэлдэхүүнтэй байх юм? Ямар ямар

улсууд ингээд энэ зөвлөлд нь орох юм бэ? Тэгээд эндээс л бас асуудал эхлэх болов уу гэж ингэж бодож байгаа юм.

Одоо дэлхийн улс орнуудад ёс зүй бол бүр бараг хууль, дүрэм журмаасаа дээгүүр тавигдсан. Ёс зүй зөрчиж байгаа хүмүүс нь өөрсдөө уучлалаа гуйгаад хариуцлагаа хүлээгээд ингээд явчихдаг. Тэгэхээр манайд энэ асуудал бол бүр байхгүй. Өөрөө сүүлийн үед маш олон асуудал яригдаж байна. Тэгээд өөрсдөө уучлал гуйгаад ингээд хариуцлагаа хүлээж байгаа хүн бол лав харагдахгүй байгаа.

Төрийн албаны энэ асуудал дээр намчирхал, улс төржилт бол замаа алдсан шүү дээ. Одоо Төрийн албаны зөвлөлийнхөн байж байна. 2012-2016 оны хооронд ажилд орсон хүмүүсийг бүр ажилд орсон огноогоор нь хоморголон халалт явагдсан.

Тэгээд тэрний ард тал дээр бүрдүүлсэн энэ төрийн алба данхар, ажиллаж чадахгүй байна гэдэг ийм шүүмжлэлүүд ингээд их яваад байгаа.

Одоо юун дээр төрийн янз бүрийн албан хаагчид, бүх шатны албан хаагчид, дээрээс нь энэ төрийн үйлчилгээний албан хаагчид энэ тэр гээд энэ бүх хүмүүс л энэ дотор ёс зүйн асуудал дээр орох ёстой.

Дээрээс нь бас энэ ёс зүйгүй ч юм шиг ажлаа хийх чадваргүй байгаад байгаа энэ асуудал дээр нь энэ төрийн алба хаах хүн олдохоо болилоо шүү дээ. Авч байгаа цалинг бүр доллар шилжүүлээд бодохоор ямар цалин аваад байгаа юм. Дээрээс нь тэр хүн, хоолондоо, ар гэртээ бас яаж зарцуулах юм. Тийм ээ. Тэгэхээр үүнтэй холбоотой бас асуудлууд байна.

Тэгэхээр түрүүний тэр.../минут дуусав/

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Ц.Туваан гишүүний асуултад хариулъя.

Энэ хуулиар төрийн албан хаагчдын ёс зүйн асуудал эрхлэх эрх бүхий этгээд, түүний бүрэн эрх гээд зүйл, заалт оруулаад өгсөн байгаа.

Таны асууж байгаа зүйлийг бол 10 дугаар зүйлээр зохицуулаад өгсөн. Төрийн албан хаагчийн ёс зүйн асуудлаарх Ёс зүйн хороо, түүний бүрэн эрх гээд. Энэ бол Төрийн албаны зөвлөлд анхны хуулийн төслөөр бол тусдаа бие даасан Төрийн албаны зөвлөлтэй энэ тэнцэхүйц хэмжээний ийм хороо байгуулахаар яригдаж байсан. Тэгээд энэ хуулийн төсөл боловсруулах явцад Төрийн албаныхаа зөвлөлийн дэргэд байгуулъя. Гэхдээ бүрэн бие даасан, хараат бус байдлаар ажиллах ийм эрх хэмжээг нь олгож өгье гэж ингэж хуульчилж өгсөн байгаа.

Цаашлах юм бол энэ төрийн байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны эрх хэмжээг тодорхой зааж өгсөн. Энэ Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд төрийн байгууллагын томилох эрх бүхий албан тушаалтны эрх хэмжээг нь зааж өгсөн. Өмнөх практикаас үзэх юм бол тэр төрийн бүх шатанд ажил, албан тушаал хариуцаж байгаа хүмүүсийн талд үйлчилдэг гэдэг юм уу. Тэр талаасаа. Зөвхөн албан хаагчидтайгаа ёс зүйн хариуцлага ярихаас биш тэр албан тушаалтантай хэн хэрхэн хариуцлага тооцох юм бэ гэдэг асуудал нь бүрхэг байсан. Энэ зүйлийг хуульчилж өгсөн байгаа.

Тийм учраас энэ томилох эх үеийн албан тушаалтны эрх хэмжээг зааж өгсөн. Байгууллага 25-аас дээш ажиллагсадтай байгууллага болгон Ёс зүйн зөвлөлүүд байгуулна. Тэр нь өөрөө бүрэн биеэ даасан, хараат бусаар үйл ажиллагаа явуулна. Тэр дарга удирдлагаас ямар нэгэн байдлаар хараат биш. Нийт ажиллагсдынхаа хурлаас санал авч байж итгэл дааж ажиллах хүмүүс тэр Ёс зүйн зөвлөлд орно. Ёс зүйн зөвлөл өөрөө хуралдаж ахлах хүнээ даргаа сонгож ингэж явах.

Тэгээд энэ гомдол мэдээлэл гаргах, түүнийг хянан шийдвэрлэхтэй холбоотой асуудлыг аль болохоор нэгдүгээрт ёс зүйн зөрчилд тэр хариуцлагаас мултрах тийм орон зай үлдээхгүй байхыг эрхэмлэсэн. Нөгөө талаараа хэн нэгнийг хэлмэгдүүлж хариуцлага тогтоох, тооцох ямар нэгэн улс төрийн бусад атгаг хувийн ийм эрх ашгийн үүднээс хэн нэгнийг хэлмэгдүүлэх, хариуцлага тооцох энэ зүйлүүдийг нь хааж өгсөн ийм зохицуулалтуудыг хэлсэн.

Тантай санал нэг байгаа. Мэдлэг, ур чадварын зэрэгцээгээр энэ ёс зүй харьцаа, хандлага, энэ хариуцлагын асуудлыг давхар авч үзэхгүй бол үнэхээр болохгүй байна.

Нийтлэг энэ улс орнууд хөгжсөн парламентат ёс нь хөгжсөн, төрийн алба нь ёс зүйтэй болж төлөвлөсөн энэ улс орнуудын жишгийг харах юм бол тэр төрийн албанд бүх шатандаа хулгай хийхгүй. Бид худлаа хэлэхгүй, хулгай хийхгүй, хууран мэхлэхгүй гэсэн үндсэн гурван алтан зарчим байна. Бидний дунд цаашлах юм бидний дунд ийм үйлдэл хэрхэвч гаргаж болохгүй гэсэн тийм соёл, тогтолцоог бий болгож байгаа юм.

Тийм учраас энд урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэхтэй холбоотой бүхэл бүтэн тусдаа зүйл заалт оруулж, энэ асуудалд ихээхэн ач холбогдол анхаарал тавьж байгаа. Одоо манай замын цагдаа нар энэ тэндээс нууж байгаад буудаад, тэгээд торгууль тавьдаг, анаад сууж байдаг тийм байдлаар бүх түвшинд бид тэгж хандаж болохгүй.

Харин тэр ёс зүйн аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлийн ажлыг хийхийг энэ хуулиар нэлээн тодорхой үүрэгжүүлж өгч байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Ц.Туваан гишүүн тодруулга 1 минут.

Ц.Туваан: Энэ төрийн албан хаагчийн ёс зүй бас энэ нийгмийн хангамж, цалин цавуутайгаа холбоотой байх.

Тэгэхээр энэ тал дээр би бас нэлээн үг хэлж байгаа. Тэгээд үүнийг манай Засгийн газрынхан ирэх жилийн төсөв дээр оруулж ирнэ ээ гэж ингэж ярьж байгаа. Дээрээс нь энэ Төрийн албаны зөвлөлийнхнөөс асууя. Орон нутагт явж байхад энэ төрийн албан хаагчид чинь маш олон тоогоороо олон жилээрээ дутуу яваад байна. Тэгээд төрийн албан хаагчдын тэр иргэдэд үзүүлэх орон тоо бөглөгдөхгүй дутуу яваад байна гэдэг чинь тэр хэмжээгээрээ иргэд энэ төрийн үйлчилгээ авч чадахгүй хохироод байгаа юм.

Тэгэхээр үүнтэй холбоотой ямар бодлого байна. та хэд дээр. Тэгээд тэр шалгалтыг өөрчлөх, цаг үед нь тааруулах энэ тэр арга хэмжээ авахгүй бол ингээд л нөгөөдөхөөрөө зарлаад ингээд яваад байх уу гэдэг нэг ийм асуултыг асууя. Тэгээд энэ нэг л болохгүй олон мянгаараа дутуу байгаа шүү. Иргэд үйлчилгээгээ авч чадахгүй л байгаа.

Тэгэхээр Төрийн албаны зөвлөл энэ дээр ямар бодлоготой байна.

С.Одонтуяа: Б.Баатарзориг дарга хариулах уу? 93 дугаар микрофон.

Б.Баатарзориг: Ц.Туваан гишүүний асуултад хариулъя. Өмнө нь асууж байсан гишүүдийн асуултад ч бас давхар хариулж байна.

Энэ хөдөө орон нутагт боловсон хүчний дутагдал байна. Хүний нөөцийн дутагдал. Бүр хомстол байдал ч орж байна. Энэ цалин хөлстэй ч холбоотой. Бусад зүйлүүдтэй ч холбоотой байна.

Энэ дээр Төрийн албаны зөвлөл, Улсын Их Хурлын дарга, Төрийн байгуулалтын байнгын хороо, Ёс зүйн байнгын хороо, бусад Байнгын хороодоос чиглэл авсан. Цалин хөлсний шинэтгэлийн асуудлаар, орон сууцны шинэтгэлийн асуудлаар, орон нутгийн нэмэгдлийн асуудлыг судалж үзэхтэй холбоотой. Сангийн яам, Хөдөлмөрийн яамтай хамтарсан ажлууд хийгдэж байгаа болно.

Дараагийнх нь тоогоор үзэх юм бол одоогоор 1732 сул оронтой байна. 4208 төрийн байгууллагад. Эндээс 144 нь удирдах ажилтан байгаа.

С.Одонтуяа: Хариултыг нь гүйцээгээд сонсьё. Б.Баатарзориг даргын микрофоныг өгчих.

Б.Баатарзориг: Удирдах ажилтан 144, гүйцэтгэх ажилтан 1474 гүйцэтгэх ажилтны сул орон тоо байгаа. Үүнийг нөхөхтэй холбоотой бид нар Сонгон шалгаруулалтын хуулийг шинэчлэн өргөн барихтай холбоотой дагалдан гарах

журам, дүрмүүд дээр өөрчлөлт оруулж байгаа зүйлүүд бол бий. Ингэснээр хүний нөөцийн хангалт сайжрах, тогтвортой ажиллах. Бас тэр туслах болон зохион байгуулагчдыг ажиллуулахтай холбоотой болзол, шаардлагын асуудал дээр өөрчлөлтүүд гаргаж байгаа болно. Мөн адил албан тушаалууд, адил ажил, албан тушаал дээр шилжиж ажилладаг ийм зүйлүүд нь нээлттэй байж байгаа болно. Баярлалаа.

С.Одонтуяа: Одоо Цагаанхүүгийн Идэрбат гишүүн асуултаа асууна.

Ц.Идэрбат: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе.

Төрийн албаны зөвлөлөөс бас хэд хэдэн асуулт байгаа юм. Одоо ер нь тэгээд төрийн алба данагар боллоо л гээд байгаа. Энэ төрийн албаны бүтцэд орж байгаа энэ 4 ангиллаас ард иргэд бол төрийн албаны бүтэц гэдэг дээр ердөө л Тамгын газар, энэ дарга нарынх нь бүтэц л өндөрсөөд байгаа юм шиг ийм юм ойлгоод байх юм.

Тэгэхээр энэ дээр одоо тэр эмч, багш, тэр цэвэрлэгч, үйлчлэгч энэ бүх хүмүүс ороод хоёр зуун хэдэн мянга болоод байгаа юм. Эндээс яг төрийн захиргааны албан хаагч сумын Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын Тамгын газар дээр нь тэд байгаа юм гэдгийг нь бас нэг нэлээн ялгаж, салгаж одоо бас би энэ танхимд бас та бүхнийг нэг хэлээд өгөөсэй гэж ингэж бодоод байгаа юм. Энэ цэрэг, цагдаа, онцгой. Одоо бүх л зүйлүүд ороод хоёр зуун хэдэн мянга болоод байгаа.

Гэтэл зөвхөн дарга нарын л тоо л нэмэгдээд байгаа юм шиг нийгэмд ийм ойлголтыг бид нар бас төрүүлээд байна. Тэгэхээр энэ дээр бас нэг тийм ялгаж салгасан тоо бас нэг хэлж өгөөч ээ гэж ингэж хүсэж байна.

Хоёрдугаарт, одоо ингээд 1300 албан тушаал хоосон байна. Сумдууд дээр. 330 суманд хуваагаад үзэхээр энэ чинь дунджаар 4 орон тоо байхгүй. 4 орон тоо гэдэг чинь одоо сумын Тамгын газрын бүтцийнх нь бараг 30 хувь нь байхгүй байна.

Тэгэхээр ер нь ингээд 30 хувь нь байхгүй. Үлдэж байгаа 70 хувь нь баахан хүний юм давхар хариуцаад бөөн стресс, бөөн нерв. Төрийн үйлчилгээ тэнд цалгардаад ингээд байгаад байх юм.

Ер нь шулуухандаа хэлэх юм бол яг одоо явж байгаа энэ хууль эрх зүй, энэ цалин цагааны энэ орчин чинь Монголын төрийг ер нь хөлгүй болгочихсон юм билээ. Яг анхан шатан дээр ажиллаж байгаа хүн маш ховор болчихсон. Маш их халагдаж, солигддог ийм болчихсон.

Тэгэхээр ер нь энэ доод сууриа анхан шатанд төрийн үйлчилгээ үзүүлж байгаа энэ бүтцээ ер нь яаж сайжруулах юм бэ? Энэ Төрийн албаны хууль чинь

өнөөдрийн энэ байдлаараа яваад цаашаа явахгүй нь ээ гэдэг нь амьдрал дээр тодорхой болоод байна шүү дээ.

Төрийн албаны маш сайхан хууль хийж байгаа, чанга хууль хийж байгаа л гэж яриад байгаа боловчиг амьдрал дээр энэ чинь буухгүй байна. Ажилдаа дарагдсан, хоёр гурван хүний ажил хийсэн, цалин багатай, дарамт ихтэй, цаг наргүй нэг тийм хэдэн хүмүүс сумын Тамгын газар дээр байж байна шүү.

Дараагийнх нь энэ төрийн албан хаагчдын. Би энэ дотроо яг тэр төрийн захиргааны албан хаагчдын, сумын Засаг даргын Тамгын газрын алба хаагчдын эрх ашгийг хангах тал дээр, ер нь хамгаалах тал дээр Төрийн албаны зөвлөл бас тийм чиг үүрэг байна уу?

Өнөөдөр суман дээр ажиллаж байгаа энэ төрийн албан хаагч бөөн шалгалт шүүлэг, янз янзын юмыг арай чамай даваад гарахад цаана нь 450 мянган төгрөгийн цалин угтаж байгаа. Гэтэл энэ эрүүл мэндийн салбар, боловсролын салбар, энэ сайд нар нь сайн ажиллаж байна. Өчигдөр би Цэнхэрмандал суманд очоод уулзалт хийхэд тэнд багш нар сууж байна. Цалин чинь хэд болсон бэ гэсэн. Сая болсон гээд тэнд баясгалантай хүн сууж байна шүү дээ. Ажиллах эрч хүчтэй. Тэгэхэд хажууд нь сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан гээд ямар ч ажиллах идэвх сонирхол байхгүй. Зайлуул бөөн дарамтад 450 мянган төгрөгийн цалин аваад сууж байгаа адилхан хорин хэдэн насны залуучууд ингээд сууж байгаа.

Тэгэхээр энэ нэг цалин цагааны асуудал дээр яг төрийн захиргааны энэ сумын анхан шатанд ажиллаж байгаа энэ алба хаагчдын цалинг нэг дорвитойхон нэмээд ингээд үзэхэд яадаг юм бэ. Ийм юм байна уу, үгүй юу? Энэ дээр эрх ашгийг нь яаж хангах юм?

Ёс зүйн хэм хэмжээг ер нь дүгнэж цэгнэхэд бас хэцүү шүү. Тэгээд төрийн албаны шалгалт янз янзын юмнууд байгаа. Дээрээс нь энэ ёс зүйн хуулийг би зарчмын хувьд дэмжиж байгаа. Ард иргэд ёс зүйтэй төрийн албыг хүсэж байна. Харин энэ маань эргээд дарга ангид үйлчилдэггүй, жирийн төрийн албан хаагчдыг ямар нэгэн байдлаар хяхаж хавчих, ажлын байрыг нь солих энэ зүйлийн нэг зэвсэг болж хувирах вий гэж ингэж бодож байгаа. Тэгэхээр үүнийгээ маш сайн бодож тунгаагаасай гэж ингэж бодож байна.

Тэгээд ер нь би Цэнхэрмандалд ажиллахад, өчигдөр орой уулзалт хийхэд төрийн албан хаагч нар тэнд маш олон зовлон ярьж байна. Одоо ажлаасаа гаръя гээд энэ мянга гурван зуу.../минут дуусав/

С.Одонтуяа: Хариулт авахын өмнө мэндчилгээ дэвшүүлье. Дорнод аймгийн Дорнод төгсөлт төрийн бус байгууллагын гишүүд Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэнд нийт Улсын Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс ажилд нь амжилт, амьдралд нь хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөе. /алга ташив/

Хариулт 94 дүгээр микрофон. Төрийн албаны зөвлөл.

С.Цэдэндамба: Ц.Идэрбат гишүүний асуултад шууд хариулъя.

Нэгдүгээрт, тэр төрийн алба алба данхар байна, олон байна гэдэг дээр маш тодорхой тайлбар өгөөч ээ гэж хүсэн.

Үнэхээр яг төрийн захиргааны албан хаагч бол энэ нийт төрийн албан хаагчдын 10 хувь л байгаа. 10 хувь буюу 21-хэн мянга. Тийм. Төрийн үйлчилгээ буюу боловсрол, соёл, эрүүл мэнд, шинжлэх ухааны салбарт ажиллаж байгаа нь бол нийт төрийн албан хаагчдын 66.0 хувь байгаа юм. 66.0 хувь буюу 137 мянга 665 нь төрийн үйлчилгээний ангилал.

Ингээд ерөнхий дүнгээр ийм олон хүн байгаа юм шиг боловч яг төрийн захиргаа бол түрүүн хэллээ. 10 хувь л байгаа буюу 21 мянга 135 байгаа юм. Үүн дээр яах вэ, Төрийн жинхэнэ алба гэвэл төрийн тусгай нэмэгдэнэ. Төрийн тусгай бол төрийн захиргааны албан хаагчаасаа хоёр дахин их буюу 45 мянга 899 гэсэн ийм л харьцаатай байгаа.

Тэгэхээр үүнийг бас иргэд олон нийтэд зөв тайлбарлаж өгөхгүй бол ер нь төрийн алба данхар байна, юу байна гэсэн ийм олон нийтийн мэдээллийн юугаар авсан мэдээллээрээ бас иргэд хандах төөрөлдөх зүйл байгаа. Энэ дээр зөв тайлбар өгөөч ээ гэсэн гишүүнд талархлаа.

Хоёр дахь асуулт байна. Тэр орон нутгийн анхан шатны төрийн захиргааны байгууллагыг яаж бэхжүүлэх вэ гэдэг дээр үнэхээр бас Төрийн албаны зөвлөлийн анхааралд байгаа асуудал мөн. Бид энэ талаар бас тодорхой хэмжээний санал судалгаа дэвшүүлээд сумын Тамгын газар, аймгийн Тамгын газрын бүтцийн орон тоог нэмүүлэх ийм Засгийн газрын шийдвэр гаргасан. Одоо дараачийн алхам бол цалин хөлсийг нэмэгдүүлэх энэ саналаа Засгийн газарт бас өгч байгаа.

Тэгээд Төрийн албаны хуульд байгаагаар төсвийн асуудал ярихаас өмнө Засгийн газар энэ асуудлыг Улсын Их Хуралд оруулж ирэх тийм заалттай. Түүнд нь бид үндэслэл болох судалгаа, мэдээллүүдийг маш тодорхой гаргаж өгсөн.

Үнэхээр өнөөдөр сумын Тамгын газрын анхан шатанд ажиллаж байгаа төрийн албан хаагчийн цалин бол тэтгэврийн доод хэмжээтэй ижил байгаа. Энэ бол төрийн албан хаагчийн төрийн албаны үнэлгээ ямар байна вэ гэдгийг хөндлөнгийн хүмүүст харагдахаар ийм зүйл.

Тийм ч учраас залуучууд бол энэ орон нутагт очиж ажиллах хүсэл сонирхолгүй байгаа нь бас үүнтэй холбоотой. Нийгмийн асуудал ерөөсөө маш бага байгаа учраас.

Тэр 1333 хүн байна гэдгийг бид бүх сумдаас энэ сул орон тоо авсан. Тэгэхдээ энэ бүгдээрээ сул байгаа юм биш. Үүний 600 гаруй нь үүрэг гүйцэтгэгч нар байгаа. Үүрэг гүйцэтгэгч гэдэг нь юу вэ гэхээр зэрэг төрийн албаны зохих хэмжээний шалгалт өгч амжаагүй ийм зүйл байгаа.

Гурав дахь шалтгаан бол энэ анхан шатанд байгаа мал эмнэлгийн ажилтнууд, байгаль хамгаалах ажилтнууд гэдэг юм уу, мэргэжилтнүүдийг салбарын хуульдаа заавал төрийн захиргаа байна гээд ингээд заачихсан учраас Төрийн албаны хуулиар шалгалт авахаас аргагүй байдаг. Гэтэл бид хэлж байгаа. Байгаль орчны яаманд та нар энэ байгаль хамгаалагч нараа ТҮ болгож болохгүй юу. Хөдөө аж ахуйн яам, мал эмнэлгийн салбарт энэ зарим мэргэжилтнүүдээ төрийн үйлчилгээний ангид оруулж болохгүй юу гэдэг ийм саналуудыг бас хүргүүлээд байгаа.

Яагаад гэхээр тэнд ажиллаж байгаа улсууд бас захиргааны албан хаагч байна гэсэн учраас шалгалт өгөхөөс аргагүй. Шалгалт өгөхдөө зэрэг бас тэнцэх тэнцэхгүй байна гэдэг асуудал яригддаг ийм зүйл байгаа. Энэ чиглэлээр бид зохицуулалт хийж байгаа.

Ямар зохицуулалт гэхээр зэрэг ер нь анхан шатны төрийн байгууллагад ажиллах хүмүүст туршлагын болзол тавихгүй байгаа. Ажилласан жилийн туршлагын болзол тавихгүй.../минут дуусав/

С.Одонтуяа: Ц.Идэрбат гишүүн тодруулъя.

Ц.Идэрбат: Энэ 2023 оны төсөв дээр энэ анхан шатанд ажиллаж байгаа төрийн захиргааны албан хаагчдыг. Би төрийн захиргааны гэж хэлээд байгаа шүү. Алба хаагчдын цалингийн асуудал дээр үндсэндээ энэ 330 сумын Тамгын газарт 20-иор бодоход 7 мянга гаруй, 8 мянган хүний асуудал л байгаа.

Тэгээд энэ хүмүүсийг адилхан төгсөөд очиж байгаад багш, эмч шиг цалингийнх нь хэмжээг нэг сая төгрөгт аваачихад тэнд залуучууд энэ төрийн албаны шалгалтыг даваад гарна, орно оо. Гагцхүү энэ 400 мянган төгрөгийн цалин гэдэг чинь л олон залуучуудыг цааш нь түлхээд байгаа юм. Би КОВИД-ын хуулийг барьж 13 залууг шалгалтгүйгээр томилсон. Ажилд. Дандаа сумдад. Тэд 3 сарын дараа очиход тэр 13 залуугийн 1 нь үлдээд бусад нь бүгд цалингаа голоод явчихсан байгаа юм.

Тэгэхээр энэ дээр өндөр цалинтай байхад ёс зүй давхар шийдэгдээд явчихна гэж ер нь ингэж харж байгаа шүү.

Тэгэхээр та бүхэн маань энэ цалингийн асуудал дээр зоригтойхон юм оруулаарай. 20 хувь, 10 хувь чинь хэрэггүй шүү гэж хэлье.

С.Одонтуяа: Санал хэллээ. Одоо Гочоогийн Ганболд гишүүн асуултаа асууя.

Г.Ганболд: Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль хэлэлцэж байна.

Тэгээд бид ёс зүйг хуульчилж болохгүй гээд л. Төрийн албаны ажлын онцлогууд, тухайн ажлаасаа хамаараад тус тусдаа ёс зүйн дүрэмтэй байна гэж явж байгаад өнөөдрийг хүрсэн л дээ.

Тэгээд өнөөдөр ингээд хуульчлах гэж байна. Яг сая Төрийн албаны зөвлөлийнхний хэлж байгаагаар бол 1300 орчим сул орон тоо байна гэж байна л даа. Энэ хууль батлагдсанаар энэ тоо бүр улам нэмэгдэнэ л дээ.

Өнөөдөр цөөхөн улсад энэ ёс зүйн хууль батлагдсан байдаг юм байна лээ. Энэ Азийн өндөр хөгжилтэй Солонгос, Япон гээд цалин хангамж нь өндөр, нийгэм нь өөрөө өндөр ёс зүйтэй. Тэнд төрийн албанд орох хүмүүсийн өрсөлдөөн асар их байдаг ийм газар хуульчилж явдаг.

Тэгвэл өнөөдөр бид цалин нь 400 гаруйхан мянган төгрөгийн цалин авдаг ийм хүмүүсээ бид ингээд үг хэл, үйлдлээр нь ингээд ёс зүйн хууль батлаад. Тэгээд бараг өмссөн хувцсаар нь хүртэл ийм ёс зүйн хариуцлага хүлээлгээд явах юм бол энэ төрийн албанд орж ирэх хүмүүс бүр цөөн болно л доо.

Зүй нь бол бид өөрсдөө харин Улсын Их Хурал, Засгийн газар, төрийн өндөр албан тушаалтнууд нийгэмд ёс зүйтэй, үлгэр болдог. Өнөөдөр нийгэмд байгаа махны асуудлаар мэргэжлийн хяналтын газрын дарга нь юм уу, Шадар сайд нь гарч ирээд ард түмнээсээ уучлалт гуйгаад огцорчихдог. Энэ эмийн асуудлаар Эрүүл мэндийн сайдад нь гарч ирээд үнэхээр буруутай бол ард түмнээсээ уучлалт гуйгаад огцорчихдог. Тэр Дарханы замын асуудлаар тухайн салбарын сайдад нь уучлалт гуйдаг. Ийм үлгэр үзүүлж байж л бид энэ төрийн албан хаагчдыг энэ ёс зүйн хуулийг баталж явах ёстой юм.

Тийм учраас би бол энэ удаа зүгээр яах вэ цаг хугацааны хувьд арай эрт байсан юм биш биз дээ. Цалин хангамжийг нь, энэ төр лүү орох иргэдийн, хүмүүсийн хүсэл зорилго их болоод өрсөлдөөн их болсон үед энэ хуулийг гаргаж явах байсан юм болов уу гэж ингэж бодоод байгаа юм л даа.

Яах вэ, энэ хууль батлагдлаа гэхэд ингээд Ёс зүйн хороо байгуулагдах нь. Байгууллагууд дээр ёс зүйн зөвлөл бий болох нь. Ингээд явахаар зэрэг ер нь бол ингээд манай төрийн байгууллагууд чинь дотоод зөрчил нь ямар байдаг билээ. Нэг дарга дагасан хэдэн хов жив ярьсан хүмүүсийн асуудал дэврээд л.

Тэгээд ер нь энэ төрийн албаны хуулиар бид чинь төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах тал дээр маш сайн хуулиуд гаргасан. Гэтэл тэр олон шалгууруудыг чинь зүгээр нэг ёс зүйн жижиг үйлдлээр төрийн албанаас гаргах, сануулаад дараа нь ажлаас нь чөлөөлөх ийм том юмнууд орж ирэх гээд байгаа учраас энэ Төрийн албаны зөвлөлийнхөн бол үүнийг нэг талаасаа бараг энэ ёс зүйн хууль дээр би бараг зарим нэг тал дээр нь би эсрэг байр суурьтай байх ёстой байгууллага гэж би бодоод байгаа шүү дээ.

Энэ төрийн албан хаагчдаа хамгаалах ёстой. Энэ төрийн албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах тал дээр та бүхэн бүх талаар хуулийн ямар нэгэн байдлаар өө сэв гаргахгүй байх нь л би чухал гэж ингэж бодоод байгаа юм л даа.

Тэгэхээр энэ тал дээр Төрийн албаны зөвлөлийнхөн яг ямар байр суурьтай байгаа вэ? Энэ хууль дээр чинь Төрийн албаны хуулиар бид чинь аймгийн иргэдийн Хурлын Төлөөлөгч нар улс төрийн намаас иргэдийн Хуралд дэвшээд гарч ирсэн хүмүүсийг чинь гуравны нэг нь төрийн албанд томилж болно гээд гаргачихсан.

Тэгвэл одоо энэ хууль дээр чинь тэрнээс холхон байх л юм тавьсан байна шүү дээ. Тэрэнд орсон байх юм бол энэ ёс зүйн алдаа гаргасан гээд л шууд чөлөөлөх ийм байдал руу л орох нь л дээ. Тэгээд энэ байдлыг ер нь манай Төрийн албаны зөвлөлийнхөн яг юу гэж ойлгож байгаа вэ? Яаж харж байгаа вэ? Энэ тал дээр би Төрийн албаны зөвлөлөөс ер нь нэг байр суурийг нь сонсьё гэж ингэж бодож байна. Тэгээд дараа нь тодруулъя.

С.Одонтуяа: Мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг, Ж.Ганбаатар, С.Одонтуяа нарын урилгаар Баянгол дүүргийн ерөнхий боловсролын 93 дугаар сургуулийн 12^а ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Мэндчилгээг Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа миний бие уншиж танилцууллаа. Та бүхэнд нийт Их Хурлын гишүүдийнхээ өмнөөс сурлагын өндөр амжилт хүсэн ерөөе. /алга ташив/

Хэн хариулах вэ? 95 дугаар микрофон. Төрийн албаны зөвлөлийн гишүүд хариулъя.

Ц.Амартөгс: Гишүүний асуултад хариулъя.

Ёс зүй, сахилга хариуцлагын тухай, ёс зүйн хэм хэмжээг тогтоох тухай энэ хуулийн концепцод Төрийн албаны хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байгаа төрийн албан хаагчийн үйл ажиллагааг хууль дээдлэн хэрэгжүүлэхэд нэмэр болохуйц, тэр хэм хэмжээгээ хэрэгжүүлж чадахгүй байгаа албан хаагчдад хариуцлага тооцдог энэ механизмыг бий болгох гэдэг асуудлаар

нь зохицуулалтыг тодорхой болгох, тусгах гэдэг асуудал дээр нь Төрийн албаны хуулийн хэрэгжилтэд дэмжлэг болох багц хуулийн нэг хэсэг ээ гэж ингэж ойлгож байгаа.

Төрийн албан хаагчдын шударга, сахилга баттай, ур чадвартай мэргэшсэн албан хаагчдыг илүү сайн ажиллуулах, шатлан дэвшүүлэх энэ механизмыг цаашдаа тууштай баримталж хэрэгжүүлэх нь энэ хүрээндээ Төрийн албаны зөвлөл ажиллана.

Харин ёс зүй, ашиг сонирхлын зөрчилтэй, ёс зүйн хэм хэмжээгээ сахидаггүй ийм албан хаагчдад ил тод байдлаар хариуцлага тооцдог байх, энэ механизмыг бүрдүүлэх. Мөн хэрвээ тэр нь нотлогдож байгаа бол бусад хууль эрх зүйнхээ хүрээнд хариуцлагаа хүлээдэг ийм зүйлийг бэхжүүлнэ ээ гэж ингэж ойлгож байгаа.

Одоо бий болоод байгаа энэ төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний, албан хаагчдын ёс зүйн дүрмийн хүрээнд байгаа зохицуулалтыг илүү хариуцлагатай нь уяж өгч байгаа гэж ойлгож байгаа.

Төрийн байгууллагуудад бий болсон 2711 зөвлөлүүд байгаа. Энэ зөвлөлүүд маань бие дааж үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх, тэдгээр хүмүүсийнхээ шийдвэрийг албажуулж хэрэгжүүлдэг ийм тогтолцоо нь хуулийн хүрээнд бэхжиж байж энэ зөв голдрилдоо орох юм байна гэсэн энэ ойлголттой байгаа.

Нийт 78 байгууллагаас бид санал авч 800 гаруй санал авч энэ хууль тогтоомжид зохицуулж өгөөч ээ гэсэн энэ саналуудыг багцлаад 45 багц саналыг, мөн дараа нь Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлүүдийн үйл ажиллагаатай холбоотой 37 саналыг багцалж хүргүүлсэн. Энд мөн хууль тогтоомжид тусгагдсан байгаа.

Гол зарчим нь бид төрийн албан хаагчид маань хууль тогтоомжийн дагуу хуулиа хэрэгжүүлж ажиллах бололцоо, нөхцөлийг бүрдүүлэхэд нь ямар нэгэн байдлаар бие дааж ажиллах, хариуцлага тооцдог ил тод механизмыг илүү бүрдүүлэх гэдэг агуулгаар нь бид цаашдаа ажиллах боломжтой байгаа гэж үзэж байгаа.

С.Одонтуяа: Одоо Цэдэндамбын Цэрэнпунцаг гишүүн асуултаа асууя.

Ц.Цэрэнпунцаг: Энэ хуулийг дэмжиж байгаа. Энэ чинь удаан яригдаж яригдаж орж ирж байгаа.

Тэгээд манай хуульч гишүүд л их яриад байсан шүү дээ. Энэ Их Хуралд орж ирснээс эхлээд л энэ ёс суртахууныг хуульчилж бичиж болох юм уу, болохгүй юм уу гээд. Энэ бол одоо тэр их хуульчдын маань нарийн гүнзгий маргаан болох байх.

Их Хурлын гишүүний хувьд, энэ ард түмнээ төлөөлөөд сууж байгаа гишүүний хувьд гарцаа байхгүй энэ төрийнхөн албан хаагчид бид ёс суртахуунтай, төрийнхөө үйлчилгээг ард түмэндээ хүргэхдээ бас ард түмнээ, иргэдээ хүндэтгэж харьцдаг ийм сайхан төрийн албан хаагчидтай болох гарцаагүй шаардлагатай. Үүнийг ямар ч байсан мэдээж төгс төгөлдөр хууль гарахгүй л байх.

Тэгэхээр нь алдаа дутагдал юм байх л байлгүй дээ. Үүнийг нь цааш нь засаж залруулаад бид явж болох байх. Тэгэхээр ямар ч байсан нэг ийм хуультай болж байгаа нь сайшаалтай байна. Тэгэхдээ зүгээр яах вэ, нэг бодож санадаг хоёр, гурван юм хэлье. Зүгээр нэг л асуулт байгаа юм.

Төрийн албан хаагчид маань одоо энэ цалин багатай, хангамж муутайхан шиг ингээд зүтгэж байна гээд гишүүд болгонд л яриад байна. Ялангуяа хөдөөний гишүүд. Энэ яг байдагт амьдрал ийм л байгаа юм. Мэдээж тэр ёс суртахууны асуудал ард иргэдийг бухимдуулдаг. Тэр тэгээд л цаашлаад л авлига, хээл хахууль, худал хуурмаг хулгайтай холбоотой юм бол дээгүүрээ л нөгөө том акулуд энэ Улаанбаатарын хавиар л байгаа шүү дээ.

Хөдөөгийн маань энэ алслагдсан газар, ажиллаж байгаа төрийн албан хаагчид маань энэ тал нь харин тийм айхтар юм гайгүй л дуулдаад байдаг юм.

Тэгэхдээ яах вэ, энэ хэд маань нэг үйлчилгээгээ үзүүлж байхдаа янз бүрийн харьцаа үүсгэсэн. Цаад талдаа бол санаатай санаагүй сэдэл янз бүр байдаг байх. Бид ямар хүний дотор орж үзсэн биш гэж нэг үг бий. Тийм ээ. Тэгэхлээр энэ чинь хүний доторх хүнийг бид чинь хянаж шалгах гэж байгаа учраас бас их хэцүү ажил юм шиг байна. Ямар сэдлээр чухам ийм үйлдэл хийв. Үйлдэхийг бол бид амархан шигээ тодорхойлчихно. Энэ зүй бус харьцлаа гээд. Тэгтэл сэдэл нь хөөрхий минь зөв байсан байж болно. Бид үүнийг яаж мэдэх вэ? Энэ тал руугаа яаж жоохон гүнзгий зохицуулалт хийж харах гэж оролдсон юм бол энэ хууль дээр.

Дээрээс нь нөгөө төрийн албан хаагчид маань тэр өдөр өглөөнөө буруу хөл дээрээ бослоо гэдэг шиг бас сэтгэл санааны хувьд ч гэсэн ирээд тэгээд л нэг хоёр гурван ширүүн үг хэлчихдэг. Нөгөө иргэн маань гомдоож явчихдаг. Тэгээд ингээд тэрний нь гаднаас үйлдлээс нь харахаар зэрэг үнэхээр ёс суртахууны айхтар догол гаргачихсан юм шиг болоод. Нөгөөдөх нь даамжирч яваад. Нөгөөдөх иргэн маань бас нэлээн араас нь хөөцөлддөг. Бас шартай, хэл амтай шиг ингээд хөөцөлддөг. Ингээд л нөгөө нэг төрийнхөө албан хаагчийг бас хөөрхий минь тэр өдрийнх нь нэг. Бид нар өглөө болгон л заримдаа сайхан зантай, заримдаа муухай зантай, өглөө гэрээсээ гарахдаа бид нараас хамаарахгүйгээр бидний сэтгэл санаа, үйлийн үр ч ямар ч юм. Хажуу дахь гэр орон, нөхцөл байдал, амьдралын нөхцөл байдал гээд л олон юмнаас шалтгаалж янз бүрийн зан характертай гарч ирдэг.

Тэгэхээр энэ талаас нь бид нэг зөвлөгөө өгдөг. Тэр өдөр нь жишээлбэл төрийн албан хаагчдад сэтгэл зүйн талаас зөвлөгөө өгч, энэ үнэхээр тэр өдөр нь сэтгэл санаа үймэрсэн байвал тэр өдөр нь ажлаас нь үдээс өмнө нь ч юм уу, тэр өдөр нь чөлөөлөөд ч юм уу. Одоо дараа нь нөхөж ажиллахаар ч юм уу ингэж олгодог барьдаг энэ зохицуулалт оруулж өгч, төрийнхөө албан хаагчдыг хамгаалж өгсөн юм нь энэ дундаа байвал бас зүгээр юм шиг санагдаад байгаа юм.

Энэ их нарийн л их мэдрэмжтэй, ийм л нэлээн гүнзгий ийм агуулгатай л хууль байх ёстой байх гэж бодоод байгаа юм. Энэ талуудыг нь бодохоор зэрэг.

Тэгээд энэ төрийнхөө албан хаагчдыг зөв өө. Энэ хууль зөв байна. Тэгэхдээ бас нэг төрийнхөө албан хаагчдыг хамгаалж өгсөн нэг ийм юмнууд нь орсон тийм зүйл, заалтууд энд байна уу гэж асууя.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Гишүүний асуултад. Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн хариулна.

Б.Бат-Эрдэнэ: Ц.Цэрэнпунцаг гишүүний асуултад хариулъя. Хуулийн төслийг дэмжиж байгаа явдалд баярлалаа. Тантай санал нэг байгаа.

Энэ хуулийн төсөлд төрийн албан хаагчдынхаа эрхийг хамгаалах, эрх ашгийг хамгаалах чиглэлээр бас тодорхой зүйл заалтууд тусгагдсан байгаа. Төрийн албан хаагчдын эрх бүхий албан тушаалтны буруу хандлага энэ үйл ажиллагаанаас хамгаалах ийм тодорхой зохицуулалтууд байгаа.

Цаашлах юм бол гомдол гаргагч, түүнчлэн зөрчилд холбогдсон төрийн албан хаагч дээд шатандаа дав давж асуудлаа тавих тийм боломжийг нь нээж өгсөн байгаа. Үүний зэрэгцээгээр гомдол гаргах энэ асуудлуудыг нь тодорхой шаардлага тавигдсан байгаа. Мөн энэ ёс зүйн зөрчлийн хариуцлага тооцох асуудлуудыг нь ямар процессоор, хэрхэн яаж шийдвэрлэх вэ гэдгийг нь нэлээн нарийвчилж. Үүний цаад талд хүний ёс зүйн зөрчил, тэр хариуцлагыг хэн нэгний үзэмжээр хариуцлагаас мултрах тийм боломжийг нь хааж өгсөн. Нөгөө талаасаа хэн нэгнийг хэлмэгдүүлэх тийм асуудал гаргахгүй байх талаас энэ хуульд тодорхой ийм асуудлуудыг оруулсан.

Төрийн албан хаагчдын цалин, нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг төр бодлогоороо онцгой анхаарч үзэхгүй бол төрийн албан хаагчдын цалин, нийгмийн баталгаатай холбоотой эрүүл мэндийн салбарын ажиллагсад, багш нар гомдол тэмцэл хийж байгаа. Энэ аргагүй. Ялгамжтай байдлаар тогтоогоод байна.

Үүний цаад талд төр байгалийн баялгаас орж ирж байгаа энэ сул мөнгөөр төрийн албан хаагчдынхаа цалин, нийгмийн баталгаатай холбоотой асуудлыг нь шийдээд яваад байхаар хувийн хэвшил маань ямар хэмжээнд хүрэх вэ. Энэ чинь улс орон бид өмчийн олон хэлбэртэй.

Хэрэглээ энэ зах зээлийн эдийн засаг руу шилжчихээд 30 гаруй жил явж байгаа. Эдийн засгийн амьдралын 80 хувийг нь хувийн хэвшил нуруун дээрээ үүрч байна гээд тунхаглаад байдаг. Гэтэл яг ийм байдлаараа явах юм бол амаргүй ийм нөхцөл байдлууд бий болохоор байгаа юм. Би энэ асуудлыг би олон удаа тавиад байгаа юм.

Үнэхээр энэ байдал чинь нөлөөлж байна. Яг төрийн анхан шатны байгууллага тэр аймаг, суманд ажиллаж байгаа төрийн албан хаагчдын авч байгаа цалин, нийгмийн баталгаатай холбоотой тулгамдсан асуудал байна уу гэвэл байна. Энэ асуудлыг тусад нь нэг мөр холбогдох хуульд шийдвэр, бодлогын хувьд нэг цэгцлэх ийм шаардлага байгаа юу гэвэл байгаа. Ганцхан төрийн албанд ажиллаж байгаа хүмүүст тавигдах тэр нийтлэг ёс зүйн хэм хэмжээ, шаардлагуудаа бид тогтвортой, ойлгомжтой, нэг мөр болгох ийм шаардлагын үүднээс суурь энэ хуулийг оруулж ирж байгаа юм. Бодит байдал ийм л байна.

Улс төрийн нөлөө бий. Монголчууд энэ улс төрөөрөө бол энэ 30 жилийн хувьд улс төржиж, намчирхаж айхтар талцсан. Энэ нь төрийн албаны төлөвшил, төрийн албандаа итгэх ард түмний итгэлийг сулруулах нэг үндсэн шаардлага, үндсэн нөхцөл бий болсон уу гэвэл хүн болгон хүлээн зөвшөөрөх байгаа. Энэ дарга, удирдлагуудтай холбоотой асуудал бий шүү. Энэ дарга удирдлагууд бол нэг газар цүнх барьж байгаад очиж томилогддог. Томилогдсоныхоо маргааш баг бүрдүүлэх нэрээр олон хүмүүс, төрийн албан хаагчдыг зайлуулдаг.

Өөрийнхөө баг гэж ямар ч мэдлэг чадвар байхгүй. Дээрээс нь ёс зүй, харьцаа хандлага огт байхгүй ийм хүмүүсийг.../минут дуусав/

С.Одонтуяа: Ц.Цэрэнпунцаг гишүүн тодруулъя.

Ц.Цэрэнпунцаг: Баярлалаа.

Ер нь яах вэ, ерөнхий санаа бол ер нь хамгаалалтаа бас зэрэг хариуцлага нэг талд нь оноож байна. Тийм ээ. Тийм учраас нөгөө талд нь бас шударга хамгаалалтын ийм сайхан оруулж өгч явах нь зөв байгаа.

Хамгийн гол нь бид нар бас нэг төрийн нийт албан хаагчдад нэг ийм нийт суурь хууль орж ирж байгаа учраас төр, иргэн хоёр хоорондоо ер нь ямар харьцаатай байх юм бэ гэдгийг манай төрийн албан хаагч сайн бодож баймаар байгаа юм. Уламжлалт бидний харьцаа бол төр бол тэр дээр байгаа. Одоо нөгөө бурхны оронд ирсэн шүү дээ. Чухаг дээд гурвын оронд төр ирсэн.

Дээр үеэсээ ч тийм байсан гэдэг утгаараа. Тэгээд дээрээс харьцдаг, дээрээс өнгийж харьцдаг нэг ийм. Бид нар бол яагаад гэвэл тэр дээр байгаа төрд үйлчилж байгаа учраас иргэд та нар бол энэ доор байгаа. Бидний зарц боол юм гэсэн маягаар харьцдаг нэг ийм уламжлалт харьцаа бидэнд байдаг

шүү. Энэ бол хүмүүсийн дотор ер нь бичигдээгүй, бодож агуулагдаж явдаг төрийн албан хаагч ч байгаа. Дарга цэрэг нарт бол бүр их байгаа. Үүнийг сайн бодолцож бас энэ хууль дээрээ.../минут дуусав/

С.Одонтуяа: Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн асуултаа асууя.

Х.Булгантуяа: Төрийн алба ёс зүйтэй байх гэдэг чухал.

Би зүгээр жоохон санаа зовниж байгаа нь энэ нэг дээд шатандаа үйлчлэл багатай, доод шатандаа нэг их хатуу үйлчилсэн, ажил албан тушаалаас нь огцруулах үндэслэл болсон, хариуцлага тооцсон тийм л хууль болчих вий дээ гээд л жоохон айж байна.

Энэ Төрийн албаны зөвлөлөөс асууя. Төрийн албаны зөвлөлийн 2020 оны үйл ажиллагааны тайланд нийтдээ 12 байгууллага, 10 яам хамрагдаад ингээд нийтдээ 1194 төрийн байгууллагад Ёс зүйн зөвлөл байгуулагдсан. Баахан хүмүүсдээ ингээд хариуцлага тооцсон юм байна.

Үүнд төрийн албаны дээгүүр зэрэгтэй албан тушаалтан хэчнээн хүмүүст, хариуцлага тооцсон хүмүүсээс хэдэн хувь нь байгаа вэ?

Дээрээс нь нэмээд энэ нөгөө санкцууд дээр нь 8.1.1 дээр төрийн албан хаагчид тавигдах ёс зүйн нийтлэг шаардлага гэдэг дээр төрийн байгууллагын үйл ажиллагааны соёл, дэг журам энэ тэр гээд.

Ер нь завхралын чинь гол зүйл нь дэг журам нь, соёл нь өөрсдөө яг бичигдээгүй, журамлагдаагүй байгаад байгаа болохоор би одоо ямар нэг байгууллага дээр очиход энэ байгууллагын соёл гэж яг юу юм бэ гэж хаана, ямар бичсэн юм байдаг юм бэ? Одоо би бол сайн мэдэхгүй байгаад байна.

Ер нь энд тэнд хувийн хэвшил ч гэсэн дээ ажилд ороход бараг манай байгууллагын соёл энэ, манай байгууллагын дүрэм энэ, манай байгууллагын бүтэц ийм гээд бараг долоо хоногийн сургалт хийдэг. Төрийн байгууллагад бол ер нь ийм зүйл бол бас муу л харагдаад байх юм. Соёл, дэг журам гэдгийг хаана, ямар баримт бичигт үндэслэж үүнийг ярьж байгаа юм бэ?

Дээрээс нь Төрийн албаны хуулийг зөрчих юм бол гэдэг санкц дээр эхлээд ямар ч байсан сануулах юм байна. Тэгээд дараа нь халах хүртэл. Ганцаарчилсан хэлбэрээр сануулаад. Нийт ажилчдынх нь өмнө нээлттэй сануулаад. Төрийн албанаас халахыг сануулаад. Тэгээд төрийн албанаас халах ийм шийтгэл ногдуулах гэсэн ийм таван янзын шийтгэлтэй юм байна.

Тэгэхээр хэрвээ энэ өдрөөс хойш нэг жилийн дотор ёс зүйн зөрчил гаргаагүй бол ёс зүйн хариуцлага хүлээснийхээ дараа.

Тэгэхээр төрийн албанаас халагдчихаад ахиад нэг жилийн дараа дахиад төрийн албандаа орж болно гэсэн үг үү? Ёс зүйн алдаануудыг гаргасан болохоор болно гэсэн үг үү?

Дээрээс нь энэ хууль дээр байгаа нэлээн олон зарчмууд Хөдөлмөрийн тухай хууль дээр байна л даа. Ялгаварлан гадуурхах гээд. Энэ бол бүр бүхэл бүтэн нэлээн том зүйл болоод Хөдөлмөрийн хууль дээр орчихсон. Төрийн албанд ажиллана гэдэг чинь л адилхан хөдөлмөрийн харилцаа үүсэж байна. Ажил олгогч тал нь л төрийн байгууллага байна гэсэн үг.

Тэгэхээр энэ Хөдөлмөрийн хууль дээр орсон байгаа зүйлүүдийг дахин үүн дээр оруулж өгөх хэрэгцээ шаардлага байсан юм уу гэдэг нэг ийм хэдэн асуултыг асууя. Тэгээд шаардлагатай бол тодруулъя.

С.Одонтуяа: Мэндчилгээ дэвшүүлье. Улсын Их Хурлын гишүүн Хассуурийн Ганхуяг, Жамбалын Ганбаатар, Салдангийн Одонтуяа нарын урилгаар нийслэлийн Баянгол дүүргийн ерөнхий боловсролын 77 дугаар сургуулийн 12 дугаар ангийн багш, сурагчид Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна. Та бүхэнд сурлагын өндөр амжилт хүсье. /Алга ташив/

Би бас Баянгол дүүргээс сонгогдсон С.Одонтуяа гишүүн нь өнөөдөр хурал удирдаж байна. Баярлалаа.

Хэн хариулах уу? Б.Бат эрдэнэ гишүүн хариулах уу? Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн хариулъя.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Манай ажлын дэд хэсэг нэмээд хариулт өгөөрэй.

Ер нь энэ хуулийн зорилго бол төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлагын төрлийг тогтоож, ёс зүйн хариуцлага хүлээлгэх үндэслэл журмыг зааж өгсөн.

Албан тушаалтан өөрөө хариуцлага хүлээх соёлыг төлөвшүүлэх зорилгоор уучлалт гуйх, албан тушаалаа сайн дураараа огцорч, ёс зүйн хариуцлага хүлээх ийм соёл, ийм боломжийг л нээж өгөхийг эрмэлзэж байгаа.

Нөгөө талынх нь юм бол одоо хариуцлага тооцохоосоо өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээ гэдэг бол их том байр суурь эзэлж байгаа. Соён гэгээрүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах энэ зохицуулалтыг хуульд оруулж өгсөн байгаа.

Бид сайн мэднэ. Өөрөөсөө эхлэх ёстой. Ялангуяа дээд талаасаа. Төрийн өндөр албан тушаалтнуудаасаа эхлэх ёстой. Шатны гишгүүрийг доороос нь шүүрдэггүй ээ. Шатны гишгүүрийг дээрээс нь шүүрдэнэ ээ гэдэг энэ үг, энэ

зарчимд нийцүүлж бид Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн дүрмийг баталж хэрэгжүүлээд одоо мөрдөж байгаа.

Тийм учраас тантай санал нэг байгаа. Энэ хууль гаргаад зөвхөн эрх бүхий албан тушаалтнуудын эрхийг хамгаалсан, эрх үүрэг бүхий албан тушаалтнууд өөрийнхөө харьяанд ажиллаж байгаа албан хаагчдаа шавхуурддаг, чичилдэг, хариуцлага тооцдог, өөрийнхөө санаа нийлээгүй хүмүүсээ ажлаас зайлуулдаг ийм хууль, ийм нэг арга хэрэгсэл болохоос бид сэргийлж тодорхой хамгаалалтын зохицуулалтуудыг оруулж өгсөн.

Би түрүүн гишүүдийн асуултад хариулсан. Давах боломж нь нээлттэй байгаа. Бүр төрийн албаны дэргэдэх энэ хуулиар байгуулагдах Ёс зүйн хороонд асуудлаа тавих ийм боломжийг нь нээж өгсөн байгаа. Энэ асуудлуудыг нь шийдэх цаашлах юм бол энэ ёс зүйн хариуцлагыг тооцохгүй байх хугацаа энэ зүйлийг нь хууль зүйд нь нийцүүлээд, жишигт нийцүүлээд ингээд энэ хуулийн төсөлд оруулсан байгаа гэдгийг хэлье.

С.Одонтуяа: Нэмж 95 дугаар микрофон. Ч.Бат-Эрдэнэ үү? Төрийн албаны зөвлөлийнх. Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ.

Ч.Бат-Эрдэнэ: Төрийн албаны зөвлөлийн Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ. Х.Булгантуяа гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

Эхний асуудал нь Төрийн албаны тухай хууль, энэ ёс зүйн хуулийн төсөлд туссанаар энэ халах сахилгын шийтгэл ногдуулсан хүн эргээд жилийн дараа төрийн албанд орж болох уу гэсэн ийм асуулт байсан.

Тэгэхээр өнөөдрийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Төрийн албаны хуулиар авлига, ашиг сонирхлын гэмт хэрэгт холбогдоод шүүхийн шийтгэх тогтоол хүчин төгөлдөр болсон ийм төрийн албан хаагчдыг бол эргэж төрийн албанд орох эрхгүйгээр ингэж халах ийм зохицуулалттай.

Бусад гэмт хэргийн тухайд бол энэ хөөн хэлэлцэх хугацаа мөн ял шийтгүүлэлгүй болсон тооцох тухай энэ хугацаа өнгөрсөн бол төрийн албанд орох шалгуур шаардлагынхаа хүрээнд ерөнхий тусгай шалгалтаа өгөөд орж болох энэ эрх нь нээлттэй байгаа гэдгийг танд хэлье.

Дараа нь энэ Хөдөлмөрийн хуульд бас тодорхой заалтууд байна гэсэн ийм зүйл та асуусан.

Тэгэхээр энэ гаднын улсуудын туршлагыг судлаад үзэхэд энэ ёс зүйн асуудлыг нэгд энэ **“хууль тогтоомж, дүрэм журамд суурилсан нийтлэлийн ёс зүйн хандлага”**, нэг нь болохоор **“зарчимд суурилсан ёс зүйн хандлага”** гэсэн ийм хоёр хэлбэрээр энэ ёс зүйн байдалд нь хяналт тавиад байгаа.

Үндсэндээ нэг нь хатуу дүрэм журмаар тогтоож ёс зүйн байдалд нь хариуцлага хүлээлгэдэг. Энэ зарчмыг авлигын индексээрээ өндөр байгаа улсууд хэрэглээд явж байгаа. Авлигын индекс бага хөгжилтэй улс орнуудад энэ зарчимд суурилсан ёс зүйн хандлагыг баримталж байна.

Орчин үед олон улсын чиг хандлага нь ямар түвшин рүүгээ явж байгаа вэ гэхээр үүнийг холимог байдлаар хэрэгжүүлэх нь зүйтэй байна гэсэн ийм чиг хандлага руугаа олон улсын байгууллагын судалгаанууд бас гарч байгаа.

Тийм учраас энэ хүрээндээ маш олон хуулиудын нийцлэлийн үндсэн дээр энэ ёс зүйн байдалд давхар давхар хяналтуудыг тавих ёстой гэдэг. Энэ дээр Хөдөлмөрийн хууль, энэ шүгэл үлээгчийн хууль гэж байж байна. Авлигын хууль. Мөн Нийтийн албаны ашиг сонирхлын зөрчлийн хуулиуд. Энэ хуулиуд маань хоорондоо уялдаж байж энэ ёс зүйн байдалд нь хяналт тавихад илүү үр дүнтэй байна гэсэн ийм хандлага давамгайлж байна.

Монгол Улсын хэмжээнд өнөөдрийн байдлаар ёс зүйн код буюу төрийн албан хаагчийн ёс зүйг дүрмээр тогтоосон 31 гаруй ёс зүйн дүрэм байж байгаа.

Тэгэхээр энэ хууль маань суурь хууль болоод батлагдаад гарсны дараагаар төрийн байгууллагын төрийн бүх шатанд энэ ёс зүйн код, дүрмүүдээ нэгдсэн байдлаар шинэчилж сайжруулах ийм ажил гарах юм. Баярлалаа.

С.Одонтуяа: Ч.Бат-Эрдэнэ дарга нэмээд хариулчих.

Ч.Бат-Эрдэнэ: Нэмэлтээр хариулъя.

Бид бүхэн Төрийн албаны тухай хууль шинэчилсэн найруулга батлагдсаны дараагаар энэ төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм батлагдсан. Энэ дүрэм маань бодит амьдрал дээр маш их үр дүнгээ өгч байгаа.

Энэ Ёс зүйн зөвлөлүүд бүрэн гүйцэд энэ төрийн захиргаа болон төрийн үйлчилгээний албан дээр байгуулагдаад ингээд дуусаж байна. Энэ дээр ямар асуудал тулгамдаад байгаа вэ гэхээр энэ Ёс зүйн зөвлөлийг чадавхжуулах, Ёс зүйн зөвлөлийн гишүүдийг ёс зүйн зөрчлийг шалган шийдвэрлэх энэ процессын үйл ажиллагаанд сургах, бусад энэ захиргааны, эрүүгийн, Төрийн албаны тухай хуульд заасан сахилгын зөрчлүүдээс хэрхэн ялгах юм бэ гэдэг энэ чадавхжуулах ажил их чухал байна.

Энэ дүрэм батлагдсанаас хойш багагүй хэмжээний чадавхжуулах сургалтуудыг 2019, 2020, 2021 онд зохион байгуулсны үр дүнд энэ ёс зүйн зөрчлийн тоо их багасаж байна. Үндсэндээ 3 жилийн хугацаанд аваад үзэх юм бол төрийн захиргааны албан хаагч нь 819, төрийн үйлчилгээний албан хаагч 850. Нийтдээ 3 жилийн хугацаанд 1669 ёс зүйн зөрчил бүртгэгдсэн байж байгаа.

Тэгэхээр Ёс зүйн зөвлөлүүд чадавхжсанаар ёс зүйн зөрчил гаргахаас урьдчилан сэргийлэх энэ ажил бас бодитой үр дүнд хүрнэ гэсэн ийм ойлголттой байгаа.

Нийтлэг гараад байгаа зөрчлүүд ямар байдаг юм бэ гэхээр Төрийн албаны тухай хуульд заасан албан үүргээ хангалтгүй биелүүлэх, мөн согтууруулах ундаа хэрэглэх, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг зөрчих энэ асуудлууд. Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй байгаа, ажлын цаг ашиглалттай холбоотой. Мөн энэ харилцаа, хандлагатай холбоотой ийм зөрчлүүд нийтлэг давамгай байдалтай байгаа юм. Баярлалаа.

С.Одонтуяа: Х.Булгантуяа гишүүн тодруулъя. Нэмэлт 1 минут.

Х.Булгантуяа: Би нөгөө хуулийн танилцуулга дээр байгаа. 1422 төрийн албан хаагч байгаагаас сая энэ зөрчилтэй гэж гарснаас та бүхэн 2020 оны төрийн тусгай 809, 353 нь төрийн захиргааных байна гэж байна.

Тэгэхээр үүн дотор ТЗ дотор. ТЗ-1 нь 500 гаруй мянган төгрөгийн цалингаас эхэлж байх шиг байна. Тэгэхээр ТЗ15. Өндөр дээд албан тушаалтай хүмүүс энэ зөрчилтэй гэж илрүүлсэн хүмүүс дотроос чинь хэд байгаа юм бэ?

Өмнөх шалгалтаар чинь хэрвээ энэ зөрчилтэй гэж гаргасан хүмүүс нь ихэнхдээ бага албан тушаалтнуудад нэлээн хатуу чанга сахилга хариуцлага ногдуулаад байдаг. Нэмээд ахиад ийм ёс зүйн дүрэм гаргаад ахиад тэр хүмүүстээ бүүр их чангалаад байх вий гэж энэ асуултыг нэгдүгээрт асуугаад байгаа юм.

Хоёрдугаарт, Хөдөлмөрийн хууль дээр би энэ ялгаварлан гадуурхалт энэ тэр дээр нэлээн тодорхой сайн биччихсэн байгаа учраас тэрийг дахин ийшээ оруулах шаардлага байсан юм уу?

Гуравдугаарт, Төрийн албаны тухай хууль дээр сэтгэцийн өвчин, эмгэггүй байх гэдгийг та бүхэн бас яаж тогтоодог юм бэ?

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Ч.Бат-Эрдэнэ дарга хариулах уу? 95 дугаар микрофон. Маргаан хянан шалгах газрын дарга Ч.Бат-Эрдэнэ.

Ч.Бат-Эрдэнэ: Х.Булгантуяа гишүүний асуултад нэмэлтээр хариулъя.

Энэ чангатгах гэдэг энэ асуудал дээр жишээлэхэд төрийн захиргааны албан тушаалтны зөрчлийн тоо жишээлэхэд 2019 онд 316 байсан. 2020 онд 353, 2021 онд 150 болоод ингээд буучихсан байж байгаа.

Үйлчилгээнийх нь бол бас 2019 онд 321, 2020 онд 260 болоод ингээд буучихсан ийм үзүүлэлт байж байгаа.

Ер нь яг энэ ёс зүйн хууль маань батлагдаад гарсны дараагаар ямар бодлого баримтлах ёстой вэ гэхээр энэ ёс зүйн зөрчлийг гарсны дараа шийдэх биш гарахаас урьдчилан сэргийлэх чиглэлд Ёс зүйн зөвлөлүүд байгууллага бүр дээрээ ажиллах ёстой юм байна гэдэг энэ бол хамгийн том чухал зарчим байгаа.

С.Одонтуяа: Ч.Бат-Эрдэнэ дарга гүйцээгээд хариулчих.

Ч.Бат-Эрдэнэ: Энэ яг одоогийн байдлаар яг ТЗ 10-аас дээш гэдэг тоо нь яг одоогоор бэлэн байхгүй байна. Танд тусад нь гаргаад ингээд хүргүүлье. Бидэнд яг энэ ёс зүйн мэдээллийн тайлан хагас бүтэн жилээр нэгтгэгдээд байж байдаг.

Тэгэхээр танд хүргүүлье.

С.Одонтуяа: Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн асуултаа асууна.

О.Цогтгэрэл: Энэ Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг анх удаагаа хуулиар зохицуулах гэж байна л даа. Анхдагч хууль.

Үүн дээр би дахиад л тэр суурь асуултыг нь асуумаар л байна. Энэ ёс зүй гэдэг зүйлийг яг хуулиар яаж хэмжиж, яаж хариуцлага тооцож, яаж шагнаж урамшуулж. Энэ дээр чинь ер нь дэлхийн бусад орнуудад, тэр тусмаа энэ хүний эрхийг дээдэлдэг орнуудад яг ийм хууль байна уу? Одоо энэ хуулийн судалгаа хийж байхад. Тэр тусмаа хүний эрхийг дээдэлдэг гэж байгаа орнуудад.

Энэ хүний эрхийн асуудал яг үүний чинь цаана яваад байна л даа. Энэ чинь субъектив. Хэмжиж болохгүй. Бүр хэтрүүлээд хэлэх юм бол дур зоргийн шийдвэрүүд энэний цаана чинь гарах нөхцөл бололцоо олон зүйл энд харагдаад байх юм.

Яг үүн дээр дахиад асуухаар тэр ерөнхий юм руу орчих байх. Тэр хүний эрхийг дээдэлдэг орнуудад яг ёс зүйг хуульчлан тогтоож байгаа, хуулиар хариуцлага ноогдуулах боломж бололцоог бүрдүүлж байгаа жишээ байна уу?

Дараа нь энэ Төрийн албаны зөвлөлөөс нэг асуулт байгаа юм. Ер нь Монголын төрийн албан албан хаагчийг сонгон шалгаруулж байгаа тогтолцоотой холбоотой. Монголын төрийн алба гээд яривал захиргаа, үйлчилгээний албыг дийлэнх нь орох байх. Үүний ажил олгогч нь Засгийн газар.

Тэгэхээр ажил олгогч хүн ажилтнаа сонгон шалгаруулж авч байгаа энэ үйл явцыг шал өөр байгууллага. Төрийн албаны зөвлөл гэдэг хөндлөнгийн байгууллага шалгаруулж өгч тэр гүйцэтгэх ажлыг нь хийж байгаа нь тогтолцооны хувьд энэ хэр зөв бэ?

Тарин тэр Төрийн албаны хуулийг биелүүлэх, хяналт тавих энэ үүрэг чинь Төрийн албаны зөвлөлтэй байгаад Засгийн газар чинь тэр ажил олгогчийнхоо үүднээс. Тэр тусмаа тэр гүйцэтгэх ажлаа өөрөө хийгээд явах ёстой юм биш үү. Яг энэний чинь цаана дахиад л яг төрийн албаны чадвар, болзол шаардлага, хүний нөөцийн олон зүйл чинь. Компани ч гэсэн тэр гүйцэтгэх удирдлагын баг өөрөө хүнээ шалгаруулж аваад магадгүй ТУЗ-ийн дэргэдээ бусад хяналтын хороод нь байж л байдаг шүү дээ.

Тэгэхээр Төрийн албаны зөвлөл, Засгийн газар хоёрын энэ ажил олгогч болоод энэ зохицуулах харилцаа энэ чинь тогтолцооны хувьдаа ер нь хэр зэрэг зөв гэж одоо манай төрийн албаныхан, Төрийн албаны зөвлөлийнхөн энэ дээр боддог вэ? Үүн дээр байр сууриа илэрхийлээч.

Тэгээд тэр эхний асуулт нь хүний эрхийг дээдэлдэг гэж байгаа орнуудад ёс зүй, ёс суртахууныг хуульчлан тогтоож байгаа жишээ баримтууд хэр их байна вэ?

С.Одонтуяа: Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуун. 92 дугаар микрофон. Б.Бат-Эрдэнэ гишүүн хариулаад. Нэмээд дараа нь Б.Идэрчулуун гуай хариулчих.

Б.Бат-Эрдэнэ: Тийм. О.Цогтгэрэл гишүүний асуултад хариулъя.

Ёс зүйн асуудал бол их л чухлаар тавигдаж байгаа юм даа. Олон улсын өнөөгийн практикт ч гэсэн энэ тавигдаж байгаа л асуудал байна. Бид 90 онд шинэ нийгмийн харилцаа руу шилжээд, хүний хүмүүжил төлөвшлийн асуудал бол хувь хүний эрхийн асуудал гээд зөнд нь орхисон.

Өнөөдөр Монголын нийгэмд тулгамдаж байгаа олон асуудлын уг сурвалж энэ дээр тулгамдаж байгаа юм. Ёс зүйн асуудлыг огт хайхрахгүй яг зэрэгцүүлээд л ингээд явсан. 30 жилийнхээ бидний үр дүнг эргээд харахад бас сонин л дүр төрх гарах байх.

Энэ ёс зүй бол хүний биеэ авч явах төлөв байдлын мөн чанарыг онол бөгөөд ёс суртахуун, зан суртахууны хэм хэмжээтэй нягт холбоотой ухагдахуун.

Дээр нь төр гэдэг ойлголт бол энэ улс төрийн шинжлэх ухаанд ч тэгж үзсэн байдаг. Ард түмний санаа бодол, хүсэл зоригийг илэрхийлсэн, олон түмэнд үйлчилдэг байгууллага гэж үздэг.

Тийм учраас төр, иргэний харилцааны амин чухал асуудлын нэг нь төрийн үйлчилгээ эрхэлж буй төрийн албан хаагчдын үйл ажиллагаа, тэдний ёс зүйн байдалтай зайлшгүй л уялдаж холбогдож байгаа ийм л асуудал байгаа юм.

Тэгээд яах вэ, одоо ингээд хамаагүй гээд ингээд хаяад явах юм бол цаашаа ямар байх юм. Энэ тавигдаж байгаа хэм хэмжээ, нийтлэг шаардлагууд

бол нэг их хүний эрх, эрх чөлөөг хаагаад хясан боогдуулаад зөрчөөд байх ийм зүйл. Хүн хүнтэй зөв харьцах ёстой юу л зөв харьцах ёстой. Хүн архи уухгүй байх ёстой юу. Архи согтууруулах ундаа, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, бодис ийм юмнаас хол байх ёстой юу гэвэл хол байх ёстой л асуудал.

Өнөөдөр явж ирсэн юманд сэтгэц, хар тамхитай холбоотой төрийн бүр дээд удирдлагын түвшинд чинь асуудлууд яригдаж л байсан шүү дээ. Ийм л байгаа юм. Тэгээд энэ нь хамаагүй гээд л хаях юм бол тэгээд л хаях л юм.

Цаашдаа одоо энэ авлига, хулгайн асуудлыг хар л даа. Улсаа барьцаалж байгаад хөгжлийн банкаар дамжуулаад 1.8 их наяд. Төсвийн хуульд бид чинь төсөв батлахдаа урьд хожид байгаагүй 18 их наяд төгрөгийн төсөв баталсан. Улс орон даяар 1.8 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажил хийнэ гэж байгаа.

Тэр улс орон даяар хийх өчнөөн зуун цэцэрлэг, өчнөөн зуун километр зам, сургууль, цэцэрлэг барих хэмжээний мөнгийг л хэдхэн улсууд л хулгай хийгээд л авчихсан л байгаа шүү дээ.

Ингээд яах вэ, ер нь бол энэ төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагын эрх зүйн зохицуулалтын талаар гадаад зарим орны туршлага энэ юм нь дээр нэлээн үзсэн. Судалгааны хүрээнд төрийн албан хаагчийн ёс зүйн үндсэн зарчмыг тунхаглан, гишүүн улсууддаа дотоодын хууль тогтоомждоо тусган хэрэгжүүлэхийг уриалсан олон улсын байгууллагыг сонгож авсан.

Улс орнуудын хувьд парламентын засаглалтай, хөгжингүй болон хөгжиж буй орнуудаас сонголт хийсэн. Олон улсын байгууллагаас Нэгдсэн Үндэстний Байгууллага, Европын зөвлөл. Хөгжингүй улс орнуудаас Япон Улс, Сингапур, Солонгос, Австрали, Канад. Хөгжиж буй улс орнуудын жишиг туршлагыг үзсэн. Зүүн болон Төв Европын орнуудаас. Ингэж л үзсэн байгаа. Дэлгэрэнгүй материал байж байгаа.

Тэгээд энэ улс орнуудын нийтлэг чиг хандлагыг үзэх юм бол энэ ёс зүйн хэм хэмжээг хуульчлан тогтоох код, дүрмээр зохицуулсан улс орнууд ч байна. Хуульчилсан бие даасан, хуульчилсан улс орнууд ч байна. Япон Улс гэхэд 1999 онд парламент.../минут дуусав/

С.Одонтуяа: Б.Идэрчулуун Төрийн албаны зөвлөлийн гишүүн. 92 дугаар микрофон.

Б.Идэрчулуун: Баярлалаа. Төрийн албан хаагчийн ёс зүйг бол энэ гурван хэлбэрээр олон улсад зохицуулаад байгаа юм.

Нэг нь хууль тогтоомж, дүрэм журмаар зохицуулж байна.

Хоёр дахь нь ёс зүй зан үйлийн дүрмээр зохицуулж байна.

Гурав дахь нь зааварчилгаа юм уу, зөвлөмж чиглэл өгөх маягаар зохицуулж байгаа юм.

Тэгээд хууль тогтоомж, дүрэм журамласан энэ орнууд гэх юм бол Австри, Бельги, Канад, Чех, Дани, Испани, Финлянд, Франц, Грек, Унгар, Исланд, Итали Япон, Солонгос, Люксембург, Нидерланд, Норвеги, Польш, Португал, Турк, Америкийн Нэгдсэн Улс гэсэн.

Тэгэхээр ер нь төрийн албан хаагчийн ёс зүйг ярих ёстой юу гэвэл энэ дэлхий нийт яриад байна л даа. Хамгийн гол нь хүн нь хөгжөөгүй, нийгмийн тогтолцоо нь хөгжөөгүй, авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчил өндөртэй орнуудад хуульчлаад байгаа юм.

Хүн нь хөгжчихсөн, ёс суртахуун, ёс зүйн өндөр хүмүүжил олсон энэ ард иргэдийн дунд зөвлөмж, өөрийнхөө хийсэн буруу үйлдэлдээ ухамсарлаж, өөрөө уучлал гуйх замаар энэ ёс зүйн харилцаагаа ингээд зохицуулаад байгаа чиг хандлага байгаа юм.

1996 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий ассамблейн тогтоолоор төрийн албан тушаалтны ёс зүйн дүрэм, олон улсын дүрэм гээч юмыг баталсан байгаа юм.

Энэ дээр ерөөсөө гуравхан асуудлыг томъёолсон. Ямар гурван асуудал вэ гэхээр ерөөсөө төрийн байгууллага бол нийтийн ашиг сонирхлын төлөө ажиллахыг яг хуулиар тогтоох ёстой. Тэгэхдээ энэ төрийн албанд ажиллаж байгаа хүмүүс туйлын үнэнч байдлыг л эрхэмлэх ёстой гээд нэгдэх нь.

Хоёр дахь нь, төрийн албан хаагчид энэ хууль тогтоомжоор хүлээсэн үүрэг хүлээж ажиллахдаа үр дүнтэй ажиллана, үр ашигтай ажиллана, үнэнч шударга ажиллах ёстой гэсэн.

Гурав дахь нь, төрийн албан хаагчид үүргээ гүйцэтгэхдээ ерөөсөө хувийн ашиг сонирхол энэ юманд хутгалдахгүй, гагцхүү хуульд захирагдаж ажиллах гэсэн.

Ерөөсөө энэ гурван агуулгын хүрээнд дэлхийн улс орнууд ёс зүйн дүрэм, хууль, ёс зүйн зөрчлийг энэ гуравтаа хувааж авч үзэж байгаа юм.

Түрүүн Х.Булгантуяа гишүүн асуугаад байсан. Бусад хууль дээр хуульчилсан заалтуудыг энэ дээр оруулах шаардлага байна уу, үгүй юу гэж. Үүнийг бид хэрэв энэ хуулийг цааш нь хэлэлцэх шийд гаргах юм бол үүнийг засаж залруулаад явах боломжтой.

Хуулийн үйлчлэх хүрээ, бүрэлдэхүүн, зохион байгуулалт, бүтэц гээд. Энэ дээр засж залруулаад явчих боломжтой. Баярлалаа.

С.Одонтуяа: Одонгийн Цогтгэрэл гишүүн тодруулъя.

О.Цогтгэрэл: Хуулиар тодорхой. Ер нь энэ саяын асуудлыг ингээд тодруулаад дахин дахин асуухаар нэг тийм ёс зүйгүй байдлыг өөгшүүлэх гээд байгаа юм шиг сонсогдоод их төвөгтэй л юм байна.

Тэгэхдээ ер нь хуулиар тодорхой зааж хориглоогүй зүйлийг биелүүлээгүйнхээ төлөө тэнд тэгээд ямар түвшний ч юм уу санкц байж болно гэдэг өөрөө их л том асуудал дагуулах байх л даа.

Зүгээр түрүүний тэр нэг Төрийн албаны зөвлөлөөс асуусан асуултад гүйцээгээд хариулт авчихъя.

Ер нь энэ бүтэц, тогтолцооны хувьд Засгийн газар, ажил олгогчийнхоо хувьд тэр гүйцэтгэх ажлын тэр шалгалтыг нь аваад. Өмнөөс нь Төрийн албаны зөвлөлд баахан юм хийгээд байгаа чинь зөв юм уу, буруу юм уу. Тэнд гүйцэтгэх засаглал өөрөө ажил олгогчийнхоо хувьд хүний нөөцтэй, боловсон хүчний бодлоготой холбоотой зүйлээ хийчихээд. Хуульд нийцэж байгаа эсэхийг л Төрийн албаны зөвлөлд шалгадаг, хянадаг энэ тогтолцоо чинь тэр тал руу явах ёстой юм биш үү гэсэн ийм санал бодол байна л даа. Энэ дээр та нарын байр суурь явна байдаг юм бол?

Г.Занданшатар: 94. Төрийн албаны зөвлөлийн гишүүн, доктор С.Цэдэндамба хариулна.

С.Цэдэндамба: О.Цогтгэрэл гишүүний асуултад шуудхан хариулъя.

Яг таны хэлж байгаа шиг ийм тогтолцоо байсан. Ажил олгогч нар сонгож авдаг. Яг тэр үед л яриад байсан шиг ийм танил талаа авдаг, шалгалт шүүлэггүй авдаг, тухайн авах гэсэн хүндээ нь тааруулж өдөрт нь албан тушаалын тодорхойлолтыг өөрчилдөг, тэр хүндээ зориулсан тусгай шалгалт авдаг энэ бүх асуудал байсан учраас энэ 2014 оноос эхэлж яригдсаар байгаад шинэ хуульд энэ зохицуулалтыг, тогтолцоог ийм болгоё гэдэг зарчим дээр Улсын Их Хуралд хэлэлцээд энэ хуулийг баталсан. Одоо энэ дагуу явж байна. Тэгэхдээ Төрийн албаны зөвлөл байгууллагын дотоод үйл ажиллагаанд шууд оролцохгүй, зөвхөн сонгон шалгаруулж өгөөч ээ гэдэг захиалгыг нь биелүүлж байна.

Хоёрдугаарт, хуульд заасан ийм.../минут дуусав/

Г.Занданшатар: С.Цэдэндамбаа дарга товч тодорхой гүйцээгээд хариулчих. Нуршихгүй тодорхой.

С.Цэдэндамба: Тийм. Төрийн албаны зөвлөл бол Засгийн газрын буюу гүйцэтгэх засаглалын байгууллагуудын дотоод ажилд оролцоогүй ээ гэж хэлж

байгаа юм. Зөвхөн түүний захиалгыг биелүүлж байгаа. Яг хуулиар хүлээсэн үүргийнхээ дагуу.

Хоёр дахь нь, тэр стандартыг нь тогтоож өгөх үүрэгтэй. Хуулиар. Ямар албан тушаалд, ямар туршлага, мэргэжилтэй, мэдлэгтэй, ёс зүйтэй хүн байх вэ гэдэг тэр стандартыг нь тогтоож өгч байгаа.

Гуравдугаарт нь, энэ томилгооноос гадуур томилгоо хийж байгаа зүйлд нь хяналт хийгээд тийм зөрчил байх юм бол холбогдох мэдэгдэл, тэр тушаал шийдвэрийг нь хүчингүй болгох ийм үйл ажиллагаа хуулиар хүлээсэн энэ үүргээ биелүүлж байгаа.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Төмөртоогоогийн Энхтүвшин.

Т.Энхтүвшин: Баярлалаа. Хуучин бол. Одоо ч гэсэн энэ Засгийн газраас баталсан төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмээ мөрдөөд явж байгаа. Тэгээд энэ асуудал ингээд Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль болж орж ирж байгаа юм байна.

Үүнийг ерөнхийд нь дэмжиж байгаа. Дэлхий нийтээрээ л энэ хувь хүний ёс зүйн асуудал, ёс суртахууны асуудал нэлээн яригдаж байна. Дэлхий нийтээрээ анхаарал хандуулаад явж байна гэдгийг бас хэлмээр байна.

Энэ хууль ингээд батлагдаад гарах юм бол ер нь төрийн захиргааны албан тушаалтныхаа цалин хөлсний асуудлыг бид ярихгүй болохгүй ээ. Нийгмийн баталгааны асуудлыг дагаж ярихгүй болохгүй.

Өнөөдөр сум, орон нутгийн Засаг даргын Тамгын газар ажиллаж байгаа хүмүүс 450 мянган төгрөгийн л цалинтай явж ирж байна шүү дээ.

Тийм учраас би юу хэлэх гээд байна вэ гэхээр нийгмийн баталгаа, цалин хөлснөөс гадна манай Төрийн албаны зөвлөл бол энэ төрийн захиргааны албан тушаалтад ямар хүмүүсийг оруулах юм. Төрийн үйлчилгээний албан тушаалтанд ямар хүн оруулах вэ гэдгээ дахиж нэг ангилж нэг үзэхгүй бол болохгүй болсон байна. Тэр суманд байж байгаа хөдөө аж ахуй хариуцсан түшмэл, сумын Засаг даргын Тамгын газар ажиллаж байгаа малын их эмч, нийгмийн бодлогын түшмэлүүд маань төрийн захиргааны албан тушаалтанд орох шаардлага байна уу?

Үүнийг та хэд маань бас нэг эргэж хараач ээ.

Сум, орон нутагт маань ажиллах боловсон хүчин олдохгүй байна. Энэ шалгалтаас болоод. Энэ өндөр босготой шалгалтыг чинь давдаг ийм сумын төрийн албан хаагчид ховор болсон байна. Зөвхөн нэг аймгийн жишээгээр бодоход 280 хүн төрийн албанд дутагдалтай байж байна шүү дээ. Зөвхөн нэг аймгаар бодоод үз.

Тийм учраас та хэд маань төрийн захиргааны албан тушаалтан, энэ ангилал зэрэглэлүүдээ бас нэг ялгаж салгаач ээ гэдэг дээр хэлмээр байна.

Хоёр дахь асуудал бол яах аргагүй энэ төрийн өндөр албан тушаалтанд тавьж байгаа, тавигдсан энэ хүмүүс яах аргагүй улс төрийн нөлөөллөөр томилогдсон хүмүүс байж байгаа. Төрд ажиллаж байгаа мөртлөө улс төрийн нөлөөллөөр дарга болсон хүмүүс байж байгаа юм. Ажил нь явахгүй байгаа. Үлбэгэр сул дорой, ажлаа мэдэхгүй. Ийм юмнаас чинь болоод энэ төрийн албан хаагчдын нэр хүнд унаад байгаа юм. Нэр хүнд.

Тийм учраас энэ дээр цаашдаа онцгой анхаарч ажиллах хэрэгтэй гэдгийг хэлмээр байна.

Дараагийн асуудал. Энэ хууль дээр төрийн болон орон нутгийн өмчтэй компаниудын удирдлага, ТУЗ чинь энэ хуульд хамрагдах юм уу? Энэ төрийн албаны албан хаагчийн ёс зүйн хуульд дээрх хүмүүс маань хамрагдах юм уу? Үүнийг тодорхой хэлж өгөөч.

Дараагийн асуудал бол яах аргагүй энэ салбарын дүрмүүд байж байгаа. Цагдаагийн ёс зүйн дүрэм, эрүүл мэнд, эмч нарын, багш нарын ёс зүйн дүрмүүд байж байгаа. Хэрвээ юу гэдэг юм энэ хууль дээр ажлын хэсэг гараад ажиллах юм бол нэгтгээд нийлүүлээд нэг том хууль болгоод базах ийм бололцоо боломж байна. Заавал үүнийг тус тусад нь салбарын дүрэм гэхээсээ илүү энэ хуулиар нэгтгээд явчих ийм бололцоо боломж байна гэдгийг хэлмээр байна.

Дараагийн асуудал бол энэ Ёс зүйн хороо, Ёс зүйн зөвлөлтэй байх юм байна. Энэ Ёс зүйн хороо, Ёс зүйн зөвлөлд маань иргэн, төрийн бус байгууллагын төлөөлөл орж ажиллах юм уу? Үүнийг хэлж өгөөч.

Дараагийн асуудал бол энэ 14.4-т заачихсан байна. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгчийн ёс зүйтэй холбоотой гомдол гаргах, түүнийг хянан шийдвэрлэх харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна гээд жоохон бөөрөнхийлөөд оруулчихсан.

Тэгэхээр одоо юу гэдэг юм энэ улс төрийн албан тушаалтнууд чинь дахиж ийм ёс зүйн хууль хэрэгтэй юм шиг ингэж харагдаад байна. Энэ асуудал дээр бас нэг тайлбаруудаа хэлж өгөөч ээ гэж хүсэж байна.

Тэгээд ерөнхийд нь хуулийг дэмжиж байгаа. Яах аргагүй энэ хууль гарахаас өөр арга байхгүй. Гаргах ч ёстой. Бид цаашдаа ёс зүйтэй, ёс суртахуунтай ийм төрийн албан хаагчид болгохын тулд энэ дүрмийг хуульчлаад нэг мөр.../минут дуусав/

Г.Занданшатар: Зочид эхлээд танилцуулчихъя. Улсын Их Хурлын гишүүн Жигжидийн Батжаргал, Нямаагийн Энхболд нарын урилгаар Төв аймгийн

Жаргалант сумын иргэдийн төлөөлөл Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Та бүхэндээ Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс эрүүл энх, сайн сайхан, урт удаан наслахыг хүсэн ерөөе. /алга ташив/

Тэгээд энэ Төрийн албаны зөвлөл. Бас түрүүн Цэндийн Сандаг-Очир гишүүн ч асууж байсан. Олон гишүүд энэ Төрийн албаны тухай хуультай асуудлыг бас яриад байгаа юм.

Төрийн албаны тухай хууль одоо бас хэлэлцэж байгаа. Энэ аймаг, сумдад тавигдах шаардлага, нийслэлд тавигдах шаардлага. Төрийн захиргааны төв байгууллагад тавигдах шаардлага энэ тэрийг ангилж өгөхгүй бол хөдөөд яг тэр шаардлагад чинь нийцэх боловсон хүчний нөөц боломж, хомстол бас амьдралд нийцэхгүй юмнууд байгаа.

Тэгээд хэдэн аймаг, сумынхныг л Төрийн албаны зөвлөл шалгаад мянга есөн зуун хэдэн хүн шаардлага хангахгүй нь томилсон байна энэ тэр гээд л байдаг. Яг нийслэл дээрээ болж байгаа энэ томилгоо энэ тэр дээр яадаг вэ гэж аягүй чухал асуудлууд хэлээд байгаа шүү.

Тэгээд манай Жигжидийн Батжаргал гишүүн бол тойргийнхон нь ч ирсэн байна. Энэ аймаг, орон нутгийн амьдралтай холбоотой асуудлыг маш гүн гүнзгий мэдэж, хуралдаа байнга сууж яг энэ асуудлыг байнга хөндөж ярьдаг гишүүн. Тэгээд энэ үгийг нь анхаарч ажиллах хэрэгтэй байгаа юм.

Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороон дарга, хууль санаачлагч асуултад хариулна.

Хоёр гишүүний асуултын дараа асуулт хариултын цаг дуусна. Гишүүд чуулганы танхимд цуглаж санал хураалтад бэлтгэнэ.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Т.Энхтүвшин гишүүн хууль төслийг дэмжиж байгаагаа илэрхийлээд хэд хэдэн чухал санал, асуултыг тавилаа, санал хэллээ.

Тэгэхээр бид энэ хуулийн төслийнхөө 13.4-т Ерөнхийлөгч, Их Хурлын дарга, дэд дарга, гишүүд, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, бүх шатны шүүгч, прокурор, Шүүхийн сахилгын хорооны дарга, гишүүн, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, гишүүн, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, төлөөлөгчийн ёс зүйтэй холбоотой гомдол гаргах, түүнийг хянан шийдвэр, харилцааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна гээд оруулчихсан.

Энэ дээр таны хэлж байгаа саналаар илүү нарийвчилж тодорхой болгох саналыг хэлэлцэх эсгийг нь Их Хурал шийдчих юм бол та бүхэн маань энэ

ажлын хэсэгтээ ороод хуулийн төслийн илүү боловсронгуй чамбайруулах чиглэлээр ажиллах бололцоо нь бий.

Төрийн өмчит компаниудын хувьд нийтийн албаны тухай хуулиараа зохицуулагдана гээд ингээд орхичихсон байгаа. Хэлэлцүүлгийн явцад үүнийгээ авч үзэх бололцоо нь бүрэн нээлттэй байгаа.

Түрүүн гишүүдийн асуултад хариулахдаа бас ярьж байсан. Тантай санал нэг байгаа. Төрийн албан хаагчдынхаа нийгмийн хамгаалал, баталгаа, цалин урамшуулалтай холбоотой ялгамжгүй байх энэ асуудлуудыг нэг авч үзэх ёстой байх.

Дээр нь төрийн албан хаагчдынхаа тэр зааг ялгааг нэлээн тодорхой гаргахгүй бол өнөөдрийн хэрэгцээ шаардлагаар эмнэлэг, сургууль, цэцэрлэгүүд баригдаж байгаа. Үүнийг дагаад төрийн албан хаагчдын тоо нэмэгдэхээс өөр арга байхгүй. Ингэж ангилж зааглаж ялгаагүйтэй холбоотойгоор бас төрийн албаны үйл ажиллагаатай холбоотой асуудлууд гарч байгаа гэдэгтэй санал нэг байгаа.

Ер нь энэ даргалах бүрэлдэхүүний хувьд энэ төрийн нүүр царай болж үлгэр манлайлал үзүүлж ажиллах энэ хүрээндээ л бид энэ ёс зүйн нийтлэг хэм хэмжээ, нийтлэг шаардлагуудыг тавьж ажиллах ёстой л гэсэн үндсэн суурь зарчим маань энд байгаа юм гэдгээ хэлье. Баярлалаа танд.

Г.Занданшатар: Ц.Амартөгс 95. Цэнддаваагийн Амартөгс. Төрийн албан зөвлөлийн гишүүн.

Ц.Амартөгс: Гишүүний асуултад хариулъя.

Төрийн захиргааны албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлыг яалт ч үгүй эргэж харах, ялангуяа орон нутагт анхан шатанд ажиллаж байгаа төрийн захиргааны үүргийг хэрэгжүүлж байгаа энэ албан хаагчдын цалин хөлс, тэтгэврийн доод хэмжээтэй ижил түвшинд байгаа. Энэ асуудлыг бид эргэж харах талаар Засгийн газрын холбогдох яамдтай Сангийн яам, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамдтай ажиллаж байгаа.

Энэ ажиллах чиглэл маань ер нь энэ төрийн захиргааны албаны албан тушаалын ангилал, зэрэглэлийг тухайн албан тушаалынхаа хэрэгжүүлж байгаа чиг үүрэг, эрх хэмжээ, шаардлага, мөн үүрэг хариуцлагатай нь уялдуулан шинэчлэн тогтоох энэ асуудлыг ажлын хэсэг байгуулан бас судлах ажлууд хийгдэж байгаа. Энэ дээр ялангуяа төрийн захиргааны төв байгууллагууд, агентлаг, мөн орон нутгийн байгууллагуудын онцлог, ялгаа ялгамж ямар байх вэ гэдэг дээр нэгдүгээрт энэ асуудлыг авч үзнэ.

Хоёрдугаарт, салбаруудын хууль тогтоомжид орсон цалин хөлс нэмэгдүүлэх ч гэдэг юм уу, бусад бодлогын хүрээнд төрийн захиргааны чиг

үүргийг хэрэгжүүлэхгүй боловч төрийн захиргааны чиг үүрэгт орчихсон байгаа. Энэ ангилал, зэрэглэлд хамаарч байгаа албан тушаалуудыг хэрхэн яаж нэг нэгдсэн стандартад оруулах вэ гэдэг энэ асуудлыг шийдэх ийм үндсэн чиглэлүүд гараад судалгаа хийгдээд явж байгаа.

Тэгэхээр үүнийг мөн нэн даруй, ойрын хугацаанд болон ер нь цаашдаа системийнхээ хувьд аажмаар ямар систем төрийн албаны бүтцээ бий болгох вэ. Ангиллаа дөрвөн ангиллынхаа хэмжээнд ялгаа, ялгамж байгууллагуудын хэрэгжүүлж байгаа чиг үүрэг, мөн гаргаж байгаа шийдвэр, явуулж байгаа үйл ажиллагаатай холбоотой шинэчлэх ийм ажлууд хийгдээд эхэлж байна.

Г.Занданшатар: Одоо Төмөртөгоогийн Энхтүвшин гишүүн тодруулж асууна.

Т.Энхтүвшин: Төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагуудын захирал, удирдах зөвлөлийн гишүүдийг Төрийн албаны ёс зүйн тухай хуульд оруулаад явах нь зөв байх. Нэг заалтаар.

Би яагаад ингэж бодож байна гэхээр төрийн өмч буюу төсвийн хөрөнгөөр олсон ашгийг төсвийн хөрөнгөтэй адилтгаж үздэг.

Тийм учраас тэр төрийн өмчтэй компаниудын захирал нь, ТУЗ нь мөн ялгаа байхгүй бас энэ төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг ягштал мөрдөж ажиллах ёстой. Энэ хууль бол ялгаагүй тэр хүмүүст ч гэсэн үйлчлэх ёстой л гэсэн ийм байр суурьтай байгаа гэдгээ дахин илэрхийлье.

Г.Занданшатар: Баагаагийн Баттөмөр гишүүн асуулт сууна.

Б.Баттөмөр: Хуулийг дэмжиж байгаа. Өчигдөр бид Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороон дээр нэлээн тодорхой ярьсан.

Хуулийг санаачилж оруулж ирж байгаа Байнгын хорооны дарга Б.Бат-Эрдэнэ болон бусад хүмүүст талархаж байна.

Ер нь сая манай гишүүдийн яриад байгаа энэ ёс зүйн дүрэм бол бүх түвшинд ижил үйлчлэх ёстой. Тэгэхдээ өөр өөрийн онцлогтой байх ёстой гэдэгтэй санал нэг байгаа. Шаардлагаа өндөржүүлэх хэрэгтэй. Бас тэр нийгмийн хамгаалалтай, цалин хөлстэй холбоотой асуудлыг нь шийдэх ёстой гээд Т.Энхтүвшин гишүүний хэлж байгаа саналтай санал нэг байна.

Ер нь аливаа хөгжил гэдэг бол хүний хөгжил байдаг. Бид өнгөрсөн 30 жилийн хугацаанд хүний хөгжил гэхээр зэрэг л нэг мэдлэг гээд. Мэдлэг гэхээр зэрэг нэг баахан дээд сургууль төгссөн хүмүүс бэлтгэчихвэл болно гэж ингэж л үзэж ирсэн л дээ. 200 гаруй дээд сургууль байгуулах зөвшөөрөл олгочихсон байгаа шүү дээ. Өнөөдөр 70, 80 дээд сургууль 3-хан сая хүнтэй. Одоо 10 мянган

хүнд ногдох оюутны тоогоор дэлхийд нэгдүгээр байранд явж байгаа гэж байгаа юм. Тэр хэмжээгээр чанартай хүмүүс бэлтгэж байна уу гэхээр байдаггүй.

Тэгэхээр энэ ядуурлыг л дэвэргэж байгаа юм бол энэ чанаргүй боловсрол, чанаргүй хувийн дээд сургуулиудтай холбоотой гэж ингэж үзэж байгаа шүү дээ.

Тэгэхээр эдгээр зүйлүүд дээр бид онцгой анхаарах шаардлагатай байгаа юм л даа. Төрийн алба гэдэг бол улс орондоо, ард түмэндээ үйлчилдэг л ийм алба.

Тэгээд төрийн албаны нэр хүнд бол сүүлийн үед маш их унасан. Энэ юутай холбоотой вэ гэхээр мэдлэг, чадвар дутагдалтай байна. Туршлага дутуу байна. Ёс зүй муутай байна. Энэ болгон нь одоо гологдож байна л даа.

Өнөөдөр төрийн алба тогтворгүй байна гээд бид ярьж байгаа. Тийм ээ. Энэ 30 жилийн хугацаанд Монгол Улсын улсад Засгийн газар 18 удаа солигдчихсон. Тэр хэмжээгээрээ дунд, доод түвшинд бол төрийн алба ийм тогтворгүй болоод яваад ирчихсэн.

Мэдээллийн хэрэгслээр энэ төрийн албаны ажилтнуудын талаар сайн муу мэдээлэл маш их явж байгаа. Юунд ч хариу өгдөггүй.

Тэгэхээр энэ мэдээллийн хэрэгслээр гарч байгаа энэ буруу зөрүү мэдээлэл гэж байгаа бол тэндээ хариулт өгдөг ийм эрх зүйн орчинг бүрдүүлэх чиглэлээр төрийн алба ямар юм бодож байна. Энэ нэгдүгээрт хариулт өгөөч.

Хоёрдугаарт, Манай төрийн албанд хийж байгаа, яригдаж байгаа нэг юм бол нэг хүн томилогдохоороо тэрний хүн юм гэнэ лээ, тэр даргын хүн юм гэнэ лээ. Үгүй ээ, одоо ингээд нэг танил талаар бүх юмыг шийддэг.

Тэгэхээр энд олон нийт шүүмжлэлтэй хандаж байгаа юм. Тэгэхээр тодорхой албан тушаалд стандартууд, одоо сая тэр С.Цэдэндамбаагийн ярианд гарч л байна л даа. Стандартууд тогтоогоод өгчихвөл яасан юм. Тухайлбал төрийн албанд ямар ямар мэдлэг чадвартай, ямар албанд ямар мэдлэг чадвартай хүмүүс байх ёстой юм. Үүнийг нь тэр стандартыг нь тогтоогоод өгчхөж болохгүй юм уу? Төрийн албаныхнаас би асууж байна л даа.

Хоёрдугаарт, энэ үйлчилгээний стандарт гэж байгаа юм. Энэ дээр ардчилал хөгжсөн ч бай, ямар ч улсад энэ үйлчилгээний стандарт байна. Ялангуяа өндөр хөгжилтэй орнуудад. Энэ Японд бол маш тодорхой байдаг шүү дээ. Хувцастаас өгсүүлээд бүх зүйл нь стандарт. Ийм үйлчилгээний стандартыг тогтоох тийм боломж байна гэж би ингэж харж байгаа юм.

Дараагийнх нь бол энэ карьер хийх, албан тушаал ахих. Ямар албан тушаал дээр хэчнээн жил ажиллаад, тэгээд дээшээгээ албан тушаал ахиж ажиллах ёстой юм. Энэ хуульчлаад өгчхөж болдоггүй юм уу?

Хариуцлагын шалгуур гэж байгаа юм. Тодорхой хариуцлага алдсан бол тодорхой тэр өөрөө өргөдлөө бичээд гараад явчихдаг. Тэр шүүх гэдэггүй. Ийм зүйлүүдийг хийж болохгүй юм уу?

1 минутаа нэмээд.../минут дуусав/

Г.Занданшатар: Асуултад эхлээд хариулна. Тэгээд хариулт хангалтгүй бол тодруулж асууна. Хэн хариулах вэ? Хууль санаачлагч уу? Ажлын хэсэг үү? 92. Б.Идэрчулуун. Төрийн албаны зөвлөлийн гишүүн. Б.Идэрчулуун.

Б.Идэрчулуун: Б.Баттөмөр гишүүний асуултад хариулъя.

Яах вэ, ер нь бол энэ хууль хэрэгтэй байна уу, хэрэггүй байна уу гээд ярьцгааж байх шиг байна. Энэ хоёр талтай. Ёс зүйтэй төрийн албан хаагч байх асуудал бол төрд орж байгаа хүний сонгон шалгаруулалт дээр энэ ёс зүйтэй эсэхийг нягтлах асуудал байгаа. Нөгөөдөх нь болохоороо төрийн алба хааж байгаа төрийн албан хаагчид ёс зүйн асуудал гаргах юм бол яах вэ, гаргахаас яаж урьдчилан сэргийлэх вэ гэдэгт л чиглэсэн хууль гэж ойлгож байгаа.

Б.Баттөмөр гишүүн ярьж байна. Энэ Төрийн албаны хуульд чинь бидний мөрдөж байгаа 2017 онд баталсан 2019 оны 01 сарын 01-нээс мөрдөж байгаа хуульд төрд анх орох иргэнд тавих шалгуур гэдэг нь өөрөө стандарт. Шатлан дэвшихдээ ямар албан тушаалд дэс түшмэлд ямар албан хаагч байх юм, туслах түшмэлд ямар албан хаагч байх юм, эрхэлсэн түшмэлд хэдэн жил ажилласан, ямар туршлагатай хүн байх юм гээд үүнийг бас стандарт тогтоочихсон.

Тэгэхээр одоо яагаад энэ төрийн албаны нэр хүнд унаад байна вэ гэхээр одоо ил тод. Та бүхэн ч өөрсдөө мэдэж байгаа. Энэ ардаа яриа хэлээтэй төрийн албанд ордог, урьд нь орчихсон байсан улс төрийн хамгаалалттай, намын гишүүнчлэлтэй, гишүүнийхээ батлахыг аваачиж хувийн хэрэгтээ хийгээд түдгэлзэх өргөдөл хийчихсэн ийм хүмүүсийн л хийдэг асуудал. Яг үнэндээ бол. Түүнээс биш мөрөөрөө яг өөрийнхөө бор зүрхээр Монголчуудын ярьдгаар яваад төрийн албанд шаталж дэвшиж байгаа улсуудад ямар хайрцаг, хүрээнд ажиллах вэ, амьдрах вэ гэдгийг нь нарийн хуульчлаад өгчихсөн учраас эд нараас ёс зүйн зөрчил гарах нь харьцангуй бага.

Энэ хууль гарснаар төрийн албан хаагч гэдэг хүн ямар хүрээ хязгаарт ажиллах юм бэ гэдгийг энэ ёс зүйгээр нь хязгаарлаад өгч байгаа нь төрийн нэр хүнд, төр өөрөө иргэдэд хүлээн зөвшөөрөгдөх энэ нөхцөл бололцоог л бий болгох юм.

Энэ өндөр хөгжилтэй орнуудын туршлагыг харахаар эхлээд улс төрийн албан тушаалтнуудынхаа ёс зүйн асуудлыг зохицуулалт хийж байж, улс төрчид нь өөрөө ёс зүйгээрээ үлгэрлэж байж, төрийн албан хаагчид нь ёс зүй баримталдаг ийм амьд жишиг байгаа юм.

Манайд ямар хэрэгцээ шаардлага байна гэхээрээ албан тушаал хашиж байгаад дараа нь хуйгаараа шоронд явдаг. Идсэн уусан нь ингээд алба хашсаныхаа дараа илэрдэг. Ийм юмнууд өндөр байгаа учраас энд заавал бид мал туухдаа хүртэл ташуур хэрэглэдэг шүү дээ. Тэрний л нэг хэлбэр. Энэ төрийг сайн зүгт явуулах гэсэн л нэг л суурь ойлголтыг л оруулж ирж байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Энэ мал туух гэж байгаа хэрэг биш шүү. Энэ ерөөсөө. Үгээ оновчтой ашигла.

Б.Баатарзориг дарга та хэд жаахан учиртай ярина шүү. Хишгээгийн Нямбаатар. Баагаагийн Баттөмөр гишүүн тодруулж асууя. 1 минут.

Б.Баттөмөр: Тэр Төрийн албаны хуульдаа тэр стандартуудыг тогтоочихсон байдаг. Тэр стандартаа ажил хэрэг болгох хэрэгтэй.

Тэр стандартыг одоо ерөөсөө хэрэгжихгүй байгаа шүү дээ. Энэ стандартууд зөв бол хүн энэ шүүх энэ тэрээр яваад байх шаардлагагүй байгаа юм л даа. Сая Хөгжлийн банкн дээр хийсэн шалгалт дээр ямар ямар алдагдлууд, юу юу гарчихсан бэ гээд ингээд үзэхээр 4-өөс 5 хүнд хууль бус халсан гээд л шүүхийн шийдвэр гараад 200 сая төгрөг өгчихсөн байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ хууль бус халагдсан гомдлууд ер нь хэр зэрэг байдаг юм? Шүүхээр яаж шийдэгддэг юм? Та нар дээр тийм судалгаа, статистик байна уу? Үүнийг хэлж өгөөч.

Монголын төр энэ тоглоомын дүрмээ маш тодорхой болгоод тэрийгээ мөрдөж ажилладаг бол ийм зарга, ийм янз бүрийн хардлага ийм юм үүсэхгүй л дээ. Үүнийг л асуугаад байгаа юм. Энд хариулт өгөөч.

Г.Занданшатар: 93. Б.Баатарзориг дарга.

Б.Баатарзориг: Улсын Их Хурлын эрхэм гишүүдийнхээ асуултад хариулъя.

Төрийн албаны шинэтгэлийн нэг шинэ үеүд эхэлж байна. Улсын Их Хурлын даргын өрөөнд Байнгын хороодын дарга нараас чиглэлүүд авсан. Төрийн албаны шинэтгэлийн хоёр дахь, шинэ шат эхэлж байна. Үүнтэй холбоотойгоор Төрийн албаны зөвлөл, Байнгын хороод, Улсын Их Хурлын гишүүдтэй хамтраад багц хуулийн шинэчлэлтүүдийг өрнүүлъя.

Хоёрдугаарт нь, төрийн албан хаагчдын ангилал, зэрэглэлийг боловсронгуй болгоё. Сая өмнө нь Улсын Их Хурлын гишүүдийн асууж байсан асуултууд бий. Энэ төрийн албан хаагчдын тооны харилцааны асуудал, зохистой харилцааны асуудал. Яг үнэндээ төрийн алба бол тийм айхтар олон хүнтэй алба биш ээ. Төрийн захиргааны 21 мянга 135 хүн байна. Ийм цонхондуу.../минут дуусав/

Г.Занданшатар: Одоо Хишгээгийн Нямбаатар гишүүн асуулт асууна.

Хууль санаачлагчаас асуухаас өмнө би зүгээр нэг хоёр зүйлийг хэлье ээ гэж бодож байна. Энэ нэгдүгээрт өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Төрийн албаны тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлоос урьдчилан сэргийлэх тухай хууль, Захиргааны ерөнхий хууль гээд хэд хэдэн хуулиудтай давхардсан ийм зохицуулалттай ийм хуулийн төсөл, түүний үзэл баримтлалыг өнөөдөр хууль санаачлагч танилцуулж байна гэдэг үгээр би үгээ эхэлье гэж бодож байгаа юм.

Ер нь Аристотелийн үеэс “ёс зүй” гэдэг ойлголт нийгэм, улс төрийн хэллэгт нэвтэрсэн гэж сурах бичигт байдаг. Хожим нь энэ “этика” гэдэг үгнээс “этос” гэдэг үгнээс грекээр. Энэ үгнээс “морал” гэдэг үг өөрөө гарч ирсэн.

Хожмоо энэ ёс зүйн хэм хэмжээнүүд маань өөрөө тухайн ажил мэргэжлийнхээ ёс зүйн дүрэм, ажил, мэргэжлийнхээ онцлогоос шалтгаалсан ёс зүйн дүрмээр зохицуулагдаж ирсэн ийм харилцааг өнөөдөр би хуульчлах, гарцаагүй тулаад байгаа шаардлага юу вэ гэдгийг би нэгдүгээрт асууя.

Хоёрдугаарт, өнөөдөр бид 400 мянган төгрөг өгч байгаа төрийн албан хаагчийнхаа Төрийн албаны хуулиар төр хүлээсэн, ажиллах нөхцөл баталгаагаар хангаж чадах, хангах үүргээ биелүүлээгүй байгаа энэ цаг үедээ ийм давхардсан зохицуулалтыг оруулж ирэх шаардлагууд юу байгаа юм бэ гэдгийг би бас дахиад асууя.

Өнөөдөр төрийн албанд ажиллаж байгаа. Түрүүн Ц.Идэрбат гишүүн сумын Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын тухай ярьж байна лээ. Өнөөдөр хороодод ТЗ-3-аар ажиллах ийм албан тушаалтан олдохоо больсон. Мөн л адилхан цалин 400 мянган төгрөг. Шөнө өдөргүй хорооны нийгмийн ажилтан, зохион байгуулагч нар төрийн анхан шатны үйлчилгээг иргэдэд үзүүлэх ийм чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаж байгаа. Харамсалтай нь өнөөдөр 400 мянган төгрөгийн ийм цалинтай л байгаа юм.

Бид нар өнөөдөр эдийн засгаа яаж хурдан тэлж төрийн албан хаагчдийнхаа ажиллах нөхцөл, баталгаа, цалин хангамжийг нэмэгдүүлэх вэ гэдэг нэг тийм суурь зарчим руу эхэлж явж байж дараагийн ээлжид энэ тавигдах шаардлага, шалгуураа илүү өндөрсгөвөл яасан юм бэ гэсэн ийм үг хэлье.

Тэгээд би хоёр асуултад хариулт авъя. Би өнөөдөр бас Хууль зүй, дотоод хэргийн сайдын үед хууль зүйн бодлого, хуулийн хийдэл давхардлыг бид аль болох гаргахгүй байх энэ чиг үүргээ илүү их харж ажиллах ёстой.

Дээр нь өнөөдөр энэ хуулийн төслийг ингээд товчхон харахад ихэвчлэн тийм тунхагласан, декларативный хэм хэмжээ илүү их агуулсан. Энэ хуульд тавигдсан шаардлага нь өөрөө хэрэгжээгүй тохиолдолд түүнд хүлээлгэх хариуцлага, нөгөө талдаа бусад хуультай, хууль хоорондын уялдааг хангах чиглэлээр хийгдсэн ажлууд нь би дутуу дулимаг байна гэсэн ийм зүйлийг давхар хэлье.

Г.Занданшатар: Хэн хариулах вэ? Бадмаанямуугийн Бат-Эрдэнэ гишүүн. Хууль санаачлагч, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хорооны дарга. Дараа нь санал хураалттай.

Б.Бат-Эрдэнэ: Х.Нямбаатар гишүүний асуултад хариулъя.

Засгийн газраас бид хуулийн дагуу санал авахаар хүргүүлсэн. Засгийн газраас саналаа ирүүлсэн. Хэд хэдэн асуудлаар анхаарах, татгалзсан ийм санал ирсэн байгаа.

Тэгээд Засгийн газраас ирүүлсэн саналыг бид авч үзээд зарим саналыг авсан, өөрчилсөн ийм зүйл байгаа. Энэ хэлэлцэх асуудлыг нь шийдчих юм бол хэлэлцүүлгийн явцад таны хэлж байгаа давхардал, хийдэлтэй холбоотой асуудлуудыг нь авч үзэх ийм бололцоо байгаа гэж ингэж бодож байгаа.

Гэхдээ ерөнхийдөө өнөөдөр нийтлэгээрээ төрийн албан алба, төрийн албан хаагчдын ёс зүйтэй холбоотой асуудал, тулгамдаж байгаа асуудал мөн үү гэвэл мөн байгаа. Ялангуяа даргалах бүрэлдэхүүнтэй холбоотой, улс төрийн өндөр албан тушаалтнуудын авлигалтай холбоотой ийм асуудлууд байгаа юу гэвэл байгаа.

Бид энэ 30 жилийн хугацаанд эдийн засаг нэмэх нь эдийн засаг, дахиад эдийн засаг гэж явсаар байгаад тэгээд эцсийн дүндээ улс орны хөгжил ямархуу түвшинд байгаа билээ. Ард иргэдийн амьдрал байдал ямар байгаа билээ. Тэр дундаа төрийн үйлчилгээг иргэдэд чанартай, тэгш хүртээмжтэй хүргэх энэ ажил маань ямар түвшинд байгаа билээ гэдэг бол эцсийн дүндээ ямар нэгэн нөлөөгөөр улс төрийн намын хүний нөөцийн. Бүр хуулиас гадуур улс төрийн өндөр албан тушаалтнуудын нөлөөгөөр томилж байгаа томилгоонуудтай, төрийн албыг төрлийн алба болгож ирсэн энэ даргалах бүрэлдэхүүний ёс зүйтэй холбоотой асуудал дээр л бид тулаад байгаа.

Хүний хөгжлийн тухай асуудлыг энэ 30 жилийн хугацаанд хаячихсан. Үндсэн хуульдаа хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг цогцлоон байгуулна гээд тунхаглачихсан. Хүмүүнлэгийн тухай асуудлыг бүр ярихаа больсон. Хүний зүрх сэтгэлийн боловсролын тухай асуудал бүрэн хаягдсан гэж болно.

Тийм учраас Үндсэн хуулийн энэ том суурь зарчмыг хэрэгжүүлэхэд бүх шатанд ажиллаж байгаа энэ төрийн алба, ялангуяа энэ өндөр дээд түвшинд ажиллаж байгаа хүмүүсээсээ эхлээд үлгэр манлайлал үзүүлж ажиллах ийм шаардлага байгаа юм.

Тийм учраас үүнийг зөвхөн хууль санаачлагч цөөхөн хэдэн гишүүдийн санаачилсан хуулийн төсөл гэхээсээ илүү түрүүн Улсын Их Хурлын дарга хэлсэн. 2018 оноос хойш эрдэмтэн судлаачид, Төрийн албаны зөвлөл, энэ холбогдох байгууллагын санал, иргэдийн санал, мөн зөвлөлдөх энэ санал асуулга, хэлэлцүүлгийн үеэр гаргасан санал, түүнчлэн хуулийн үндэслэл, шаардлагууд, урт хугацааны хөгжлийн баримт бичиг, Засгийн газрын мөрийн хөтөлбөр, Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2019 онд хийсэн. Энэ өөрчлөлтийн үзэл санаа, энэ бүх юмнууд хууль зүйн үндэслэл нь болж байгаа гэдгийг хэлье. Баярлалаа.

Г.Занданшатар: Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Дэмжсэн дэмжээгүй гурав хүртэлх гишүүн үг хэлж болно. Үг хэлэх шиг байна уу? Хишгээгийн Нямбаатар сайдаар тасаллаа.

Эрхэм гишүүн Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн анх энэ хуулийг боловсруулж байсан. Гишүүд чимээгүй.

Ж.Сүхбаатар: Энэ хуулийн төслийг би хэлэлцэх эсэхийг нь дэмжиж байгаа.

25 жилийн өмнө Монголд бас нэг прокурорын байгууллага, хэд хэдэн байгууллагууд дүрэмтэй байсан. Төрийн хянан шалгах хороо тэр үед төрийн албан хаагч ёс зүйн байдалд хяналт тавина гээд заалттай байсан.

Тэгээд би тухайн үед 25 жилийн өмнө С.Төмөр гишүүний туслах байсан. Тэгээд энэ асуудлаар Л.Жавзмаа дарга хүсэлт тавьсан гээд анх боловсруулж байсан. 3 сар суусан. Маш хэцүү байсан.

Ер нь ёс зүйн кодекс хуульчилсан хэлбэр агуулгаараа ерөнхийдөө Америкт байгаад байгаа юм. Тэгэхдээ байгууллага болгон, салбар болгон өөр өөр л дөө. Тэгээд тэрний жишгийг барьж байгаад ингээд тухайн үеийн хуулийн байгууллагуудын дүрэм эд нарыг харж байгаад “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээний тухай” гэж нэг төсөл боловсруулж үзээд гарчигийг нь бас “Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын тухай хуулийн төсөл” гэж хийж байсан.

Тэгэхэд тэр үед асуудал үүсэж байсан л даа. “Этика” буюу “ёс зүй” гэдэг шинжлэх ухаан болохоос биш зан суртахуун, ёс суртахууны моралын тухай шинжлэх ухаан, сургааль болохоос биш хуульчилж болохгүй гэдэг яриа байсан.

Гэхдээ тухайн үед асуудал юу болсон бэ гэхээр ер нь агуулга бол, энэ ёс зүй гэдэг бол нөгөө төрийн албаны хүрээнд илүү сахилгатай холбоотой. Одоо Б.Бат-Эрдэнэ даргын Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо гэдэг чинь бид ёс зүйн асуудал гээд байгаа. Үүнийг орчин үед ёс зүйн асуудлыг тухайн төрийн албаныхны сахилгатай холбоотой асуудал авч үзээд байгаа юм.

Тэгээд энэ хууль дээр Ёс зүйн хороо, Ёс зүйн зөвлөл байгуулъя гэдэг л гол юм байх шиг байгаа юм. Мэдээж тэр дотор байгаа зохицуулалтууд дээр уянгын халилтай юмнүүдийг хасах ёстой. Мэдээж энэ бас салбар олон хуулиудын огтлолцол дээр байгаа. Заалтууд давхарддаг. Үнэн. Бэлэг дурсгал, авлигатай холбоотой, Төрийн албаны хуультай, эрүүгийн ч гэдэг юм уу.

Тэгэхээр энэ асуудал дээр гол ажиллах механизм нь нэг удаа оролдлого хийх юм нь бол энэ Ёс зүйн хороо, Ёс зүйн зөвлөлүүдийг ажиллуулъя гэдэг энэ эхний алхам бол би бас зөв байх гэж бодоод байгаа юм. Мэдээж тэр заалт дотор бас нэг жоохон тэр тунхаглалын шинж чанартай гээд бас Х.Нямбаатар сайд хэлж байна. Бас тийм юмнууд бий байна л даа.

Ер нь зарим заалт нь тунхаглалын шинж чанартай байдаг. Гэхдээ жоохон прагматик болгоод сахилга талаас нь жоохон явмаар байгаа юм. Угаасаа ногдуулах шийтгэх нь ёс зүйн хариуцлагууд нь сахилгын шийтгэл байгаа шүү дээ. Сахилгын шийтгэл байгаа.

Тэгэхээр бид энэ Ёс зүйн хороо, Ёс зүйн зөвлөл гэдгийг Сахилгын хороо, Сахилгын зөвлөл гэж ойлгох юм бол илүү зөв ойлгогдоно. Сахилгын шийтгэл ногдуулах этгээд гэж ойлговол.

Энэ утгаар нь бас авч үзээд. Түүнээс “ёс зүй” гэдэг үгийг нь хөөцөлдөх юм бол зан суртахуун, ёс суртахуун гээд хуульчилдаггүй харилцаатай илүү холбоотой гэдэг нь үнэн. Гэхдээ хуулийн хүрээнд бас оруулж ирдэг зохицуулалтын хэлбэрүүд дэлхий дахинд байгаад байна л даа. Одоо Америкийн Конгрессын гишүүд жоохон хүүхдүүд шиг. 20 жилийн өмнө би очоод танилцаж л байсан хүн л дээ.

Тэгэхэд эндээ ингээд янз бүрийн бэлэг дурсгал, хүнтэй хүлээн авалтад орвол нөгөө зөвлөгөө авах ёс зүйн комисс руу утасдаж асуудаг байхгүй юу. Одоо би ингэж болох уу, үгүй юу гэдэг.

Тэгээд эндээ бидний хуучин сурагчийн үеийн юм шиг ийм юутай. Нэг ийм энгэрийн юмандаа хийж явдаг юмтай. Тэрүүгээрээ тэнд нь Ёс зүйн комиссоос зөвлөгөө, лавлагаа авдаг, утсаар мэдэгддэг. Гомдол, мэдүүлэг. Ийм юм хийж болохгүй гэдгийг нь тэрийг нь ард нь биччихсэн байгаа. Жоохон хүүхэд шиг тийм юм хүртэл аваад явдаг байхгүй юу.

Энэ бол илүү тийм. Би ойлгохдоо илүү ёс зүйн асуудлыг хуульчилдаг хэлбэр нь илүү зүгээр англо-саксоны тал руугаа байгаа. Тэгэхдээ сүүлийн үед

яхах вэ дорнын орнууд угаасаа заншлын хэм хэмжээ хүчтэй учраас хуулиас дутахгүй үйлчилдэг учраас парламентын төрийн албаны заншилд байж байгаа байх.

Зүгээр их зөв огтлолцож, зөв томьёолохгүй бол мэдээж хэрэг жоохон юу гэдэг юм онигоонд оруулах гэдэг юм уу, шүүмжлэх, шоолох тийм байдал гарна.

Тийм учраас хамгийн түвэгтэй асуудал нь бол би томьёолол гэдгийг нь ойлгож байна. Томьёолол бол хэцүү, амаргүй. Гэхдээ одоо ингээд манай гишүүд оруулаад ирчихсэн энэ асуудал яригдаж байсан. Би 25 жилийн өмнө энэ төслийг нь анх хийж байсан хүн. Өнөөдөр болохгүй гэж хэлээд яах вэ. 1999 онд Ц.Шаравдорж, С.Төмөр багш, С.Оюун гишүүн гурав үүнийг өргөн бариад. Одоо архивт бий л дээ.

Тэгээд энэ хуулийн миний тэр 25 жилийн өмнө хийж байсан хуулийн төслийн суурин дээр ер нь бүгд явж байгаа. Энэ ёс зүйн дүрмүүд. Тэгээд би тэр үед яалт ч байхгүй тэр асуудалтай тулгарч байсан хүн л дээ. Тухайн үед яах вэ гишүүний туслах байсан учраас муу хийвэл ажилгүй болчих учраас, багшдаа тоогдохын тулд бүх хүчээ дайчилж байсан.

Тийм учраас нэлээн материал уншсан. Тийм. Тэгээд тэр үед яах вэ Б.Энхбаяр гишүүн оюутан байж байгаад надтай холбогдож ийм ёс зүйн талаар ном бичиж байсан үе л дээ. Тэгээд өөрөө сая энэ дээр нөгөө талаас нь хэлж байна.

Ёс зүйн дүрмүүд дээр илүү зохицуулъя гээд байх шиг байна. Яах вэ, ер нь дүрмүүд бол бүх чиглэлд манайд бий болоод хэрэгжиж явж байгаа. Нэг их сайн хэрэгжиж байна уу гэвэл хэцүү байгаа. Одоо тэр хуучны юу руу аваачиж байна вэ гэхээр Төрийн хянах хорооны үеийнх шиг Төрийн албаны зөвлөл дээр энд аваачъя.

Тэгэхээр сахилгын шийтгэл Төрийн албаны зөвлөл болон салбар зөвлөлүүдийн гүйцэтгэх үүрэг нэмэгдэх нь л дээ. Зүгээр энэ дээр бид яах вэ үр дагаврыг нь сайн бодоцгооё, ярья.

Г.Занданшатар: Тийм. Ж.Сүхбаатар гишүүний боловсруулсан төслийг С.Төмөр гуай 2000-2004 оны парламентад өргөн мэдүүлж байсан юм билээ. Төсөл нь байлаа.

Одоо Баттөмөрийн Энхбаяр гишүүн.

Б.Энхбаяр: Би энэ Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийг дэмжихгүй үг хэлэх гэж байгаа юм.

Тэгэхээр би хамгийн ёс зүйгүй этгээд гэж цоллогдохоо мэдэж байна л даа. Ёс зүйтэй хүмүүс нь дэмжинэ. Ёс зүйгүй хүмүүс нь дэмжихгүй юу болж таарах л байх л даа. Улс төр явах байх.

Тэгээд яагаад дэмжихгүй байгаа вэ гэж. Энд яг шинэ юм нь юу байна. Одоо Монгол Улсад үйлчилж байгаа 400 гаруй хуульд байгаа бүх л юм энд байна. Угаасаа. Үндсэн хуулиа биелүүлэх ёстой гэж, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх ёстой. Архи ууж болохгүй. Бүх хуульд байгаа шүү дээ.

Энд юу нь нэмчихсэн юм бэ гээд би сая бүр ингээд тулгаад л уншаад хараад байлаа. Жишээлбэл, Төрийн албаны хуульд ард түмэндээ үйлчилнэ гэдэг үүрэг байгаа. Энэ ёс зүйн хууль дээр юу болж байна вэ гэхээр ард түмэндээ чин сэтгэлээсээ үйлчилнэ гэж байгаа байхгүй юу. Ийм л юм нэмэгдэж байна.

Сэтгэл зүрх чинь хуульчлагддаггүй юм. Баригддаггүй юм. Хайр сэтгэлийг хуульчилж чаддаггүй юм. Хүн төрөлхтөн хэзээ ч хайр сэтгэлийг хуульчилж байгаагүй. Хүний сэтгэл зүрхийг хуульчлах гээд байгаа байхгүй юу.

Одоо ингэж байгаа шүү дээ. Албаны харилцааны хэвийн уур амьсгалыг алдагдуулахгүй байх гэж. Үүнийг зөрчвөл ингээд хууль зөрчсөн гээд. Үгүй ээ энэ парламентад байна шүү дээ хэвийн уур амьсгал байтугай хэвийн бус байх ёстой. Бүр. Хэрэлдсэн ч яадаг юм. Зодолдсон ч яадаг юм. Ер нь.

Тодорхой ийм зарчмын асуудал дээр. Тэгэнгүүт ингээд хэвийн уур амьсгал алдагдуулж болохгүй ээ гэж байгаа юм. Би түрүүн асуулаа шүү дээ. Хов базаж болох юм уу, үгүй юм уу. Ийм юм хуульчлагддаггүй байхгүй юу даа.

Төрийн албан хаагчид чинь энэ чинь бүр дарамт болно. Ингэж байгаа байхгүй юу. Төрийн албан хаагчийн хувьд иргэний эрх, эрх чөлөөний хязгаарлалтыг эсэргүүцэх үг үйлдэл, зан байдлаар илэрхийлж болохгүй гэж байгаа юм.

Энэ төрийн албан хаагчид чинь юмны үнэ өслөө гэж төр засагтаа бухимдаж болохгүй юу. Мушийж болохгүй юу. Эсэргүүцлээ илэрхийлж болохгүй юу. Юмны үнэ өслөө гэдэг одоо тийм постны доор уурласан тийм эможи ашиглаж болохгүй юу. Энэ чинь эсрэгээрээ өөр асуудал руу ороод байна шүү дээ. Төрийн албан хаагчаа бүр дарамтлах.

Тэгээд гол яг юу юм чинь юм бэ. Одоо би нэг л заалт хэлье. Төрийн албаны үйл ажиллагаанд итгэл алдах үйлдэл гаргахаас зайлсхийх гэж. Энэ яг ямар үйлдлийг ойлгох вэ. Ер нь. Үүнийг ер нь хэн хэмжих юм бэ. Хэн шүүх юм. Манай сая одоо энэ танхимд нэлээн ярьж байгаа. Төрийн албаны зөвлөлийн гишүүн Б.Идэрчулуун бол шүүчих юм шиг байна. Энэ болохгүй бүтэхгүй байгаа юм бол энэ Их Хурлын гишүүдээс болж байгаа гэж удаа дараа хэллээ шүү дээ. Олон юман дээр.

Албан тушаалын томилгоонд нөлөөлдөг гэж хариуцлагатай мэдэгдэл хийлээ. Энэ албан тушаалын гэмт хэргийн тухай ярьж байна шүү дээ. Их Хурлын гишүүн албан тушаалын байдлаа ашиглаад хууль бус нөлөөлөл үзүүлсэн тухай ярьж байгаа бол энэ Авлигатай тэмцэх газар хандах хэрэгтэй. Энэ танхимаас одоо гараад.

Түүнээс биш энэ зүгээр ингээд улс төржиж байгаа асуудалд би мэдэхгүй байна.

Одоо саяын заалтыг хэн тайлбарлаж, үүнийг ямар хэмжүүрээр хэмжих юм. Ер нь манай Монголын болж бүтэхгүй байгаа юм энэ ёс зүй хууль байхгүйгээс л болсон юм байна л даа. Яг энэ хуульд нь шинэ юм юу байгаа юм бэ гэхээр бүх төрийн байгууллагын дэргэд Ёс зүйн зөвлөл байгуулна л гэж байна. Тэр дотроо Төрийн албаны зөвлөл дэргэдээ Ёс зүйн зөвлөл байгуулж байгаад улс төрийн албан тушаалтнуудыг хянана гэнэ. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарын ёс зүйн асуудлыг Төрийн албаны зөвлөл хянадаг байгууллага биш. Энэ чинь Үндсэн хуульд заачихсан. Дээр нь Ерөнхий сайд томилдог, иргэдийн Хуралд нэр дэвшүүлдэг улс төрийн хариуцлага тооцдог албан тушаал.

Энд Төрийн албаны зөвлөлд оролцох гэж байна шүү дээ. Энэ Үндсэн хуультай нийцэхгүй. Яагаад гэхээр Төрийн албаны зөвлөлийн Ёс зүйн хороо нь огцруулах дүгнэлт гаргана гэж байна шүү дээ. Энэ улс төрийн томилгоонд оролцож яах гэж байгаа юм. Та нар. Одоо байгаа төрийн жинхэнэ албан хаагчдынхаа асуудлыг шийдэж чадахгүй байж. Одоо энэ хууль гараад төрийн албан хаагчдын ёс зүйг энэ ард сууж байгаа хэдэн хүн хянана. Тэр дотроо бүр улс төрийн албан хаагчдынхыг яриад байгаа шүү. Эд нар. Энэ бол өөрөө нөгөө зарчим, хэм хэмжээ, бусад юмнуудтайгаа нийцэхгүй байна.

Тийм учраас би дэмжихгүй гэж хэлэх гэж байгаа юм.

Г.Занданшатар: Зочид танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Буланы Бейсений урилгаар Анагаах ухааны дээд сургуулийн 1988 оны төгсөгчдийн төлөөлөл эмч нар Улсын Их Хурлын үйл ажиллагаа, Төрийн ордонтой танилцаж байна.

Эргэн учирсан энэ мөчүүдээ инээд баяр хөөр дурсамжаар дүүрэн угтаж байгаа төгсөгчдөдөө, 1988 оны төгсөгчдөдөө Улсын Их Хурлын гишүүдийн өмнөөс халуун баяр хүргээд 33 эмч Төрийн ордон, чуулганы үйл ажиллагаатай танилцаж байгаа юм байна.

Энэ ардын эмч 1 байна, гавьяат эмч 20 байна, Төрийн шагналт 1 байна, Эрүүлийг хамгаалахын гавьяат ажилтан 3 байна, Эрүүл мэндийн дэд сайд 1 байна, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга 2, эрүүл мэндийн газрын дарга 5, нэгдсэн эмнэлгийн даргаар ажиллаж байсан 15, хурандаа цолтой 3 хүн байна. /алга ташив/

Манай Б.Бейсений гишүүний төгсөгчид шинжлэх ухааны доктор, профессор 5, клиникийн профессор 27 төрсөн байна.

Мөн өнөөдөр төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүдийн эрүүл мэндийг хариуцаж эмчээр нь ажиллаж байсан Улсын Их Хурлын эмч, хүний гавьяат эмч Пүрэвдаваагийн Долгормаа төрсөн өдрийн баярын мэнд хүргэе. /алга ташив/

Ингээд П.Долгормаа эмчдээ төрсөн өдрийн баярын мэнд хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхан бүхнийг үе үеийн гишүүдийн өмнөөс хүсэн ерөөе.

Содномын Чинзориг гишүүн алга байна. Хишгээгийн Нямбаатар гишүүн. Ботьчихлоо.

Гишүүд үг хэлж дууслаа. Одоо санал хураалт явуулна. Н.Энхболд дарга аа, санал хураалт. Н.Энхболд гишүүн ээ. Санал хураалт. Саналаа өгчхөөд явчих.

Тэгээд энэ хуулийг анх санаачилж байсан Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн маань эсэргүүцэж байгаа, Б.Энхбаяр гишүүн ч гэсэн хоёулаа С.Төмөр гуайн шавь нар. С.Төмөр гуай үүнийг хуульчлах ёстой гэж 2000 онд үзэж. Харин одоо тэр концепцынхоо дагуу хэлэлцэх эсэхийг нь шийдчихээд ажлын хэсэгт орж үүнийгээ сайжруулах хэрэгтэй.

Б.Бейсен гишүүн саналаа өгчихөөд яв. Та хэд хүлээж бай. Б.Бейсен гишүүн саналаа өгчихөөд явна. Тэгээд энэ Японд ёс зүйн хууль байна. Германд сахилга хариуцлагын тухай хууль хууль байна. Төрийн албаны. Ингээд доторх юмыг нь сайн янзлах хэрэгтэй.

Тэгээд янз янзын юмнууд байвал хэлэлцэх эсэхийг нь шийдэж байгаад үүнийг сайн тухтай янзлах ёстой гэж үзэж байгаа. Ингээд санал хураалтад бэлд. М.Оюунчимэг гишүүн суугаарай. Санал хураалт.

Энэ бүртгэлийн санал хураалт явуулж байгаа. Дараа нь Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна. Өнөөдрийн анхны санал хураалт учраас бүртгэл техникийн. Энэ бүртгэлд ороогүй гишүүдийг дуудъя.

Байнгын хорооны саналаар Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Хоёр. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Гурав. Захиргааны ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай.

Дөрөв. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай.

Тав. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай.

Зургаа. Авлигын эсрэг хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна. Санал хураалт.

27 гишүүн дэмжиж, 57.4 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэнд тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороонд шилжүүлж байна.

Дараагийн асуудалд орно.